



Гүйцэтгэлийн аудитын тайлан

**ТӨРӨӨС БҮХ НИЙТИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛ ОЛГОХ БОДЛОГО ХАНГАЛТГҮЙ
ХЭРЭГЖИЖ БАЙНА**

2021 оны 3 дугаар сар

**АУДИТЫН СЭДЭВ: ТӨРӨӨС БҮХ НИЙТИЙН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОЖ БУЙ
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ҮР ДҮН**



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

Г Аудитын тайлан баталгаажуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.1.10, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д хийсэн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Байнгын хороо, Боловсрол, Шинжлэх ухааны яам, Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлэхийг Аудитын гуравдугаар газар /Д.Энхболд/-т даалгасугай.


3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд /Л.Энх-Амгалан/, Сангийн сайд /Б.Жавхлан/, Барилга, хот байгуулалтын сайд /Б.Мөнхбаатар/ нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын гуравдугаар газар /Д.Энхболд/-т даалгасугай.

5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /ахлах аудитор Б.Хишигтогтох/-т үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны
03 дугаар сарын 02 ны өдрийн 4/23 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Төлбөр, зөрчлийн товч утга	Төлбөр, зөрчил хариуцах	
		Байгууллага	Албан тушаалтан
1	БШУЯ нь дангаар болон бусад яамтай хамтран Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд заасан 1 дүрэм, 15 журам, 6 стандарт, норматив, 2 хөтөлбөрийг баталж мөрдүүлээгүй, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй	БШУЯ	Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатар
2	Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй нийслэлийн Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 112 дугаар сургууль, Бэтүб шашны сургуулиуд зориулалтын бус барилга байгууламжтай, суралцагчдын дүнгийн үнэлгээ улсын дунджаас доогуур байна,	БШУЯ	Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатар
3	Төрийн өмчийн зарим сургууль ашиглалтын хугацаа дууссан, Мэргэжлийн хяналтын байгууллагаас ашиглалтын үйл ажиллагаа явуулахыг хориглосон, зориулалтын бус, их засвар хийгдээгүй байранд сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа нь суралцагчийн эрүүл, аюулгүй орчинд сөргөөр нөлөөлж, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангаагүй байна	БШУЯ	Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатар
Нийт дүн			

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгт, дүрслэл, хавсралтын товъёо	4-5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6
БҮЛЭГ 1. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ШИНЭЧЛЭХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАМААР ХАМРАН СУРГАЛТ, СУРГАЛТЫН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	7-32
Мөрдөгдөж буй хууль, дүрэм журам, норм норматив өнөөгийн шаардлагад бүрэн нийцээгүй, зарим эрх зүйн зохицуулалт харилцан уялдаагүй байна	7-13
Салбарын хүний нөөцийн нэгдсэн бодлого, төлөвлөгөөгүй, хамран сургалт тэгш, хүртээмжтэй бус, суралцагчийн сурах хэрэгцээнд дэмжлэг үзүүлэхүйц материаллаг орчин нөхцөл бүрдээгүй байна	13-27
Ерөнхий боловсролын салбарын төсвийн төлөвлөлт бодитой бус, тусгай зориулалтын шилжүүлгийн гүйцэтгэлд тавих хяналт сул байна	27-32
БҮЛЭГ 2. СУРГАЛТЫН ЧАНАР, СУРАГЧДЫН МЭДЛЭГЭЭ ХЭРЭГЛЭХ ЧАДВАР ХАНГАЛТГҮЙ, СУРГУУЛИЙН БОЛОН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨРҮҮ ӨНДӨР БАЙНА	33-52
Сургалтын хөтөлбөр, сурах бичиг, багшийн хөгжил, үнэлгээний журмын өөрчлөлтийг иж бүрэн, харилцан уялдаатай байдлаар хэрэгжүүлээгүй байна	33-49
Салбарын дотоод болон хөндлөнгийн хяналт үр нөлөө багатай байна	49-52
Холбогдох байгууллагын санал:	53-59
Саналд өгсөн тайлбар:	60-61
ДҮГНЭЛТ:	62
ЗӨВЛӨМЖ:	63-64
ХАВСРАЛТУУД:	65-74

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХБ	Азийн хөгжлийн банк
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БМДИ	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
БНБД	Барилгын норм ба дүрэм
БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БҮТ	Боловсролын үнэлгээний төв
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БУМС	Боловсролын удирдлага, мэдээллийн систем
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗТБХБС	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын байгуулалтын сайд
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУБИС	Монгол Улсын Боловсролын их сургууль
МУИС	Монгол Улсын Их сургууль
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НБГ	Нийслэлийн боловсролын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НЗД	Нийслэлийн засаг дарга
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НХХС	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд
ОХУ	Оросын Холбооны Улс
ОНХС	Орон нутгийг хөгжүүлэх сан
СБД	Сүхбаатар дүүрэг
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
ТБӨ	Төрийн бус өмч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШУ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ХШУДАГ	Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар
ЧҮС	Чанарын үнэлгээний судалгаа
ШУТИС	Шинжлэх Ухааны Техникийн Их сургууль
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
ЭСЯ	Элчин сайдын яам
PISA	Programme for International Student Assessment / Боловсролын олон улсын чанарын үнэлгээ

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Боловсролын салбарын хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсон тоо	7
Хүснэгт 2	“Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д тусгагдсан зорилт	11
Хүснэгт 3	“Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	11
Хүснэгт 4	III ээлжид хичээллэсэн сургууль, бүлэг, хамрагдсан хүүхдийн тоо	14
Хүснэгт 5	Зөвлөмжийн дагуу байх хүчин чадал	18
Хүснэгт 6	ЕБС-ийн байвал зохих хүчин чадал, одоогийн байгаа хүчин чадал харьцуулалт /2020 оны байдлаар/	18
Хүснэгт 7	Сургуулийн насны хүүхдийн 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо	18
Хүснэгт 8	Шинээр ашиглалтад орсон сургуульд нийлүүлсэн сандал /суудлын тоогоор/	22
Хүснэгт 9	Нормативт хүчин чадлыг бодит бус илэрхийлсэн сургууль	22
Хүснэгт 10	ЕБС-ийн боловсон хүчин /2017-2020 оны хичээлийн жил/	23
Хүснэгт 11	70-100 тэтгэлэгтэйгээр төгссөн төгсөгчдийн тоо, санхүүжилтийн дүн /2017-2019 он/	25
Хүснэгт 12	Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад хамрагдсан багш нарын тоон мэдээлэл /2017-2019 он/	26
Хүснэгт 13	Багш нарын төгссөн их, дээд сургууль	26
Хүснэгт 14	Төсвийн харьцуулалт 2020 он /сая төгрөг/	29
Хүснэгт 15	Цалингийн харьцуулалт	31
Хүснэгт 16	Үдийн цай хөтөлбөр, дотуур байрны хоолны зарцуулалт	32
Хүснэгт 17	Сургалтын төлөвлөгөөний харьцуулалт	35
Хүснэгт 18	Олон улсын хөтөлбөртэй төрийн өмчийн сургуулийн сурагчдын тоо, бүлэг	37
Хүснэгт 19	Сургалтын хэв шинж, хөтөлбөр, төлөвлөгөө харьцуулалт	39
Хүснэгт 20	Төрийн бус сургуулийн тусгай зөвшөөрөл болон үйл ажиллагаа явуулж буй хэв шинж	40
Хүснэгт 21	Боловсролын үнэлгээний талаар хууль, хөтөлбөрийн холбогдох заалтууд	42
Хүснэгт 22	ЕБС-ийн суралцагчийг үнэлэх үнэлгээ	42
Хүснэгт 23	2016-2020 онуудад боловсролын чанарын үнэлгээнд хамрагдсан суралцагчдын тоо, нийт хамрагдагсдын тоо: /эзлэх хувиар/	43
Хүснэгт 24	XII ангийн улсын шалгалтын үнэлгээний харьцуулалт	46
Хүснэгт 25	ЭЕШ-ын шалгалтын дүн ИДС-ын босго онооны харьцуулалт /2018-2020/	46
Хүснэгт 26	ЭЕШ-ын шалгуулагчийн тоон харьцуулалт	47
Хүснэгт 27	БҮТ-с зохион байгуулсан ЧҮС-ний хичээлийн агуулга /он тус бүрээр/	48

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Хүмүүн цогцолбор бага сургуулийн анги дүүргэлт, ширээ хоорондын зай	15

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ТБӨ-ийн сургуулиудын Улсын бүртгэлд бүртгэгдсэн байдал	10
Дүрслэл 2	Сургуулийн тоо өмчийн хэлбэр, байршлаар	13
Дүрслэл 3	Хамран сургалтын хувийн жин	13
Дүрслэл 4	Хамран сургалт /боловсролын ангиллаар/	13
Дүрслэл 5	Хамран сургалт, хүчин чадлын харьцуулалт	14
Дүрслэл 6	Хүчин чадлаас хэтэрч хамрагдсан хүүхдийн тоо	14
Дүрслэл 7	Хүчин чадалдаа хүрээгүй суудлын тоо	16
Дүрслэл 8	ТБӨ-ийн сургуулийн нийт хүчин чадал ба ашиглалтгүй суудлын харьцуулалт	16
Дүрслэл 9	Төрийн өмчийн ЕБС-ийн хичээлийн байрны барилгын насжилт	19
Дүрслэл 10	Үндсэн багш насны бүлгээр	23
Дүрслэл 11	Мэргэжлийн зэрэг	23
Дүрслэл 12	Тэтгэлгээр суралцагчдын харьцуулалт	24
Дүрслэл 13	Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ /мянган төгрөг/ /Нийслэлийн бага ангийн хувьд/	28
Дүрслэл 14	Төсвийн төсөлд хүргүүлсэн санал /тэрбум төгрөг/	28
Дүрслэл 15	Тусгай зориулалтын шилжүүлгийн зарцуулалт /зардлын зүйлээр/	30
Дүрслэл 16	Сургалтын цөм /сайжруулсан/ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй хүндрэл бэрхшээл	36
Дүрслэл 17	Сурах бичгийн агуулга сургалтын хөтөлбөртэй бүрэн уялдаж буй байдал	40
Дүрслэл 18	Сургалтын материал, судлагдахуунаар /эзлэх хувь/	41
Дүрслэл 19	Суралцагчдын сурлагын амжилтын үзүүлэлт /Гүйцэтгэлийн дундаж/	44
Дүрслэл 20	Сурлагын амжилт /2016-2018 он/	44
Дүрслэл 21	Улсын хэмжээнд бага боловсролын хамран сургалт хамгийн өндөр сургуулиудын чанарын үнэлгээний дүнгийн харьцуулалт /Гүйцэтгэлийн хувь/	44
Дүрслэл 22	2019 оны улсын шалгалтын харьцуулалт /112-р сургууль/	45
Дүрслэл 23	2019 оны ЭЕШ-ын харьцуулалт /112-р сургууль/	45
Дүрслэл 24	XII ангийн суралцагчдын сурлагын үнэлгээний харьцуулалт /2018 он/	45
Дүрслэл 25	XII ангийн сурагчдын хичээл сонголт, ЭЕШ өгсөн тоон харьцуулалт /2017-2019 оны нийлбэр дүнгээр/	47
Дүрслэл 26	ЭЕШ-ын хичээл сонголтын тоо /хичээлийн эзлэх хувь/	47
Дүрслэл 27	Сургалтын чанарын нөлөөллийн талаар судалгааны дүн	49
Дүрслэл 28	Сургуулийн хэмжээнд сургалтын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, үнэлэх ажил хийгддэг эсэх судалгааны дүн	49

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Боловсролын тухай хууль бусад хуулиудын харилцан уялдаа	65
Хавсралт 2	Холбогдох хуульд батлахаар заасан дүрэм, журам	66
Хавсралт 3	Нийт хамран сургалтын хувь, бусад улс оронтой харьцуулалт /хувиар/	67
Хавсралт 4	Гадаадын хөрөнгө оруулалттай ТБӨ-ийн сургууль	67
Хавсралт 5	Сургуулийн тусгай зөвшөөрлөөр олгосон суудлын ашиглалтын судалгаа, хүчин чадлаас давсан болон ашиглалтгүй байгаа суудлын тоо, аймгаар	68
Хавсралт 6	ЕБС-ийн хичээлийн байрны тоон үзүүлэлт	68
Хавсралт 7	73-108 жилийн насжилттай сургуулийн барилгын жагсаалт	68
Хавсралт 8	Анги дүүргэлт илүү болон хангалтгүй байгаа суудлын тоо /аймгаар/	69-70
Хавсралт 9	Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ (мян.төгрөг)	71
Хавсралт 10	ТБӨ-ийн ЕБС-ийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ (мян.төгрөг)	71
Хавсралт 11	ТБӨ-ийн сургуулиудад олгосон санхүүжилт /сая төгрөг/	72
Хавсралт 12	Боловсролын салбарт батлагдсан төсөв /сая төгрөг/	72
Хавсралт 13	Багш бэлтгэж буй их, дээд сургуулиуд	72-73
Хавсралт 14	БУМС-д бүртгэгдсэн хичээл сонголтын нэгтгэл	74

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх Аудитын зорилт Аудитын хамарсан хүрээ Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт Аудитын бүрэлдэхүүн, хугацаа Хүндрэл бэрхшээл	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөөний дагуу “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 6 дугаар зүйлийн 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд хийв. “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: ➤ Ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх; ➤ Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт хангагдаж байгаа эсэх. Аудитыг БШУЯ, Сангийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймаг, нийслэлийн ЗДТГ, Боловсролын газар, төрийн болон хувийн өмчийн сургуулиудын 2016-2018 оны үйл ажиллагааг /сүүлийн 3 хичээлийн жил/ хамруулан гүйцэтгэлээ Аудитыг гүйцэтгэхэд Төрийн аудитын стандарт, АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, бусад шаардлагатай баримт материал, сүүлийн 3-5 жилийн байдлаарх үндсэн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав. Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор С.Оюунгэрэл, Д.Энхболд нар удирдаж, аудитын менежер Б.Саруул чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Хишигтогтох, аудитор Э.Уянга, Ж.Мөнхбилгүүн, Э.Мөнхмандах, Б.Буянхишиг нар болон орон нутаг дах төрийн аудитын газрын аудиторууд хамтран гүйцэтгэв. Аудитын төлөвлөгөөг 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор батлуулж, талбарын ажлыг 2020 оны 9 дүгээр сарын 21-ний өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хүртэл хугацаанд гүйцэтгэж, орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагуудаас ирүүлсэн аудитын тайлан, судалгааг 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хүлээн авч нэгтгэсэн бөгөөд аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталгаажуулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв. Аудитын талбарын ажлыг 2020 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлүүлэхээр төлөвлөсөн боловч БШУС-ын 2020 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 1а/691 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтээс шалтгаалан аудитын нээлтийг 2020 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр эхлүүлсэн болно. Мөн талбарын ажлын явцад Ковид-19 цар тахлын улмаас Улсын онцгой комиссоос улс даяар Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт удаа дараа шилжүүлсэнтэй холбоотой аудитыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрт заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүй байлаа.
---	--

БҮЛЭГ 1. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ШИНЭЧЛЭХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАМААР ХАМРАН СУРГАЛТ, СУРГАЛТЫН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Мөрдөгдөж буй хууль, дүрэм журам, норм норматив өнөөгийн шаардлагад бүрэн нийцээгүй, зарим эрх зүйн зохицуулалт харилцан уялдаагүй байна

1.1 Ерөнхий боловсрол олгохтой холбоотой үйл ажиллагааг Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

1.2 Боловсролын тухай хуулиуд тус тусдаа батлагдаж ирсэн бөгөөд 2002 оноос өнөөг хүртэлх хугацаанд холбогдох хуулиуд шинэчлэн батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон, боловсролын салбар 12 жилийн сургалтад шилжсэн, Цөм хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн зэргээс дараах байдлаар нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Хүснэгт 1. Боловсролын салбарын хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсон тоо

№	Хуулийн нэр	Батлагдсан огноо	Нэмэлт, өөрчлөлт орсон тоо
1	Боловсролын тухай хууль	2002-05-03	26
2	Бага, дунд боловсролын тухай хууль	2002-05-03	13
3	Дээд боловсролын тухай	2002-05-03	10
4	Сургуулийн өмнөх боловсролын тухай	2008-05-23	6
5	Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай	2011-07-09	6
6	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай	2019-05-30	1
7	Багшийн хөгжлийг дэмжих хууль	2018-06-27	-

Эх сурвалж: <http://legalinfo.mn>

1.3 Боловсролын тухай хуульд 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн 11.2-т заасан боловсролын стандарт хэсгээс “суралцагчийн зайлшгүй эзэмшсэн байвал зохих боловсролын агуулгын түвшин, түүний үнэлгээ” хэсгийг хасаж, “Боловсролын стандарт нь багшийн мэргэжлийн түвшин, сургалтын орчинд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлно” болгон өөрчлөн найруулсан боловч тус хуулийн дараах заалтууд болон Бага, дунд боловсролын тухай хуулийн холбогдох заалтуудыг нийцүүлж шинэчлээгүй байна. Тухайлбал,

Боловсролын тухай хууль

- 3.1.4. “боловсролын түвшин” гэж тухайн шатанд эзэмшвэл зохих сургуулийн өмнөх, **бага, дунд, дээд боловсролын агуулгын стандартаар** тогтоосон мэдлэгийн хэмжээг;
- 7.2. **Албан боловсролын агуулга, стандартыг** хуульд заасан журмын дагуу тогтооно.
Бага, дунд боловсролын тухай хууль
9 дүгээр зүйл “Бага, дунд боловсролын стандартын хэрэгжилт”
- 9.1. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшил, сурлагын ахиц, өөрчлөлтийг сургалтын явцад болон анги дэвших, сургууль төгсөхөд нь шалган үнэлж **боловсролын стандартын хэрэгжилтийг** дүгнэнэ.
- 9.2. **Боловсролын стандартын хэрэгжилтийг** багшийн үнэлгээ, сургуулийн шалгалтын болон хөндлөнгийн үнэлгээний байгууллагын дүнгээр тодорхойлно.
- 12.1. Ерөнхий боловсролын сургууль нь **боловсролын стандартаар** тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага мөн.
- 14.3. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан цөм хөтөлбөрийн дагуу явуулж байгаа бүх нийтийн ерөнхий **боловсролын стандартаас** давсан агуулга бүхий сургалтыг гүнзгийрүүлсэн сургалт гэнэ.
- 14.4. Төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургууль нь суралцагчид **бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартын** агуулгыг заавал эзэмшүүлнэ.
- 14.9. Гүнзгийрүүлсэн сургалттай сургуульд бүх нийтийн ерөнхий **боловсролын стандартаас** давсан агуулгаар явуулсан сургалтын нэмэгдэл зардлын хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан жишгийг үндэслэн сургуулийн зөвлөл тогтооно. Сургалтын нэмэгдэл зардлыг эцэг, эх, асран хамгаалагчаас гаргуулж болно.

1.4 Зарим хуулийг шинэчлэн батлахдаа Боловсролын тухай хуульд зохих нэмэлт өөрчлөлтийг оруулаагүйгээс зарим харилцаа уялдаагүй, зохицуулалтгүй болж хууль хоорондын хийдэл үүсгэсэн байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 1-с үзнэ үү/Тухайлбал:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр батлагдсантай холбоотойгоор Боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалт, 43 дугаар зүйлийн 43.1.8 дахь заалтын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” гэснийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” гэж

өөрчилсөн байна. Гэвч Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн нэр томъёоны тодорхойлолт нь хүчингүй болсон хуулийн зүйл, заалтаас зөрүүтэй төдийгүй нэмэгдэл цалинтай холбоотой зохицуулалт тусгаагүй;

- Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д "Орой, эчнээ, албан бус хэлбэрээр иргэдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ" гэж заасан хэдий ч 2016 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн "Албан сургалт нь өдөр, орой, эчнээ, экстернат зэрэг хэлбэртэй байж болно" гэсэн хэсгийг хассанаар албан сургалтын хэлбэр тодорхой зохицуулалтгүй болсон;
- Боловсролын тухай хуульд оруулсан 2016 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр 48 дугаар зүйлийн 48.3-д "сум, дүүргийн Засаг дарга, боловсролын хяналтын улсын байцаагч" гэснийг хассанаар боловсролын салбарт мэргэжлийн тавих хяналт субъект тодорхойгүй болсон;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтад нэмэлт өөрчлөлт оруулаагүй;
- Төрийн албаны тухай хуулийг 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр шинэчлэн баталсан холбоотой Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4, 43.6, 43.7 дугаар заалтыг шинэчлэн батлаагүй;
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр батлагдсантай холбогдуулан Боловсролын тухай хуулийн 11.3¹ дахь заалт хүчингүй болсон тул тус хуульд заасан боловсролын стандартыг батлах харилцаа зохицуулалт тодорхойгүй болсон.

1.5 Боловсролын тухай болон Бага, дунд боловсролын тухай хууль, ерөнхий боловсролын салбарт мөрдөгдөж буй дүрэм, журамд шашны сургууль² болон их, дээд сургуулийн харьяа ахлах сургуулийн үйл ажиллагааны талаар зохицуулалт хангалтгүй байна.

- Нийслэлд байршилтай Гэсэр сүм, Бэтүб сүмд үйл ажиллагаа явуулж буй шашны сургуулиуд бүрэн дунд боловсрол олгож байгаа нь Боловсролын тухай хуулийн 18.4 "Шашны сургуульд суралцагчид суурь боловсрол эзэмшүүлэх харилцааг энэ хууль болон Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулна" гэж заасантай нийцэхгүй байх тул албан шаардлага өгөө,
- Үндэсний баглан хамгаалахын их сургуулийн харьяа "Тэмүжин-Өрлөг" бүрэн дунд сургуулийн сургалтын үйл ажиллагаа ,

1.6 Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Боловсролын тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгө аймаг, нийслэлийн боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулиудын төсөвт батлагдахгүй байгаагаас гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, багшийн хөгжлийг дэмжих, багш сурагчийн хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах боломжийг хязгаарлаж байна. Тухайлбал,

- Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т "Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, нийслэл, сум, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүй зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна";
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т "Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж байгууллага эрсдэлийн түвшнээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна";
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т "Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын нийт хувьсах зардлын хоёр хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулна" гэж заасан боловч Засгийн газрын 2016 оны "Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай" 242 дугаар тогтоолоор батлагдсан бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцох бүрэлдэхүүнд тусгагдаагүй гэж тус тус заасан хэдий ч сургуулийн төсөвт хөрөнгө төлөвлөсөн ч батлагддаггүй байна.

1.7 Мөн боловсролын салбарын хуулиудад Засгийн газар, Боловсролын сайд дангаараа болон бусад салбарын сайдтай хамтарсан, стандартын болон мэргэжлийн хяналтын байгууллагаас баталж, мөрдүүлэхээр заасан дараах 24 дүрэм, журам, хөтөлбөр, стандартыг батлаагүй бөгөөд зарим төслийг боловсруулах шатандаа байх тул албан шаардлага өгөө. /Дэлгэрэнгүйг Хавсралт 2-с үзнэ үү/

1.8 Боловсролын тухай хууль түүнд нийцүүлэн гарсан зарим дүрэм, зааврын заалт бусад хууль эрх зүйн актуудтай харилцан ирэхдээ, өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй байна. Үүнд:

- Эрүүл мэндийн сайд, БСШУСС-ын /хуучин нэрээр/ 2018 оны А/494, А/761 дүгээр хамтарсан тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт сэтгэл зүйчийг орон тоогоор ажиллуулах үүрэг өгч, ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн зааврыг баталсан боловч Боловсролын тухай хууль, Засгийн газрын 2019 оны "Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 25 дугаар тогтоолоор баталсан албан тушаалын зэрэглэлд батлаагүй;

¹ Боловсролын тухай хуулийн 11.3.стандартыг асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулан, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 6.5-д заасны дагуу батлуулж, улсын бүртгэлд бүртгүүлнэ.

² Боловсролын тухай хуулийн 18.4 Шашны сургуульд суралцагчид суурь боловсрол эзэмшүүлэх харилцааг энэ хууль болон Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулна. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 8.3 Шашны сургуульд суралцагчдад иргэний суурь боловсрол олгохыг тухайн сургууль хариуцна

- БСШУС, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайд нарын 2007 оны 307/91/237³ дугаар хамтарсан тушаалаар баталсан журамд анги дүүргэлтийг бага ангид 30-35, дунд, ахлах ангид 32-35 хүүхэдтэй байхаар баталсан нь Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 305 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн дүрэм”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3.6⁴-д заасан анги дүүргэлтийн хүүхдийн тоотой уялдаагүй;
 - Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-д үр дүнгийн урамшуулал, өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг зөвхөн төрийн болон орон нутгийн өмчийн ЕБС-ийн албан тушаалтнуудад олгоно гэж заасан нь Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т “Багш, суралцагчид үзүүлэх хөнгөлөлт, нөхөх олговор, тэтгэлэг, тэтгэмж, шагнал урамшил нь өмчийн хэлбэр харгалзахгүй адил тэгш байна” гэж заасантай нийцээгүй;
 - Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-д зааснаар ААНБ бүр дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй хэдий ч БСШУСС, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”-т дотоод хяналтын ажилтны орон тоо батлагдаагүйгээс захирлын тушаалаар дотоод хяналтын ажилтныг томилон ажиллуулж, зарим сургуулиудад хавсран гүйцэтгүүлж байгаа нь ажилтнуудын ажлын ачааллыг нэмэгдүүлж ажлын гүйцэтгэл үр дүнд нь нөлөөлөхөөр байна.
 - Боловсролын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-д “Төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчинг сайжруулах, тэдгээрийг багшлах боловсон хүчнээр хангахад Засгийн газар тогтоосон журмын дагуу дэмжлэг, тусалцаа үзүүлнэ” гэж заасан ч ямар журмаар дэмжлэг, тусалцаа үзүүлэх нь тодорхойгүй, багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад хамруулж байгаагаас өөр дэмжлэг үзүүлээгүй байна.
 - Боловсролын сайдын 2018 оны А/608 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэг, сургуулийн орчинд гар утас, цахим хэрэгсэл болон сүлжээг зохистой хэрэглэх журам”-ын 3.8-д танхимын сургалтын үед багш нар суралцагчдад нийгмийн сүлжээг ашиглан даалгавар, бие даалт өгөхийг хориглох”-оор зохицуулсан байна.
- Covid-19 цар тахлын дэгдэлтийн үед зохион байгуулж буй онлайн болон теле хичээлийн үйл ажиллагаанд багш нар <https://classroom.google.com>, <https://meet.google.com> платформ ашиглаж сурагчдад хичээл заах, даалгавар өгөх, шалгах, мөн нийгмийн сүлжээгээр өдөр тутамдаа мэдээлэл солилцож буй боловч тодорхой эрх зүйн зохицуулалтгүй байна.

1.9 Холбогдох хуульд заасны дагуу Засгийн газар нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг жил бүр шинэчлэн батлаагүй, зарим дүрэм журмыг хуульд нийцүүлэн шинэчлэн баталж мөрдүүлээгүй байна.

- Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3⁵-д заасан нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр, 41 дүгээр зүйлийн 41.3⁶-т заасан төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид төрөөс ногдох сургалтын нормативт зардлын хэмжээг Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор баталсан боловч тухай бүр шинэчлэн батлаагүй.
- Засгийн газрын 2012 оны 180 дугаар тогтоолоор баталсан Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын дүрмийг Боловсролын тухай хуулийн 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн “16.7 Багшийн мэргэжил дээшлүүлэх, арга зүйн байгууллагын дүрэм, бүтцийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон тоог санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална” гэж заасан нэмэлт өөрчлөлттэй уялдуулж шинэчлэн батлаагүй.
- Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д “Сургуульд хоол зүйч, мэргэжлийн тогооч, туслах тогооч ажиллах бөгөөд суралцагчийн тооноос хамаарч бэлтгэгч, угаагч, үйлчлэгч ажиллана” гэж заасан байхад БШУСС, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А/024/11 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”-д хоол зүйчийн орон тоо байхгүй бөгөөд жишиг нормативд өөрчлөлт оруулж, хууль хэрэгжих боломжийг бүрдүүлээгүй.
- БСШУС-ын 2002 оны 333 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуульд гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт зохион байгуулах үлгэрчилсэн журам”-ыг Бага, дунд боловсролын тухай хуулийн 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн “Төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэсэн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулж шинэчлэн батлаагүй.
- БСШУСС-ын 2018 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн А/243 дугаар тушаалаар баталсан “Ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам”-ын 2.1-д “Зөвлөл нь аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд, ... 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байна” гэж заасныг 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т “Аймаг, нийслэлийн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дэргэдээ багшийн ёс зүйн хороотой байна” гэж заасантай нийцүүлж шинэчлээгүй.
- Бага, дунд боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2⁷-т заасны дагуу БСШУС-ын 2003 оны 451 дүгээр тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчийн үлгэрчилсэн дүрэм”-ийг ХНХС-ын 2016 оны А/249 дүгээр тушаалаар хүчингүй болгосон тул шинэчлэн батлах шаардлагатай;

³ Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтын цалин хөлсийг тооцож олгох журам батлах тухай

⁴ Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт 30 хүүхдээс ихгүй, өдөр өнжүүлэх бүлэг болон 6 настай 1-р ангид хамрагдах хүүхдийн тоог тухайн хот, суурины хүн амын тоо, нятрал, бүтэц бүрэлдэхүүнийг үндэслэн зургийн даалгаврын дагуу тогтооно. 6 настай хүүхдийн онцлогоос хамаарч анги дүүргэлтийг 20-24 сурагчтай байхаар тооцох нь зохимжтой.

⁵ Боловсролын тухай хуулийн Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно

⁶ Боловсролын тухай хуулийн 41.3. Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид төрөөс ногдох сургалтын нормативт зардлын хэмжээг тухайн боловсролын сургалтын байгууллагын сургалтын төлбөртэй нь уялдуулан Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно.

⁷ Бага, дунд боловсролын тухай хуулийн 17.2 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч эрмэлзэл, үлгэрчилсэн дүрэмтэй байх бөгөөд тэдгээрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална

- Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.24-т заасан “Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-ыг БШУС-ын 2013 оны 287 дугаар тушаалаар баталсан хэдий ч БСШУСЯ-наас ХЗДХЯ-нд хүргүүлсэн 2013 оны А/287 дугаар албан бичгээр нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ актаас хасалт хийлгэсэн тул шинэчлэн батлах шаардлагатай;
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Багшид ажлын гүйцэтгэлд суурилсан урамшууллыг олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална” гэж заасан боловч тус журам батлагдаж гараагүй, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоно” гэж заасныг баримталж байна.
- БСШУС-ын 2003 оны 321 дүгээр тушаалаар батлагдсан “ЕБС, цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх тоон болон чанарын шалгуур үзүүлэлт”-ийг мөрдөж байгаа боловч үйл ажиллагааг үнэлэх чанарын үзүүлэлтийн шалгуур тодорхойгүй, салбарын хууль тогтоомжуудтай уялдуулан шинэчлэх шаардлагатай байна.

1.10 Мөн аймаг, нийслэлийн боловсролын газар, Засаг дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зүгээс байгуулах, өөрчлөх, татан буулгах, хөгжүүлэх төлөвлөгөө батлах, хамран сургах тойргийг тогтоох, захирал, эрхлэгчийг сонгон шалгаруулах, томилох эрхээ хэрэгжүүлж буй боловсролын сургалтын байгууллага нь Иргэний хуулийн 99.1⁸, 99.2⁹-д зааснаар орон нутгийн өмчийн боловсролын байгууллагад хамаарч байна.

1.11 Боловсролын тухай хуульд боловсрол сургалтын байгууллагын өмчийн хэлбэрийн талаар зохицуулалт хангалтгүйгээс дараах сургуулиудын статус тодорхойгүй байна. Тухайлбал:

- **Улаанбаатар хот дахь олон улсын сургууль /International school of Ulaanbaatar/**
Тус хувийн, ашгийн бус сургуулийг тухайн үеийн Улаанбаатар хот дахь Элчин сайдын яамдууд, НҮБ, олон улсын болон төрийн бус байгууллагад ажилладаг эцэг эхчүүд санаачлан 1992 онд байгуулсан байна. Сургуулийн дүрэмд “Удирдах зөвлөл нь 5-11 гишүүнтэй байх, АНУ-ын Төрийн Департаментээс дэмжлэг /мөнгө ба төрөл бүрийн дэмжлэг/ авах боломжтой болгох үүднээс нэг санал өгөх эрхтэй гишүүнийг АНУ-ын ЭСЯ-аас томилно. Энэ заалт зөвхөн уг дэмжлэг байгаа хугацаанд хүчин төгөлдөр байна”, “Нэг үндэстний сурагчдын тоо нийт сургуульд элсэгчдийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэж заасан байна. Тус сургуулийн ач холбогдлыг харилцан хүлээн зөвшөөрч, эрх зүйн байдлыг зохицуулахыг эрмэлзэж АНУ-ын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2004 оны 5 дугаар сарын 26-ны өдөр байгуулж, УИХ-аас “Улаанбаатар хот дахь олон улсын сургуулийн тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай” хуулийг 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр баталсан байна. Уг хэлэлцээрт “Сургууль нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээд байна. Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй тохиолдолд Сургуулийн үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулагдана” гэж заажээ.
- **Монгол Оросын хамтарсан сургууль /Орос 3 дугаар сургууль/**
Тус сургууль нь Монгол Улсын Засгийн газар ОХУ-ын Засгийн газар хоорондын комиссын шийдвэрийн дагуу 1992 онд байгуулагдсан, ОХУ-ын Боловсролын яам, Буриад Улсын Шинжлэх, ухаан боловсролын яам хооронд 1994 онд байгуулсан 3 талт гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байна.
- **Монгени цогцолбор сургууль**
Тус сургууль нь төр, иргэн Н.Лхагва, “Монгени сан” ТББ-ын хамтарсан хөрөнгө оруулалттай боловч боловсролын статистик төрийн өмчийн сургуулийн ангилалаар тайлагнаж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаагаар үүсгэн байгуулагч иргэн Н.Лхагва-ын нэрээр бүртгэгдсэн байна.

Дүрслэл 1. Хувийн сургуулиудын Улсын бүртгэлд бүртгэгдсэн байдал



Эх сурвалж: УБЕГ, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагаас ирүүлсэн судалгаа

1.12 Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 155 хувийн сургуулиудын улсын бүртгэлд бүртгэгдсэн байдлыг үзэхэд хариуцлагын хэлбэр харилцан адилгүй, дийлэнх буюу 48.7 хувийг “Боловсрол, сургалтын байгууллага”, 34.0 хувийг “Хязгаарлагдмал хариуцлагатай компани”, 17.3 хувийг “Төрийн бус байгууллага” эзэлж байна.

1.13 Мөн үндсэн үйл ажиллагааг “Бага, дунд боловсрол олгох үйл ажиллагаа”, “Бага, суурь болон дунд боловсрол олгох үйл ажиллагаа”, “Боловсрол эзэмшүүлэх сургалт”, “Бүрэн дунд боловсрол”, “Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа” гэх зэргээр харилцан адилгүй бүртгэсэн төдийгүй Боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-д “Төрийн бус өмчид түшиглэн байгуулах боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө бус болон ашгийн төлөө байна” гэж заасан хэдий ч

⁸ Иргэний хуулийн 99.1 Монгол Улсад нийтийн болон хувийн өмч байна,

⁹ Иргэний хуулийн 99.2.Нийтийн өмч нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй байна,

дийлэнх хувийн сургуулиуд ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг бүртгэлтэй тул татвар төлдөггүй байна.

1.14 Салбарын яамны зүгээс төрийн өмчийн бус сургуулиудын сургалтын төлбөрийн орлогын зарцуулалт, зардлын бүрэлдэхүүн, тэдгээрийн зохистой харьцаа, эзний өмчийг хэрхэн нэмэгдүүлж буй байдалд дүн шинжилгээ хийгээгүй байна.

1.15 Иймд салбарын яам холбогдох байгууллагатай хамтран төрийн өмчийн бус сургуулиудын хариуцлагын хэлбэрийг тодорхой болгох, суралцагчийн хувьд төлж буй төлбөрөөс хүртэх өгөөжийг тодорхойлж, тооцох боломжийг бүрдүүлэх зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, “боловсрол” үндэсний хөтөлбөрт тусгасан зорилтыг жил бүрийн үндсэн чиглэлд бүрэн тусгаагүй байна

1.16 Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 295 дугаар тогтоолоор “Зөв монгол хүүхэд” үндэсний хөтөлбөр, тус үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Бага дунд боловсролын чанарын шинэчлэл”, “Авьяас” “Ном” дэд хөтөлбөрийг 2013-2016 онд улсын хэмжээнд, Монгол хэлний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т заасныг үндэслэн Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг тус тус баталсан байна.

1.17 УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030¹⁰”-д Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулах хүрээнд дараах зорилтууд тусгагдсан байна. Үүнд:

Хүснэгт 2. “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д тусгагдсан зорилт

I үе шат (2016-2020)	Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд /PISA/ хамрагдах бэлтгэлийг хангаж, нийт ерөнхий боловсролын сургуулийг хоёроос ихгүй ээлжээр хичээллэх боломжийг бүрдүүлэх, уламжлалт нүүдлийн ахуйд зохицсон боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, нэвтрүүлэх. Бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүүхэд бүр мэргэжлийн чиг баримжаатай болсон байх.
II үе шат (2021-2025)	Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд хамрагдах, хоёр ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн тоог 30 хүртэл хувиар бууруулах, анги дүүргэлтийг багасгаж, улсын дунджийг 25-аас илүүгүй байлгах.
III үе шат (2026-2030)	Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд эзлэх байрыг 5-аар урагшлуулж, сургалтын лаборатори, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүх сургуулийг 100 хувь хангах, хоёр ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн тоог 50 хүртэл хувиар бууруулах, анги дүүргэлтийг багасгаж, улсын дунджийг 20-оос илүүгүй байлгах.

Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/7105?lawid=11725>

1.18 УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх” зорилтын хүрээнд 44 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгаж, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг дараах байдлаар тодорхойлжээ.

Хүснэгт 3. “Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин		
				2025	2030	2050
1	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	94.9	95.9	96.8	100
2	7-14 насны хүүхдийн суурь чадвар (унших, тоо бодох)	хувь	61.6	70	75	90
3	Нийт төгсөгчид ажил эрхэлж байгаа төгсөгчдийн эзлэх хувь (МСҮТ, их, дээд сургууль)	хувь	76.5	90	95	100
4	Бүлэг дүүргэлт (боловсролын бүх түвшинээр)	тоо	ЕБС хотод-35, хөдөө - 28	25-30	20-30	20-30

Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/annex/details/11059?lawid=15406>

¹⁰ УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан бөгөөд УИХ-ын 2020 оны ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоолоор хүчингүй болсон.

1.19 Засгийн газрын 2010 оны 31 дүгээр тогтоолоор баталсан “*Боловсрол*” үндэсний хөтөлбөр (2010-2021 он)”, УИХ-ын 2015 оны 12 дугаар тогтоолоор “*Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого*”-ыг баталж, стратегийн зорилтыг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгаж, дараах үр дүнд хүрэхээр тусгажээ. Тухайлбал,

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024 он/

- Ерөнхий боловсролын сургалтын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарттай дүйцэхүйц үндэсний хөтөлбөрийг нэвтрүүлж, олон улсын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд 2018-2019 оны хичээлийн жилд хамрагдсан байна;
- Сурлагын амжилтын олон улсын чанарын үнэлгээний судалгаанд 2021 онд хамрагдана;
- Ерөнхий боловсролын сургуульд заах арга зүй, сургалтын технологиор мэргэшсэн магистр зэрэгтэй багшийн эзлэх хувийг 70 хувьд хүргэнэ;
- Ерөнхий боловсролын сургууль нэг ээлжээр хичээллэх боломж бүрдсэн байна;
- Боловсролын удирдлага, мэдээллийн нэгдсэн системийг 2016-2017 оны хичээлийн жилээс үндэсний хэмжээнд бүрэн нэвтрүүлсэн байна.

“Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010-2021 он) стратегийн 6 зорилтын хүрээнд

- Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх болон цогц чадамжид суурилсан сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын стандарт, сургалтын хувилбарт төлөвлөгөө, хөтөлбөрүүд боловсорч тогтвортой мөрдөгдөнө;
- Ерөнхий боловсролд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, хөтөлбөрийг нэвтрүүлсэн байна;
- Олон улсын жишигт ойртсон болон IB (International Baccalaureate) хөтөлбөрт хамрагдах эрхтэй сургуулийн тоо нэмэгдэнэ;
- Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн хангамж сайжирна;
- Багш бүрийн мэргэжлийн болон арга зүйн хөгжилд бодит ахиц гарч, шинэ стандарт, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой болно;
- Багш, удирдах ажилтан бэлтгэх тогтолцоо шинэчлэгдсэн байна;
- Бүх сургууль мэргэжлийн багшаар бүрэн хангагдана;
- Багшийн нийгмийн хамгаалал, халамжийн тогтолцоо төлөвшиж, багшийн нийгэмд эзлэх байр суурь, нэр хүнд нэмэгдэнэ;
- Боловсролын чанарын үнэлгээний шинэ тогтолцоо бий болно зэргээр 44 үр дүнд хүрэх зорилт дэвшүүлжээ.

1.20 Гэвч УИХ-ын 2016 оны 70, 2017 оны 42, 2018 оны 37 дугаар тогтоолуудаар баталсан эдийн засаг, нийгмийг 2017, 2018, 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд дээрх зорилтууд бүрэн тусгагдаагүй төдийгүй, тусгагдсан арга хэмжээний биелэлт хангалтгүй байна.

1.21 БШУЯ нь Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд заасан “*Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр*” батлаагүй бөгөөд 2016-2020 онд боловсролын мастер төлөвлөгөөгүй ажилласан нь Боловсролын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2¹¹-д заасантай нийцэхгүй байна.

¹¹ Боловсролын тухай хуулийн 38.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага орон нутгийн захиргааны болон холбогдох бусад байгууллагын оролцоотойгоор боловсролын хөгжлийн ойрын болон хэтийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

38.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын боловсруулсан төлөвлөгөө, арга зүйг үндэслэн аймаг, нийслэл, сум, дүүрэг боловсролын ойрын болон хэтийн төлөвлөгөөтэй байна.


Салбарын хүний нөөцийн нэгдсэн бодлого, төлөвлөгөөгүй, хамран сургалт тэгш, хүртээмжтэй бус, суралцагчийн сурах хэрэгцээнд дэмжлэг үзүүлэхүйц материаллаг орчин нөхцөл бүрдээгүй байна

Хамран сургалтын тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлээгүй байна


1.22 Улсын хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилд 820 ЕБС үйл ажиллагаа явуулж байгаагаас 662 буюу 80.7 хувь нь төрийн, 158 буюу 19.3 хувь нь хувийн өмчийн сургууль байна. Төрийн өмчийн сургууль 2017-2019 онд дунджаар нийт сургуулийн 82.0 хувь, хамран сургалтын 93.0 хувийг эзэлсэн байна. Нийт сургуулийн 562 буюу 68.5 хувь нь орон нутагт, 258 буюу 31.5 хувь нийслэлд байршилтай байна.

- 2019 оны байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай хувийн 21 сургууль, төрийн сургууль 1 /СБД-ийн Монгол-Оросын хамтарсан сургууль/ байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 4-с үзнэ үү/

Дүрслэл 2. Сургуулийн тоо өмчийн хэлбэр, байршлаар




Дүрслэл 3. Хамран сургалтын хувийн жин



Эх сурвалж: БШУЯ-ны статистик мэдээ

1.23 Хэв шинжийн хувьд ердийн сургууль 88.1 хувь, олон улсын хөтөлбөртэй сургууль 1.0 хувь, тусгай сургууль хамгийн бага буюу 0.7 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд 78 буюу 9.5 хувь нь бага сургууль /1-5 дугаар ангитай/, 113 буюу 13.8 хувь нь дунд сургууль /1-9 дүгээр ангитай/, 584 буюу 71.2 хувь нь ахлах сургууль /1-12 дугаар ангитай/, 45 буюу 5.5 хувь нь цогцолбор сургууль байна.

Дүрслэл 4 Хамран сургалт /боловсролын ангиллаар/



Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны яам

хамрагдсан хүүхдийн 54.0 хувь бага боловсрол /1-5 дугаар анги/, 31.0 хувь суурь боловсролд /6-9 дүгээр анги/ бүрэн дунд боловсролд /10-12 дугаар анги/ 14.7 хувь тус тус хамрагдсан байна.

1.26 БШУЯ-наас суурь боловсролд хамрагдаагүй хүүхдийг бүртгэх, суралцаагүй шалтгааныг судлах ажил иж бүрэн хийгдээгүй байна.

- Суурь боловсролд 2019 онд 6-14 насны нийт 19,303 хүүхэд хамрагдаагүй байхад БШУЯ-ны статистик мэдээнд нийт хамрагдаагүй хүүхдийн 4.3 хувь буюу 838 хүүхдийг хамруулж, суралцаагүй шалтгааныг тогтоосон байна.

1.24 Ерөнхий боловсролд 2017-2020 оны хичээлийн жилд өдрөөр 572,752-640,449 хүүхэд хамрагдсан бөгөөд хамран сургалтын цэвэр жин¹² дунджаар 93.3 хувь байгаа нь доогуур орлоготой улс оронтой харьцуулахад өндөр, харин өндөр орлоготой орнуудын түвшинд¹³, 2019 онд 96.6 хувьтай байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас үзнэ үү/.


1.25 Боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Монгол улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй” гэж заасан бөгөөд хүн амын өсөлт, нийт хүн амын тоонд бага насны хүүхдийн эзлэх хувь өндөр зэргээс 2017-2019 онд дунджаар нийт

¹² Бага, дунд боловсролын тухай хуульд¹² зааснаар ерөнхий боловсролын сургуульд 6 настай хүүхдийг элсүүлдэг тул хамран сургалтын цэвэр жинг 6-17 насаар тооцов.

¹³ Эх сурвалж: https://data.worldbank.org/indicator/SE.PRM.NENR?name_desc=true


Аймгийн төв болон нийслэлийн төвийн дүүргийн сургуулиудад төвлөрөл үүсэж, хүчин чадлаас давсан ачаалалтай ажилласан байна

Дүрслэл 5. Хамран сургалт, хүчин чадлын харьцуулалт



Эх сурвалж: ҮСХ, БШУЯ-ны статистик мэдээ, аудитын тооцоолол

Дүрслэл 6. Хүчин чадлаас хэтэрч хамрагдсан хүүхдийн тоо



Эх сурвалж: Аудитын тооцоолол

байна.

1.30 Гэвч хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөнтэй уялдуулж ЕБС-ийн хүчин чадлыг нэмэгдүүлээгүйгээс улсын хэмжээнд 2017 онд 26, 2018 онд 28 сургууль III ээлжээр хичээллэсэн бөгөөд хамрагдсан хүүхдийн 75 орчим хувийг бага ангийн хүүхэд эзэлж байна.

- Сургуулийн насны хүүхдийн тоо 2018 онд 9.2 хувиар өссөн боловч нийт сургуулийн батлагдсан хүчин чадал 2018 онд өмнөх оноос 1.5 хувиар нэмэгдсэн байна.
- Хүн амын тоо өндөр БЗД, ХУД, СХД-т байрлах сургуулиудын III ээлжид хичээллэсэн хүүхдийн тоо хамгийн өндөр байна.

Хүснэгт 4. III ээлжид хичээллэсэн сургууль, бүлэг, хамрагдсан хүүхдийн тоо

Байршил	2017 он			2018 он			2019 он		
	Сургууль	Бүлэг	Хамрагдсан хүүхэд	Сургууль	Бүлэг	Хамрагдсан хүүхэд	Сургууль	Бүлэг	Хамрагдсан хүүхэд
Баянгол дүүрэг	2	8	317	3	21	752			
Баянзүрх дүүрэг	5	32	1209	7	48	1899	1	7	265
Сонгинохайрхан дүүрэг	8	75	2872	10	97	3921			
Сүхбаатар дүүрэг	1	4	130						

¹⁴ /аудитын тооцоолол, 2017-2019 оны дунджаар/

1.27 ЕБС-ийн нийт хүчин чадал ¹⁴ 458,039 суудалтай боловч энэ нь нийт хамрагдсан хүүхдийн тооноос 31.2 хувиар доогуур байсан тул 2017 онд 180,571, 2018 онд 194,603, 2019 онд 222,403 хүүхэд илүү хамрагдсан байна. Энэ нь хамран сургалтын цэвэр жинг 2017 онд 93.9 хувь, 2018 онд 93.3 хувь, 2019 онд 92.7 хувьд хүргэсэн байна.

1.28 Аймгийн төв болон нийслэлийн төвийн дүүргийн сургуулиудад төвлөрөл үүсэж, хүчин чадлаас давсан ачаалалтай ажилласан байна. Тухайлбал,

- Хөвсгөл аймаг 10,003, Өвөрхангай аймагт 7,031 байгаа нь хамгийн их, Дундговь аймаг 881, Говь-Алтай аймагт 1,889 байгаа нь хамгийн бага байна. Ачаалал өндөртэй сургуулиуд аймгийн төвд байршилтай байна.
- Нийслэлд нийт сургуулийн 30.6 хувь, хамран сургалтын 44.5 хувь, хүчин чадлаас давж хамрагдсан хүүхдийн 56.3 хувь ногдож байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 5-с үзнэ үү/

III ээлжээр хичээллэдэг сургуулиуд бусдын эзэмшлийн барилга түрээсэлж, үйл ажиллагаа явуулсан байна

1.29 УИХ-ын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024 он/”-ын 7.10-т “Ерөнхий боловсролын сургууль нэг ээлжээр хичээллэх боломж бүрдсэн байна”, УИХ-ын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 3.2.3-т “Анги дүүргэлт хэт өндөртэй сургуулийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид шилжүүлнэ” гэж заасан

Хан-Уул дүүрэг	5	33	1342						
Чингэлтэй дүүрэг	3	21	1062	3	22	1171			
Булган аймаг	1	1	28	1	1	29			
Говь-Алтай аймаг	2	12	375	1	2	46	1	2	43
Завхан аймаг				1	4	96			
Сүхбаатар аймаг				1	13	418			
НИЙТ ДҮН	26	186	7335	28	212	8451	2	9	308

Эх сурвалж: БШУЯ-ны статистик мэдээ

1.31 БШУЯ дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2019 онд 3 ээлжтэй сургуулийн бүлэг, хамрагдалт эрс буурсан харагдаж байгаа хэдий ч уг арга хэмжээ нь ерөнхий боловсролын сургуулиудад үүсээд буй хэт ачааллыг урт хугацаанд бууруулах үр нөлөөгүй, нэг удаагийн шинж чанартай, төсөвт нэмэлт ачаалал үүсгэсэн арга хэмжээ болжээ.

- БСШУСС-ын “Барилга түрээслэх тухай” 2019 оны А/522 дугаар тушаалаар 2019-2020 оны хичээлийн жилд ачаалал хэт өндөр, III ээлжтэй 18 сургуулиас 8 сургуулийг¹⁵ иргэн, аж ахуй нэгж байгууллагын өмчлөлийн барилгыг түрээслэхээр шийдвэрлэж, нийслэлийн төсвөөс түрээсийн төлбөрт 2019 оны 9 дүгээр сараас 2020 оны 2 дугаар сарыг дуустал 262.2 сая төгрөг олгожээ,
- Дотоод тохижилт, зохион байгуулалт хийж анги танхим нэмэх замаар 4 сургуулийг¹⁶ II ээлжид шилжүүлсэн.

1.32 Боловсролын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-т аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал тухайн орон нутгийн өмчийн ЕБС-иудыг хөгжүүлэх төлөвлөгөөг батлах, биелэлтэд хяналт тавихаар заасны дагуу 13 аймаг, нийслэлийн ИТХ-аас баталсан боловч хэрэгжилтэд хяналт тавиагүй, 9 аймаг¹⁷ батлуулаагүй байна.

Бага ангийн хамран сургалт нийслэлийн төвийн дүүрэгт төвлөрч, нэг бүлэгт 66 хүүхэд хамрагдсан байна

Зураг 1. Хүмүүн цогцолбор бага сургуулийн анги дүүргэлт, ширээ хоорондын зай



Эх сурвалж: Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллага

1.33 БШУС, НХХС, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 307-91-237 тушаалын хавсралтад анги дүүргэлтийг бага ангид 30-35 хүүхэдтэй, дунд, ахлах ангид 32-35 байхаар, ЗТБХБС-ын 2011 оны 305 дугаар тушаал “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн дүрэм”-ийн 1.3.6-д “Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт 30 хүүхдээс ихгүй, өдөр өнжүүлэх бүлэг болон 6 настай 1 дүгээр ангид хамрагдах хүүхдийн тоог тухайн хот, суурины хүн амын тоо, нягтрал, бүтэц бүрэлдэхүүнийг үндэслэн зургийн даалгаврын дагуу тогтооно. 6 настай хүүхдийн онцлогоос хамаарч анги дүүргэлтийг 20-24 сурагчтай байхаар тооцох нь зохимжтой” гэж заасан байна.

1.34 Гэвч 1 дүгээр ангийн бүлэг дүүргэлтийг авч үзэхэд хотын төвийн буюу орон сууцны хорооллын сургуульд хамгийн ихдээ 66 хүүхэд буюу 2.8 дахин их, хотын захын буюу гэр хорооллын сургуульд 38 хүүхэд буюу 1.6 дахин хэтэрсэн байна.

- Улсын хэмжээнд 2018 оны байдлаар ЕБС-ийн 1-р ангийн 1 бүлэгт Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор 46 хүүхэд, нийслэлийн СБД-ийн 1-р сургууль 66 хүүхэд, ХУД-ийн 18-р сургууль 64 хүүхэд, БГД-ийн Оюуны ундраа цогцолбор 59 хүүхэд, БЗД-ийн 84-р сургуульд 57 хүүхэд хамрагдсан нь хамгийн өндөр байна.
- 2019 оны байдлаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын 4-р сургууль 49 хүүхэд, нийслэлийн СБД-ийн 1-р сургууль 53, ХУД-ийн 18-р сургууль 56 хүүхэд, БГД-ийн Оюуны ундраа цогцолбор 50 хүүхэд, БЗД-ийн 84-р сургуульд 53 хүүхэд болж буурчээ.
- Ачаалал өндөр сургуулиудад бүлэг дүүргэлт 1.5 дахин хэтэрсэн байгаагаас сурагчдын ширээ сандал хоорондох зай 15-40 см хэмжээтэй, чөлөөтэй суух боломжгүй байна.

¹⁵ БЗД-ийн 44 дүгээр сургууль, ХУД-ийн 10 дугаар сургууль, 15 дугаар сургууль, БГД-ийн Сэтгэмж, ЧД-ийн 5 дугаар сургууль, СХД-ийн 12 дугаар сургууль, 62 дугаар сургууль, 122 дугаар сургууль

¹⁶ СБД-ийн Эрдмийн хөтөч, 71 дүгээр сургууль, ХУД-ийн 18, 115 дугаар сургууль

¹⁷ Архангай, Баян-Өлгий, Дорноговь, Дундговь, Говь-Алтай, Хэнтий, Ховд, Хөвсгөл, Сэлэнгэ


Сумдын бага сургуулийн 1 ангид 1 хүүхэд хамрагдсан, зарим бүлэгт хүүхэд хамрагдаагүй, зарим сумдын ахлах сургуулийн тал суудал хоосон байна

1.35 Улсын хэмжээнд нийт батлагдсан хүчин чадал /аудитын тооцооллоор/ 2017 онд 450,537 суудал, 2018 онд 454,409 суудал, 2019 онд 469,170 суудал байгаа бөгөөд 86.0 хувийг төрийн өмчийн, 14.0 хувийг төрийн бус өмчийн сургууль эзэлж байна.

1.36 Улсын хэмжээнд анги дүүргэлт хэтэрч, хамран сургалт батлагдсан хүчин чадлаас 2017-2019 онд дунджаар 1.3 дахин их, ачааллаас давсан байгаа хэдий ч бүлэг дүүргэлт хангалтгүйгээс тухайн онуудад дунджаар 56,531 хүүхдийн суудал ашиглалтгүй, зарим сургуулийн анги танхим хоосон, бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж, ашиглалтын зардалд төсвөөс үр ашиггүй хөрөнгө зарцуулж байна.

- Архангай, Говь-Алтай, Төв, Дархан-Уул, Орхон аймгийн сургуулиудын анги танхимын дүүргэлт илүүтэй хангалтгүй байна. /дэлгэрэнгүйг хавсралт 5-аас үзнэ үү/

Дүрслэл 7. Хүчин чадалдаа хүрээгүй суудлын тоо




Эх сурвалж: Аудитын тооцоолол

онд дунджаар 64,687 байгаа бөгөөд үүнээс 2019 онд үйл ажиллагаа явуулсан нийт 157 сургуулийн 73.0 хувь буюу 115 нь нийслэлд, 27.0 хувь буюу 42 нь орон нутагт байна.

- Орон нутагт Дархан-Уул аймаг 10, Орхон аймагт 7, Баян-Өлгий аймагт 6, нийслэлд БГД-т 28, БЗД-т 27, ХУД-т 20 хувийн сургууль байгаа нь хамгийн их байна.

1.39 Төрийн бус өмчийн сургуулийн нийт хүчин чадлыг улсын сургуультай харьцуулахад 6 дахин бага боловч бүлэг дүүргэлт хангалтгүй, нийт хүчин чадлын 42.0 хувь ашиглалтгүй байна.

Дүрслэл 8. ТБӨ-ийн сургуулийн нийт хүчин чадал ба ашиглалтгүй суудлын харьцуулалт



Эх сурвалж: Аудитын тооцоолол

2014 онд баригдсан боловч 2019 оныг хүртэл үйл ажиллагаа явуулаагүй, 2019-2020 оны хичээлийн жилд 9 дүгээр ангийн 1 бүлэгт 9 хүүхэд хамрагдсан байна. Иймд төсвийн 1,143.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх албан шаардлага өглөө.

1.37 Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр болон гадаадын ТББ-ын санхүүжилтээр баригдсан сургуулийн барилгын хүчин чадлыг оновчтой төлөвлөөгүйгээс 2017-2019 оны дунджаар төрийн сургуулийн нийт хүчин чадлын 7.8 хувь буюу 30,537 суудал хоосон, зарим суманд бага сургуулийн хүчин чадлын тал хувь ашиглалтгүй, ахлах сургуулийн бүлэг дүүргэлт хангалтгүй, зарим бүлэгт хүүхэд хамрагдаагүй байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 8-аас үзнэ үү/

1.38 Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хувийн сургуулийн хүчин чадал 2017-2019

1.40 Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй шашны сургуулиуд¹⁸ 10-12 дугаар ангид хүүхэд хамруулж, бүрэн дунд боловсрол олгож байгаа нь Боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4¹⁹, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3²⁰-д заасантай нийцэхгүй төдийгүй бүлэг дүүргэлт багатай зарим бүлэгт 1-9 хүүхэд хамрагдсан байна.

- Бэтүб сүмийн шашны сургууль зориулалтын бус байранд хичээллэдэг бөгөөд 5-12 дугаар ангид 2017-2019 онд дунджаар нийт 40 хүүхэд хамрагдсан, 5 дугаар ангийн нэг бүлэгт 2017 онд 7, 2018 онд 5, 2019 онд 1 хүүхэд суралцсан,

- Гэсэр сүмд байршилтай 112 дугаар сургууль нь 120 хүүхдийн хүчин чадалтай бөгөөд 6-12 дугаар ангид 2017 онд 129, 2018 онд 97, 2019 онд 100 хүүхэд хамрагдсан,

- Өвөрхангай аймгийн Хархорин суманд байршилтай Монголын Бурханы Шашны Дээд Сургуулийн харьяа 250 хүүхдийн хүчин чадалтай ЕБС-ийн барилга УТХО-аар 1,143.1 сая төгрөгөөр 2011-

¹⁸ Нийслэлд төрийн өмчийн 112 дугаар сургууль, хувийн өмчийн Бэтүб, Өвөрхангай аймагт Монголын Бурханы Шашны Дээд Сургуулийн харьяа ЕБС

¹⁹ Боловсролын тухай хуулийн 18.4 Шашны сургуульд суралцагчид суурь боловсрол эзэмшүүлэх харилцааг энэ хууль болон Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулна.

²⁰ Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 8.3 Шашны сургуульд суралцагчдад иргэний суурь боловсрол олгохыг тухайн сургууль хариуцна

Шинээр барих сургуулийн байршил, хүчин чадлыг оновчтой тодорхойлоогүй, нэн шаардлагатай сургуулийн хөрөнгө оруулалт орхигдсон байна

1.41 БШУЯ-аас ирүүлсэн судалгаанаас үзэхэд 2017 онд 11,480 хүүхдийн суудалтай 20 сургууль, 2018 онд 6008 хүүхдийн суудалтай 10 сургууль, 2019 онд 6530 хүүхдийн суудалтай 17 сургууль ашиглалтад орсон байна.

1.42 УИХ-ын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд доорх арга хэмжээг төлөвлөсөн боловч хэрэгжүүлээгүй, ЗТБХБС-ын 2010 оны 148 дугаар тушаалаар баталсан "Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлтийн норм ба дүрэм"-д шинээр барих орон сууцны барилгын зураг төсөлд сургуулийн барилгыг хамт төлөвлөн барих заалт тусгаагүй, байна. Үүнд:

- 3.2.3-т "Анги дүүргэлт хэт өндөртэй сургуулийн ачааллыг бууруулах" зорилтын хүрээнд "сургуулийн эрэлт, хэрэгцээ өндөр байгаа хот сууринд хөрөнгө оруулалтыг төвлөрүүлж, сургуулийн барилга шинээр барих, өргөтгөх, засварлах дунд хугацааны төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах";
- 3.2.3.1-т сургуулийн хүрэлцээг сайжруулах зорилгоор "Улаанбаатар хот, аймгийн төвд шинээр барих орон сууцны хороолол, хотхоны зураг төсөл, ерөнхий төлөвлөгөөнд сургуулийг заавал тусгаж төлөвлөх чиглэлээр холбогдох норм, дүрэмд өөрчлөлт оруулж, тусгасан нөхцөлд газрын зөвшөөрлийг шийдвэрлэж байх зохицуулалтыг бий болгох" арга хэмжээг төлөвлөсөн,

1.43 Салбарын яам одоог хүртэл хөрөнгө оруулалтын дунд хугацааны бодлого, төлөвлөгөөгүйгээс шинээр барих, өргөтгөх сургуулийн хүчин чадлыг хүн амын тоо, бодит хэрэгцээ шаардлагад үндэслэж оновчтой төлөвлөөгүй, нэн шаардлагатай газарт хөрөнгө оруулалт бүрэн тусгаагаагүй нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжид сөргөөр нөлөөлж, цаашид үр ашиггүй ашиглалтын зардал гарч төсөвт ачаалал үүсэхэд хүргэж байна. Тухайлбал,

Архангай аймаг

- Архангай аймгийн Хайрхан сумын 720 суудалтай сургуульд 2017-2019 онд дунджаар 664 хүүхэд хамрагдсан байхад улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар 3,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 320 хүүхдийн суудалтай сургуулийг нэмж барихаар төлөвлөсөн;

Баян-Өлгий аймаг

- Цэнгэл суманд 100 суудалтай сургуульд 2017-2019 дунджаар 121 хүүхэд хамрагдсан байхад улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтаар 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 360 хүүхдийн хүчин чадалтай бага сургуулийн барилга барихаар төлөвлөсөн бөгөөд барилга угсралтын ажил 30.0 хувьтай;
- Цагааннуур тосгонд 320 суудалтай сургуульд 2017-2019 онд дунджаар 203 хүүхэд хамрагдсан байхад улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтаар 2,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 240 хүүхдийн хүчин чадалтай бага сургуулийн барилга шинээр ашиглалтад орсон;

Баянхонгор аймаг

- Гурванбулаг сумын 320 хүүхдийн суудалтай дунд сургуульд 2017-2019 онд дунджаар 347 хүүхэд хамрагдсан, хэвийн ачаалалтай байхад улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар тус суманд нэмж 1,540.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 160 хүүхдийн суудалтай сургууль барихаар төлөвлөсөн;
- Баянхонгор сумын Шаргалжуут багийн 150 суудалтай сургуульд 2017-2019 онд дунджаар 144 хүүхэд хамрагдаж байхад улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар тус суманд нэмж 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 240 хүүхдийн суудалтай сургууль барихаар төлөвлөсөн;

Завхан аймаг

- Эрдэнэхайрхан сумын 160 суудалтай сургуульд 2017-2019 онд дунджаар 145 хүүхэд хамрагдаж байхад улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар тус суманд нэмж 2,528.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 240 хүүхдийн суудалтай сургууль барихаар төлөвлөсөн;

Өвөрхангай аймаг

- Сант сумын 6-10 настай хүүхдийн тоо 2019 онд нийт 109 байсан боловч 2017-2019 онд тус сумын бага сургуульд өөр сумдаас нэмж хүүхэд хамрагдан дунджаар 292 хүүхэд суралцсан байна. Гэтэл улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар тус суманд нэмж 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 240 хүүхдийн суудалтай бага сургууль нэмж барихаар төлөвлөсөн;

Хэнтий аймаг

- Хэрлэн суманд 2017-2019 оны дунджаар сургуулийн насны нийт хүүхдийн тоо 4771, үйл ажиллагаа явуулж буй 5 сургуулийн нийт хүчин чадал 2019 оны байдлаар 5838 суудал, нийт хамрагдсан хүүхдийн тоо 6394 байна. Батлагдсан хүчин чадлаас 556 хүүхэд илүү хамрагдсан байхад улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар тус суманд нэмж 13,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 1500 хүүхдийн суудалтай сургууль барихаар төлөвлөсөн. Хэрлэн сумын 5 сургууль 1 ээлжээр хичээллэх боломжтой байхад нийт 85 бүлэгт, 2708 хүүхэд 2 ээлжинд хичээллэдэг байна;

Төв аймаг

- Дэлгэрхаан суманд 320 хүүхдийн суудалтай сургуульд 2017-2019 онд дунджаар 215 хүүхэд хамрагдаж, хүчин чадалдаа бүрэн хүрээгүй байна. Гэтэл улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар тус суманд нэмж 1,100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 160 суудалтай сургууль барихаар төлөвлөсөн;

Нийслэл

- БЗД-ийн 44 дүгээр сургуулийн 640 суудалтай барилгын өргөтгөл төсөл, арга хэмжээ нь 2018 оноос дамжин хэрэгжиж байна. Тус сургуулийн одоогийн хүчин чадал нь 1284 ба өргөтгөлийн барилга ашиглалтад орсноор нийт 1924 суудалтай болохоор байна. Гэвч тус сургууль нь 3 ээлжээр хичээллэдэг бөгөөд 2017 онд 3618, 2018 онд 3840, 2019 онд 4206 хүүхэд хамрагдсан байгаагаас үзвэл 640 хүүхдийн хүчин чадалтай өргөтгөлийн барилга сургуулийн хэрэгцээг хангахааргүй байна. Өргөтгөлийн барилга 2019 онд ашиглалтад орох байсан боловч төсөвт өртөг нэмэгдэж, хугацаандаа хэрэгжих боломжгүй болсноос 2019-2020 оны хичээлийн жилд 20 бүлгийн 743 хүүхдийг түрээсийн байранд хичээллүүлж, түрээсийн төлбөрт 19.3 сая төгрөг зарцуулжээ.

- Чингэлтэй дүүргийн 24 дүгээр сургуулийн одоогийн барилга ашиглалтад ороод 56 жил болсон, 1200 хүүхдийн хүчин чадалтай байна. 450 суудалтай өргөтгөлийн барилга ашиглалтад орсноор нийт хүчин чадал 1650 болох боловч тус сургууль нь 3 ээлжээр хичээллэдэг бөгөөд 2016 онд 2942, 2017 онд 3129, 2018 онд 3264 хүүхэд хамрагдсан байгаагаас үзвэл баригдаж буй өргөтгөлийн барилга хэрэгцээг бүрэн хангахааргүй байна.

1.44 ЗТБХБС-ын 2011 оны 305 дугаар тушаалаар баталсан ЕБС-ийн барилгын төлөвлөлтийн дүрмийн 1.3.4-д “Тухайн хот, дүүрэг, аймаг, сум суурины хүн амын тоо, нягтрал, багшлах зохион байгуулалт, суралцагчдын эрүүл ахуйн нөхцөл зэргийг үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн хүчин чадлыг тодорхойлох нь зүйтэй. Тухайлбал: 320, 410, 520, 560, 640-н суралцагчтай байх нь ашиглалтад тохиромжтой”, 1.3.5-д “1000 хүн тутамд ногдох ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын суудлын тоог зөвлөмжийн 1 дүгээр хүснэгтэд үзүүлэв” гэж заасан байна.

Хүснэгт 5. Зөвлөмжийн дагуу байх хүчин чадал

Суралцагчдын насны ангилал	Хамрах хувь	1000 хүн тутамд
		Байвал зохих суудлын доод хэмжээ
6 нас	20	2
7-9 нас	100	22
10-аас 14 нас	100	45
15-18 нас	75	46

*6 настай хүүхдийн 80 хувь нь сургуулийн өмнөх насны байгууллагад хамрагдахаар тооцно.

1.45 Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй ЕБС-ийн одоогийн байгаа нийт бодит хүчин чадал барилга төлөвлөлтийн дүрмийн дагуу байвал зохих хүчин чадлаас доогуур байна.

Хүснэгт 6. ЕБС-ийн байвал зохих хүчин чадал, одоогийн байгаа хүчин чадал харьцуулалт /2020 оны байдлаар/

№	Дүүрэг	Нийслэлд оршин суугаа хүн амын тоо /6-17 нас/	Байвал зохих ЕБС-ийн хүчин чадал /суудлын тоогоор/	Одоогийн хүчин чадал	Зөрүү
1	БНД	6,168	5,311	3,995	1,316
2	БХД	867	746	880	(136)
3	БГД	46,547	39,995	33,957	6,038
4	БЗД	75,731	64,915	45,180	19,735
5	Налайх	8,570	7,395	5,892	1,503
6	СХД	69,195	59,447	26,906	32,541
7	СБД	29,741	25,566	29,007	(3,441)
8	ХУД	40,007	34,201	27,931	6,270
9	ЧД	30,978	26,699	14,900	11,799
	Нийт	307,804	264,275	188,648	75,627

1.46 Мөн зарим сумдын бага сургуулийн нийт хүчин чадлын талаас дээш хувьд нь бүлэг дүүргэлт хангалтгүй, хоосон байдалтай үргүй зардал гарган ажиллаж байхад тэдгээр сумдын ахлах сургуулиуд 2-6 дахин ачаалалтай байгаагаас үзвэл анхнаасаа сургуулийн насны хүн амын тоо, хэрэгцээ шаардлагад үндэслэж, сургуулийн хүчин чадал, ангиллыг оновчтой зохион байгуулаагүйг харуулж байна. Тухайлбал²¹,

- Архангай аймгийн Чулуут сумын 120 суудалтай бага сургуульд 21, 120 суудалтай ахлах сургуульд 675 буюу 6 дахин их хүүхэд хамрагдсан.
- Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нийт 135 суудалтай 2 бага сургуульд 44, 769 суудалтай ахлах сургуульд 1369 буюу 2 дахин их хүүхэд хамрагдсан.
- Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нийт 285 суудалтай 3 бага сургуульд 85, 760 суудалтай ахлах сургуульд 943 хүүхэд хамрагдсан.
- Говь-Алтай аймгийн Тонхил сумын 60 суудалтай бага сургуульд 15, 320 суудалтай бүрэн дунд сургуульд 419 хүүхэд хамрагдсан байна.

1.47 Үндэсний статистикийн хорооноос хийсэн хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцооноос үзэхэд сургуулийн насны хүүхэд 2025 он гэхэд 806,532, нэгдүгээр ангид шинээр элсэх хүүхдийн тоо 82,269 болж нэмэгдэх хандлагатай байгааг салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хүснэгт 7. Сургуулийн насны хүүхдийн 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо

Он	2015 он	2020 он	2025 он	2030 он	2035 он	2040 он	2045 он
6-16 насны хүүхдийн тоо	531,853	653,231	806,532	882,863	878,353	888,360	976,236
Зөрүү	121,378	153,301	76,331	-4,510	10,007	87,876	12,1378
Өсөлтийн хувь	-	22.8	23.5	9.5	-0.5	1.1	9.9
Нэгдүгээр ангид элсэн орох хүүхэд	60,183	76,442	82,269	80,275	79,984	87,626	104,400
Зөрүү	16,259	5,827	-1,994	-291	7,642	16,774	16,259
Өсөлтийн хувь	-	27.0	7.6	-2.44	-0.4	9.6	19.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

²¹ 2017-2019 оны дунджаар тооцоолов

Ерөнхий боловсролын сургуулиуд орчны шаардлагыг бүрэн хангаагүй, суралцагчийн сурах хэрэгцээнд дэмжлэг үзүүлэхүйц материаллаг орчин нөхцөлийг бүрэн бүрдүүлээгүй байна


1.48 МХЕГ-аас улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулсан сургуулиудын 25.0-30.0 хувийг хамруулан хийсэн шалгалтаар сургалтын орчинтой холбоотой дараах зөрчил, дутагдал 2017 онд 49.0 хувь, 2018 онд 49.0, 2019 онд 51.0 хувийг тус тус эзэлсэн байна. Үүнд:

- Сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулах шаардлага хангасан, стандартын барилга байгууламжгүй,
- Байгалийн ухааны хичээл²², англи хэлний хичээл явуулах шаардлага хангасан кабинет, лабораторигүй,
- Лаборатори, кабинетийн тоног төхөөрөмж шаардлага хангаагүй, хүрэлцээгүй,
- Сургуулийн норм стандартаас давсан ачаалал, анги танхимын хүрэлцээгүй байдлаас шалтгаалан кабинет, лабораторид төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хичээлийг зохион байгуулаагүй,
- Сургуулийн гадаад, дотоод орчны аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулаагүй.

1.49 БШУЯ болон НҮБ-ын хүүхдийн сангаас 2016 онд хамтран зохион байгуулсан “ЕБС-ийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийн өнөөгийн нөхцөл байдал”-д хийсэн судалгааны үр дүнгээс харахад нийт сургуулийн 54.0 хувь нь төвлөрсөн усан хангамжид холбогдсон бөгөөд эдгээр сургуулиуд нь ихэвчлэн Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд байршилтай байна. Нийт сургуулийн 47.0 хувь нь дотор байрлах бохирыг усаар зайлуулдаг ариун цэврийн өрөөтэй, 35.0 хувь нь гаднаа байрлах нүхэн жорлонтой, 18 хувь нь дотор, гадна ариун цэврийн байгууламжийг хавсарч хэрэглэдэг гэсэн үр дүн гарсан байна.

1.50 Харин 2019 оны байдлаар дотор байрлах ариун цэврийн өрөөтэй сургууль 75.5 хувийг, гадна нүхэн жорлонтой сургууль 24.5 хувийг эзэлж байгаа боловч дотор ариун цэврийн өрөөтэй сургуулийн тал хувь нь төвлөрсөн усан хангамжид холбогдоогүй, бохирыг соруулдаг хэвээр байна.

Дүрслэл 9. Төрийн өмчийн ЕБС-ийн хичээлийн байрны барилгын насжилт



Эх сурвалж: БШУЯ-ны статистик

1.51 Өнөөгийн байдлаар ерөнхий боловсролын сургуулиудад ашиглагдаж буй агуулах, багш, ажилчдын байр, биеийн тамирын заал, урлагийн заал зэрэг барилга 2017 онд 1186, 2018 онд 1178, 2019 онд 1238 байгаа бөгөөд төрийн өмчийн сургуулийн 84.5 хувь, хувийн өмчийн сургуулийн 81.2 хувь нь стандартын шаардлага хангасан зориулалтын барилгад үйл ажиллагаа явуулж байна.

1.52 2019 оны байдлаар төрийн өмчийн сургуулийн 892 хичээлийн байр байгаагаас 34.2 хувь нь 40-с дээш жил ашиглагдаж байгаа буюу ашиглалтын хугацаа дууссан байна.

1.53 Хэдийгээр сүүлийн арван жилд улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр сургуулийн барилга барих хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй холбоотойгоор 1-20 жил ашиглаж буй барилга багагүй хувийг эзэлж байгаа ч 11 сургууль 73-108 жил ашиглаж буй 14 хичээлийн байранд сургалтын үйл ажиллагаа явуулж байна²³. /Дэлгэрэнгүйг хавсралт 7-с үзнэ үү/

1.54 Зарим хуучин барилгад санхүүжилт батлагдаагүйгээс их засвар хийгээгүй, барилгын аюулгүй байдалтай холбоотой Мэргэжлийн хяналтын акталсан дүгнэлттэй 104 сургуулийн барилгад одоог хүртэл сургалтын үйл ажиллагаа явуулсан, зарим сургууль зориулалтын бус байранд хичээллэж байгаа нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд суралцах эрхийг зөрчиж байх тул зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөв. Үүнд:

Дорнод аймаг

- Хэрлэн суманд 1939 онд ашиглалтад орсон барилгыг 2016 онд актлагдсанаас хойш Хан-Уул цогцолбор сургууль үйл ажиллагаа явуулсаар байна.
- Гурванзагал сумын сургуулийн хичээлийн байр 1974 онд ашиглалтад орсноос хойш их засвар хийгдээгүй, аймгийн Мэргэжлийн хяналтын газраас их засварт оруулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан,

²² Хими, физик, биологи

²³ Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм БНБД 13-04-03-т тоосгон барилга 40 жил, модон барилга 30, төмөр бетон 50, канад модон барилгын ашиглалтын хугацааг 30 жил байхаар заасан.

- Хэрлэн сумын 1-р сургууль 1969 онд ашиглалтад орсон боловч их засварт орж байгаагүй. Сэргэлэн сумын сургууль 1960 онд ашиглалтад орж, МХГ-ын 2013 онд хийгдсэн их засварт оруулах шаардлага үүссэн дүгнэлт гарсан боловч их засвар хийгдээгүй;
- Баянтүмэн сумын сургууль 1979 онд ашиглалтад орсноос хойш их засварт орж байгаагүй, барилга байгууламжийн ашиглалтын талаар МХГ-ын дүгнэлт гаргуулаагүй;
- Нийслэл**
 - БЗД-ийн 85, 87 дугаар сургууль, БХД-ийн Хангай 1, Налайх дүүргийн 103 дугаар сургуулиуд цэргийн ангийн байранд, СХД-ийн Ирээдүй цогцолбор 2 дугаар бага сургууль цэцэрлэгийн байранд үйл ажиллагаа явуулж байна.
 - Чингэлтэй дүүргийн 112 дугаар сургуулийн хичээлийн байр нь 1912 онд сүм, хийдийн зориулалттай баригдсан 108 жилийн настай, 2010 онд актлагдсанаас хойш үйл ажиллагаа явуулсаар байна.
 - ХУД-ийн 10 дугаар, БГД-ийн 19 дүгээр сургуулийн барилгад үйл ажиллагаа явуулахыг зогсоох тухай акт 2010, 2013, 2015 онуудад удаа дараа гарсан боловч үйл ажиллагаа явуулсаар байгаа бөгөөд 2019 онд төсвийн хөрөнгө оруулалтаар дээрх сургуулиудын барилгыг шинээр барьж эхэлсэн.
- Баян-Өлгий аймаг**
 - Цэнгэл сумын 2 дугаар сургуулийн байр дотуур байрны, Дэлүүн сумын 2-р сургуулийн байр фермийн, хувийн хэвшлийн "Руханият" сургууль ахуйн үйлчилгээний зориулалттай барилгад үйл ажиллагаа явуулж байна.
 - Цагааннуур тосгоны сургуулийг 2017 онд актласнаас хойш сургуулийн дотуур байранд хичээллэж байгаа бөгөөд Улаанхус сумын 2 дугаар сургууль анги танхим хүрэлцээгүйгээс дотуур байрны зориулалтаар баригдсан барилгад хичээллэдэг байна.
- Дорноговь аймаг**
 - Замын-Үүд сумын лаборатори 1 дүгээр сургууль нь 1956 онд ашиглалтад орсон, 64 жилийн насжилттай. Барилгын чанар байдал, ашиглалтын талаар аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2012, 2014, 2018 онд сургуулийн "А" корпусын барилгыг акталж шинээр барих шаардлагатай гэсэн дүгнэлт гаргасан байна. Тухайлбал: Барилгын А корпусын 1 давхрын хичээлийн танхимд 2014 онд дүүжин таазыг цөмлөн 30-40 кг жинтэй шавар нурсан, сургуулийн орчинд эрсдэлд өртөх аюултай нөхцөл байдал үүссэн,
- Дундговь аймаг**
 - Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн хичээлийн А байранд 2018 онд, Хүмүүнлэг сургуулийн хичээлийн байранд 2016 онд, Сайхан-Овоо сумын сургуулийн хичээлийн байранд 2018 онд барилга байгууламжид тавигдах шаардлага, ашиглалтын хэвийн нөхцөл найдвартай ажиллагааг хангахгүй болсон тухай МХГ-ын улсын байцаагчийн барилгын чанар, төлөв байдлын дүгнэлт гарсан боловч тус барилгуудад хичээл, сургалтын үйл ажиллагаа явагдсаар байна. Эрдэнэдалай сумын хичээлийн А, В байр, Дэлгэрцогт сумын 50 хүүхдийн хүчин чадалтай бага сургууль, Говь-Угтаал сумын дунд сургуулиуд ашиглалтад орсон оноос хойш огт их засвар хийгдээгүй байна.
- Говьсүмбэр аймаг**
 - Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 1, 2 дугаар хичээлийн барилга нь 1955-1956 онд ашиглалтад орсон, хичээлийн 2 дугаар байрыг аймгийн МХГ-ын Барилгын хяналтын улсын байцаагчийн актаар сургалтын үйл ажиллагааг явуулахыг бүр мөсөн зогсоосон, Шивээговь сумын 3-р сургууль нь 1989 онд Оросын цэргийн ангийн түр хоргодох байрны зориулалтаар баригдсан барилгад үйл ажиллагаа явуулж байна.
- Ховд аймаг**
 - Чандмань сумын сургуулийн спорт заалны дээвэрт байршуулсан харилцаа холбооны антен унаж барилгын даацын хананд цууралт үүсгэсэн тул холбогдох байгууллагад уламжилсан ч өнөөг хүртэл арга хэмжээ аваагүй,
 - Жаргалант сумын 7 дугаар сургуулийн хичээлийн барилга нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2011 онд ашиглалтад орсноос хойш хана, цонх, дээвэр, цонхны амлагаа, булангийн уулзвараар дулааны алдагдал ихтэй талаар удаа дараа холбогдох газруудад уламжилж 2018 онд их засвар хийгдсэн боловч дулааны алдагдал буураагүй, улсын байцаагчийн 2019 оны дүгнэлтээр "сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламж", Барилгын норм дүрэм БНБДИ-66-88-ын 8.2 дахь заалтыг зөрчиж байгаа тухай дүгнэлт гарсан;
- Орхон аймаг**
 - Тус аймгийн 7 дугаар сургууль нь 1974 онд ашиглалтад орсон цэргийн хуарангийн зориулалттай байранд, 1 дүгээр сургуулийн хичээлийн 2 дугаар байр нь 1985 онд ашиглалтад орсон цэцэрлэгийн зориулалттай барилгад үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн МХГ-аас 7 сургуулийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар хийж эрүүл, аюулгүй байдлыг хангуулах дүгнэлт гарсан боловч үйл ажиллагаа явуулж байна.
- Төв аймаг**
 - Аймгийн төвийн 5 дугаар сургууль нь "Барилга угсралтын контор"-ын барилгыг 1992 онд засварлан үйл ажиллагаа явуулж байна.
- Увс аймаг**
 - Улаангом сумын 960 суудалтай 1 дүгээр сургуулийн хичээлийн 1 дүгээр байр 1965 онд ашиглалтад орж, 2016, 2018 онд мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт тус тус гарсан боловч одоо болтол ашигласаар байна.
- Архангай аймаг**
 - Эрдэнэбулган суманд 1957 онд ашиглалтад орсон 2 дугаар сургуулийн барилгад 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 158.0 сая төгрөгийн их засвар хийсэн боловч уг барилгыг 2020 онд буулгаж улсын төсвийн 8.7 тэрбум төгрөгөөр шинэ байр барьж ашиглалтанд оруулсан байна.

ЕБС-иудад суралцагчдын байгалийн шинжлэх ухаан, гадаад хэлний хичээлийн сурах хэрэгцээнд дэмжлэг үзүүлэхүйц орчин бүрэн бүрдээгүй байна

1.55 БСШУСС-ын 2018 оны А/762 дугаар тушаалаар "Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори байгуулах, ашиглах нийтлэх журам"-ыг баталсан бөгөөд улсын хэмжээнд 2019 онд үйл ажиллагаа явуулж буй нийт сургуулийн 57.7 хувь нь химийн, 50.6 хувь нь физикийн, 70.1 хувь нь биологийн, 88.9 хувь нь англи хэлний шаардлага хангасан кабинет, лабораторигүй байна.

1.56 Харин кабинет, лабораторитой сургуулийн хувьд анги танхимын хүрэлцээгүй байдлаас шалтгаалан хими 65.0, физикийн 60.2, биологийн 64.3, англи хэлний 79.9 хувь нь төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хичээлүүд ороогүй, кабинет, лабораторийн зориулалтын тоног төхөөрөмжүүдийг ашиглаагүй байна.

1.57 Улсын хэмжээнд 2019 онд үйл ажиллагаа явуулсан 820 сургуульд нийт 726 биеийн тамирын заал байгаагийн 89.5 хувь нь төрийн, 10.5 хувь нь хувийн өмчийн сургуульд харьяалагдаж байгаа бөгөөд ачаалал өндөртэй сургуульд биеийн тамирын хичээлийн 1 цагт 2 анги давхар хичээллэж байна. Нийт 190 ЕБС спорт заалгүйгээс ААНБ, бусад сургуулийн спорт заал түрээсэлж биеийн тамирын хичээл орж байгаагийн 46.0 хувь нь хувийн өмчийн сургууль байна.

1.58 УИХ-ын 2016 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд сургуулийн аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр дараах зорилтыг тусгажээ. Үүнд:

- 3.2.7.1-т ЕБС-ийн орчны аюулгүй байдлын шаардлагыг боловсруулан мөрдүүлэх;
- 3.2.7.2-т Судалгаанд үндэслэн сургуулийн аюулгүй орчныг бүрдүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх,

1.59 БСШУСС-ын “Дунд хугацааны төлөвлөгөө батлах тухай” 2018 оны А/398 дугаар тушаалаар ЕБС-ийн аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр 2018-2020 онд хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг баталж, хүүхдийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал,

- Дунд хугацааны төлөвлөгөөний 8-д хэрэгжүүлэхээр заасан “Зам тээврийн осол гэмтэл, нас баралтын талаар нөхцөл байдлын судалгаа хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах” ажлын хүрээнд Замын цагдаагийн албатай хамтран сургуулийн аюулгүй орчныг нэн тэргүүнд сайжруулах шаардлагатай 50 сургуулийн жагсаалт гарган 850.0 сая төгрөгийн хөрөнгөөр 16 сургуулийн орчныг гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагч, туузан хашлага, LED самбартай болгосон байна.
- Дунд хугацааны төлөвлөгөөний 10-т хэрэгжүүлэхээр заасан “ЕБС-ийн автобусны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах” ажлын хүрээнд БШУЯ-аас 2019 онд нийт 642.8 сая төгрөгийн өртөгтэй 5 автобусыг тусгай хэрэгцээт боловсролын сургуульд нийлүүлсэн байна.

1.60 Боловсролын салбар 2019 оныг хүртэл сургуулийн орчны аюулгүй байдлын стандартгүй байсан бөгөөд дээрх төлөвлөгөөний 3-т заасны дагуу АХБ-ны санхүүжилтээр БСШУСЯ-нд 2016-2019 онд хэрэгжүүлсэн “Баруун бүсийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд ЕБС-ийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS 6782:2019 стандартыг боловсруулж 2019 оны 9 дүгээр сард батлуулсан²⁴ байна.

1.61 Тус стандартын 8.1²⁵-т заасны дагуу улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт сургуулийн 80.4 хувь нь гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээг хийж, урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулсан боловч стандарт 2019 оны 9 дүгээр сард батлагдсан, 2020 оны 1 дүгээр сараас Ковид-2019 цар тахал гарсан зэргээс шалтгаалан эрсдэлийн үнэлгээг улирал тутамд хийгээгүй, урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна.

1.62 ЕБС-иуд анги танхимын хүрэлцээгүй байдлаас шалтгаалан өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан дотоод тохижилт, зохион байгуулалт хийж анги танхим нэмэх замаар сургуулийн батлагдсан хүчин чадлыг нэмэгдүүлж байгаа нь сургуулийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS 6782:2019 стандартын 6.5.1²⁶ гэсэн заалттай нийцэхгүй, сурагчдын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна.

Шинээр баригдсан сургуулийн батлагдсан хүчин чадлаас доогуур тооны сандал, ширээ нийлүүлсэн байна

1.63 БШУЯ-ны хөрөнгө оруулалтын гүйцэтгэлээс үзэхэд 2017 онд 7,004.5 сая, 2018 онд 6,797.2 сая, 2019 онд 8,602.7 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг сургуулиудад нийлүүлсэн боловч санхүүжилтийн дутмаг байдлаас шалтгаалан шинээр ашиглалтад орсон сургуульд сандал, ширээ нийлүүлэхдээ бүрэн хэмжээнд, батлагдсан хүчин чадал буюу суудлын тоонд нийцүүлэн нийлүүлээгүй байна. Үүнээс 2017-2019 онд шинээр ашиглалтад орсон сургуульд сандал нийлүүлсэн байдлыг түүврээр авч үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 8. Шинээр ашиглалтад орсон сургуульд нийлүүлсэн сандал /суудлын тоогоор/

²⁴ Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны С/40 дүгээр тушаалаар баталж, 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс мөрдөгдсөн.

²⁵ 8.1 Сургуулийн дотоод хяналтын зөвлөл, сурагчдын өөрийн удирдлагын байгууллага болон эцэг эх, асран хамгаалагчийн зөвлөл хамтран сургуулийн гадаад, дотоод орчны аюулгүй байдлын зураглал гарган эрсдэлийн үнэлгээг улирал тутам хийж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ

²⁶ 6.5.1 Барилгын төлөвлөлтийн норм, дүрмийн дагуу баригдсан өрөө, тасалгааны зориулалтыг өөрчлөхийг хориглоно

№	Сургуулийн нэр	Сум, дүүрэг	Ашиглалтад орсон он	Хүчин чадал	УТХО-аар нийлүүлсэн	Дутуу зөрүү
1	133 дугаар сургууль	БЗД	2017	640	440	200
2	73 дугаар сургууль	БЗД	2017	960	888	72
3	38 дугаар сургууль	БГД	2017	1500	1350	150
4	13 дугаар сургуулийн өргөтгөл	БГД	2019	320	160	160
5	143 дугаар сургууль	СХД	2019	640	320	320
6	23 дугаар сургуулийн өргөтгөл	ЧД	2019	320	160	160
7	50 дугаар сургууль	ЧД	2019	450	224	226
Эх сурвалж: БШУЯ						

1.64 БШУЯ 2017-2019 онд “Сурагчийн ширээ ба сандал” MNS6582:2016²⁷ стандартын дагуу боловсруулсан техникийн тодорхойлолтын хүрээнд сурагчийн ширээ, сандлыг захиалж, нийлүүлсэн боловч чанарын шаардлага хангаагүй, амархан эвдэрч засах боломжгүй болдог, зарим сургуульд нийлүүлсэн лабораторийн тоног төхөөрөмж ашиглалтгүй байх зэрэг зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Баян-Өлгий аймгийн Өлгий сумын лаборатори 2 дугаар сургуульд 2018 онд УТХО-аар нийлүүлсэн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн ширээ сандал, самбар хангалттай хүртээмжтэй биш, ширээ сандлуудын чанар тааруу, тогтмол засварлан хэрэглэсэн, Өлгий сумын 10 дугаар сургуульд 2019 онд УТХО-аар нийлүүлэгдсэн тавилга, тоног төхөөрөмжүүд чанарын шаардлага хангахгүй, эвдэрч хугарсан,
- Дорноговь аймгийн Сайншанд сумын 3 дугаар сургуулийн бага сургуульд 2019 онд шинээр 233.6 сая төгрөгийн тавилга эд хогшил нийлүүлэгдсэн боловч зарим ангийн ширээ сандал чанарын шаардлага хангахгүй, нийлүүлэгдээд удаагүй эвдэрсэн тул тавилгыг бэлтгэн нийлүүлэгчээр солиулсан;
- Хэнтий аймгийн хэмжээнд 6 настанд зориулагдсан ширээний 31.0 хувь, сандлын 32.0 хувь шаардлага хангахгүй;
- Нийслэлийн БЗД-ийн 133 дугаар сургуульд “Долоон болдог” ХХК-ийн нийлүүлсэн нийт 25.0 сая төгрөгийн ширээ, сандал, БЗД-ийн 14 дүгээр сургуульд “Долоон болдог” ХХК, “Анун” ХХК, “Змен” ХХК, “Пи пи пи эм жи эл” ХХК-ийн нийлүүлсэн нийт 154.8 сая төгрөгийн тавилга эд хогшил чанарын шаардлага хангахгүй, БГД-ийн 141 дүгээр сургуульд “Бест хаалга” ХХК-ийн нийлүүлсэн 3.3 сая төгрөгийн тавилга эд хогшил ашиглалтгүй.
- Говьсүмбэр аймгийн Баянтал сумын дунд сургуульд 2016 онд ахлах ангид ашиглагдах физикийн лабораторийн хэрэглэгдэхүүн нийлүүлсэн боловч тус сургууль ахлах ангигүй тул одоог хүртэл ашиглалтгүй, төсвийн хөрөнгө үр ашиггүй болсон байна.

1.65 ЕБС-ийн сургалтын менежер, захирал, аймгийн Боловсролын газар зэрэг шат шатны албан тушаалтан, байгууллагын хяналт хангалтгүйгээс БШУЯ-ны БУМС-д зарим мэдээлэл иж бүрэн бус, зөрүүтэй бүртгэгдсэн байгаа нь уг цахим системийн ач холбогдлыг бууруулах, салбарын яамыг бодит бус мэдээллээр хангаж нөхцөл байдалд үнэн зөв дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодорхойлох боломжийг хязгаарлах эрсдэлтэй байна.

- Сургуулийн орчны статистик мэдээнд зарим сургуулийн нормт хүчин чадлыг 1-2 дахин нэмэгдүүлж зөрүүтэй илэрхийлсэн байна. Тухайлбал, 2019 оны нийт ЕБС-ийн нормативт хүчин чадал бодитоор 459,890 суудал байхад статистик мэдээгээр 486,454 суудалтай гэж 16,564 суудлаар зөрүүтэй бүртгэсэн. Үүнийг хүснэгтээр харуулбал,

Хүснэгт 9. Нормативт хүчин чадлыг бодит бус илэрхийлсэн сургууль

№	Сургуулийн нэр	Байршил	Өмчийн хэлбэр	Хүчин чадал /хүүхдийн тоо/		Зөрүү
				Батлагдсан	Статистик	
1	Аварга	Нийслэл, Хан-Уул	Хувийн	800	1600	800
2	Орхон хасу	Нийслэл, Хан-Уул	Хувийн	640	2920	2280
3	28-р сургууль	Нийслэл, Баянгол	Улсын	1640	2820	1180
4	97-р сургууль	Нийслэл, Баянзүрх	Улсын	960	1200	240
5	Баян-Уул сумын бүрэн дунд сургууль	Дорнод, Баян-Уул	Төрийн	640	1140	500
6	2-р сургууль	Өвөрхангай, Арвайхээр	Төрийн	1080	1660	580
7	Хужирт сумын сургууль	Өвөрхангай, Хужирт	Төрийн	952	1392	440
8	Баян-Овоо сумын сургууль	Баянхонгор, Баян-Овоо	Төрийн	160	320	160
8	Мандал бага сургууль	Баянхонгор, Мандал	Төрийн	50	120	70
9	Хүрээмарал дунд сургууль	Баянхонгор, Хүрээмарал	Төрийн	240	410	170
10	Ерөнхий боловсролын 1-р сургууль	Баян-Өлгий, Алтай	Төрийн	360	640	320
11	Алтанцөгц сумын бага, дунд сургууль	Баян-Өлгий, Алтанцөгц	Төрийн	320	640	320
12	Өндөршил сумын сургууль	Дундговь, Өндөршил	Төрийн	320	640	320

Эх сурвалж БШУЯ, аудитын судалгаа

²⁷ Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2016 оны 12 дугаар тогтоолоор баталсан

Салбарын багш, ажилтны ажлын байрны эрэлт хэрэгцээг тухай бүр тодорхойлоогүй байна

1.66 Ерөнхий боловсролын салбарт 2019-2020 оны хичээлийн жилд улсын хэмжээнд нийт 51,550 багш, ажилтан ажиллаж байгаа бөгөөд 62.2 хувийг багш, 37.8 хувийг захиргаа, үйлчилгээ, туслах ажилчид эзэлж байна. Өмчийн хэлбэрээр нь үзвэл нийт багшийн 89.7 хувь нь төрийн өмчийн, 10.3 хувь нь төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байна.


Хүснэгт 10. ЕБС-ийн боловсон хүчин /2017-2020 оны хичээлийн жил/

Хичээлийн жил	Сургуулийн тоо	Нийт багш, ажилтны тоо	Үндсэн багш	Үүнээс:		Захирал, дэд, гүйцэтгэх	Сургалтын менежер	Багшаас бусад ажилтан	Бусад багш	Нийгмийн ажилтан	Номын санч
				Төрийн өмчийн	Төрийн бус өмчийн						
2017-2018	798	47,991	29,242	26,742	2,500	828	1,425	13,771	1,364	741	620
2018-2019	803	49,441	30,411	27,615	2,796	843	1,469	13,904	1,401	767	646
2019-2020	820	51,550	32,085	28,767	3,318	849	1,530	14,236	1,375	802	673


Эх сурвалж: БШУЯ-ны статистик мэдээ

1.67 Нийт үндсэн багшийн насны бүтцийг авч үзвэл 30-39 насны багш дийлэнх буюу 35.4-36.0 хувийг, 60 ба түүнээс дээш насны багш хамгийн бага буюу 0.7-1.2 хувийг эзэлж байгаа бөгөөд мэргэжлийн зэргийг 2019 оны байдлаар авч үзэхэд бакалавр зэрэгтэй багш 23,722 буюу 73.9 хувь, магистр зэрэгтэй багш 4,767 буюу 14.9 хувь, докторын зэрэгтэй багш 18 багш буюу 0.1 хувийг тус тус эзэлж байна.

Дүрслэл 10. Үндсэн багш насны бүлгээр



Дүрслэл 11. Мэргэжлийн зэрэг



Эх сурвалж: БШУЯ-ны статистик мэдээ

1.68 Ерөнхий боловсролын сургуулиуд Боловсролын удирдлагын мэдээллийн систем болон салбарын статистик мэдээнд ажиллавал зохих багш, шаардлагатай багшийн тоог иж бүрэн, үнэн зөв тайлагнадаггүй, боловсролын газар болон БШУЯ-ны зүгээс мэдээллийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангуулж ажиллаагүй, салбарын хэмжээний хүний нөөцийн нэгдсэн суурь мэдээлэлгүй байгаа нь хүний нөөцийн нэгдсэн бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэх эрсдэлтэй байна. Тухайлбал: /106 маягтын “Ажиллавал зохих багш” хэсэгт/

- 2017-2018 оны статистик мэдээнд 162 сургууль, 2018-2019 оны статистик мэдээнд 22 сургууль, 2019-2020 оны статистик мэдээнд 99 сургууль мэдээлэл оруулаагүй;
- 2017-2018 онд 798 сургуульд 26,942 багш, 2018-2019 онд 803 сургуульд 44,440 багш, 2019-2020 онд 820 сургууль 31,007 багшаар тусгагдсан;
- 2018-2019 онд шаардлагатай багшийн тоог 14,029 гэж тусгасан боловч 196 маягтад 17,330 гэж зөрүүтэй тусгасан

1.69 БШУЯ-ны статистик мэдээнээс үзэхэд 2017-2018 онд 156 сургуульд 356 мэргэжлийн бус багш, 2018-2019 онд 113 сургуульд 209 мэргэжлийн бус багш, 2019-2020 онд 85 сургуульд 146

мэргэжлийн бус багш ажиллаж байсан бөгөөд үүний 84.5 хувь нь төрийн өмчийн, 15.5 хувь нь төрийн бус өмчийн сургуульд ажиллаж байна. Хичээлийн жилээр нь авч үзвэл жил ирэх тусам төрийн өмчийн сургуульд ажиллаж буй мэргэжлийн бус багшийн тоо буурсан байна.


1.70 Аудитын түүвэрт хамрагдсан сургуулиудад ажиллаж буй 244 багш мэргэжлийн бус, мэргэжлийн индекс зөрүүтэй, номын санч, нийгмийн ажилтан Бага дунд боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д “Багш нь багшлах эрхтэй байна”, 21.3-т “Багш бус мэргэжлийн хүн заах арга зүйн сургалтад хамрагдсаны дараа багшлах эрх авна” гэсэн заалтыг хангаагүй байна. Тухайлбал,

- Баянхонгор аймаг**
 - Аймгийн 29 сургуулиас 25 сургуульд 1-4 багш буюу нийт 33 багш, 2 номын санч мэргэжлийн бус байна.
- Баян-өлгий аймаг**
 - Аудитад хамрагдсан 8 сургуулийн номын санчаар бага анги, англи хэлний багш, нягтлан бодогч, инженер мэргэжилтэй хүн ажилладаг.
- Дорноговь аймаг**
 - Хатанбулаг, Хөвсгөл суманд хими, физик, Алтанширээ суманд физикийн хичээл заах багшгүйгээс хөтөлбөрийн дагуу хичээл ороогүй, 18 нийгмийн ажилтны 11 нь багш мэргэжилтэй, 8 сургуульд мэргэжлийн бус номын санч ажиллаж байна.
- Говьсүмбэр аймаг**
 - Аудитаар 4 сургуулийн номын санч, 2 сургуулийн нийгмийн ажилтан нь мэргэжлийн бус байна.
- Хэнтий аймаг**
 - Тус аймагт 2017-2019 онд дунджаар 471 багш ажиллаж байсан ба мэргэжлийн багшийн хангалт аймгийн түвшинд 75 хувьтай байна.
- Ховд аймаг**
 - ЕБС-д 24 номын санч ажиллаж байгаагаас 13 нь багш мэргэжилтэй, 4 бусад мэргэжлийн байна.
- Сэлэнгэ аймаг**
 - Баянгол сум болон Шаамар сумын Дулаанхаан тосгон, төрийн бус өмчийн Мандал сумын Билиг ДБ сургуулиуд мэргэжлийн нийгмийн ажилтангүй, Баянгол, Цагааннуур, Шаамар, Сайхан сумын 1-р, Мандал сумын 1, 3-р болон, Шаамар сумын Дулаанхаан тосгон, төрийн бус өмчийн Билиг ДБ зэрэг сургуулиуд мэргэжлийн номын санчгүй байна.
- Орхон аймаг**
 - 2016-2019 оны байдлаар дуу хөгжим, технологи, физик, орос хэлний багш жил бүр дутагдалтай байсан ба цаашдаа физик, хими, дуу хөгжмийн багшийн хүрэлцээ хангалтгүй болохоор байна. Мөн “иргэний ёс зүйн боловсрол” хичээлийг шинээр заахаар төлөвлөгөө, хөтөлбөрт тусгасан хэдий ч тухайн судлагдахуун заах багш бэлтгэгдээгүй, нийгмийн ухааны багш заахаар тусгасан байна.

1.71 Мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээгүйгээс зарим ЕБС-д тэтгэврийн насны багш нарыг ажиллуулж байна. Тухайлбал,

- Булган аймаг**
 - Аудитын түүвэрт хамрагдсан 13 сумын сургуулийн дутагдалтай багшийн тоог гаргахад сүүлийн 3 жилийн байдлаар давхардсан тоогоор 15 багш байна. Үүнээс тэтгэвэр тогтоолгосон болон тэтгэвэрт гарсан 10 гаруй багш нарыг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж байна.
- Говьсүмбэр аймаг**
 - Аймгийн хэмжээнд нийт 24 багш дутагдалтай бөгөөд дутагдалтай багшийн орон тоог нөхөхдөө тэтгэврийн багшийг ажиллуулах болон бага ангийн багшийг ээлжээр хичээллүүлж байна.
- Дундговь аймаг**
 - Тус аймагт тэтгэвэр тогтоолгосон 15 багш ажиллаж байгаагаас 10 нь сумдын сургуулиудад ажиллаж байна.

Дүрслэл 12. Тэтгэлгээр суралцагчдын харьцуулалт



Эх сурвалж: МУБИС

боловсон хүчин бэлтгэгдэж байна.

1.72 Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7²⁸, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3²⁹-т заасны дагуу МУЗГ-ын 2014 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын 4.1.5-т “төрийн өмчийн их, дээд сургуульд багш мэргэжлээр элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийг 70 хувь, 751-ээс дээш оноо авсан бол сургалтын төлбөрийг 100 хувь хичээлийн жилийн эхний улиралд; суралцагч 3.0 болон түүнээс дээш голч оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийг үргэлжлүүлэн 100 хувь” гэж заасны дагуу 16 их сургуульд 70-100 хувийн тэтгэлэгтэйгээр багшлах

²⁸ Орон нутгийг боловсон хүчнээр хангах, чухал хэрэгцээтэй мэргэжилтэн бэлтгэх, суралцагчийн авьяасыг дэмжих, орлого багатай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боловсрол эзэмшихэд зориулж сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох бөгөөд тэдгээрийг олгох журмыг Засгийн газар батална.

²⁹ Багш мэргэжлээр дээд боловсрол олгох их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт 6 сарын хугацаатай дадлагажигч багшаар ажиллах агуулгыг багтаана. Дадлагажигч хөдөө орон нутагт ажиллавал тэтгэлэг олгож болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

Хүснэгт 11. 70-100 тэтгэлэгтэйгээр төгссөн төгсөгчдийн тоо, санхүүжилтийн дүн /2017-2019 он/

№	Үзүүлэлт	2017 он	2018 он	2019 он	3 жилийн дүн
1	Төгсөгчдийн тоо	565	282	268	1,115
2	Санхүүжилт /сая. төг/	523.5	351.5	704.4	1,579.40

Эх сурвалж БШУЯ-ны Зээлийн сан

1.73 Гэвч МУБИС-аас гаргасан судалгаагаар 2014-2018 онуудад нийт 3415 суралцагч өндөр оноогоор тэтгэлэгтэй хөтөлбөрт хамрагдан элсэж, 834 суралцагч багш мэргэжлээр төгссөнөөс 513 суралцагч боловсролын салбарт ажиллаж байгаа нь тэтгэлэг олгож буй зорилготой нийцээгүй, үр ашиг багатай хөрөнгө оруулалт болсныг харуулж байна.

1.74 БШУЯ нь 2020 оны 7 дугаар сард хийсэн судалгааг эс тооцвол 2016-2020 хичээлийн жилд салбарын багш ажилтны ажлын байрны эрэлт хэрэгцээг тухай бүр тодорхойлоогүй, хүний нөөцийн нэгдсэн бодлого төлөвлөгөө боловсруулаагүй, дунд хугацаанд шаардлагатай багшийн ажлын байр, багш бэлтгэдэг их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөр болон суралцагч, төгсөгчдийн ажил эрхлэлтийн улсын хэмжээний иж бүрэн судалгаанд суурилсан төлөвлөлт, зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн гэх хангалттай нотлох баримт байхгүй байна.

1.75 Энэ нь Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6³⁰ заалт, Засгийн газрын 2017 оны 267 дугаар тогтоолоор баталсан “БСШУСЯ-ны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн 2.4.5-д заасан “... салбарын хүний нөөцийн болон мэдээллийн технологийн үйл ажиллагааг зохицуулах, статистикийн мэдээлэл нэгтгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчийг мэдээллээр хангах,” стратегийн зорилтын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаа хангалтгүй байна

1.76 Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг 5 жил тутамд батлах”, 7 дугаар зүйлийн 7.5-д “багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж заасан хэдий ч Засгийн газар, салбарын яамны зүгээс батлаагүй, 7 дугаар зүйлийн 7.1³¹-д “... багшийн хөгжлийн төвтэй байна”, 7.3³²-д “багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд байгууллагын нийт хувьсах зардлын хоёр хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулна” гэсэн заалтууд бүрэн хэрэгжихгүй байна. Тухайлбал:

Нийслэлд

- Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1.333-т заасны дагуу ЕБС бүр “Багшийн хөгжлийн төв”-тэй байх заалтын хүрээнд:
 - 2017-2019 оны байдлаар төрийн өмчийн 140 сургуулийн 82 буюу 58.7 хувь нь багшийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө баталж, түүний хэрэгжилтийг үнэлж, багшийн өрөөг тохижуулах, их дээд сургуульд суралцахад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх зэргээр хэрэгжсэн байна.
 - Харин үлдсэн 58 буюу 41.4 хувь нь “Багш хөгжүүлэх төв”-тэй хэдий ч баталсан төсөв хөрөнгөгүй, үйл ажиллагаагаа бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Төрийн бус өмчийн сургуулиуд “Багш хөгжлийн төв”-тэй эсэх талаарх тоо мэдээ, үйл ажиллагааны тайлан байхгүй байна.

Дархан-Уул аймагт

- Ерөнхий боловсрол олгож байгаа сургуулиудын 44 хувь нь багшийн хөгжлийн төвгүй байна.

1.77 Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2³⁴-д заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга, ИТХ-ын Тэргүүлэгчдээр дэд хөтөлбөр батлуулж тодорхой хэмжээний сургалтуудыг зохион байгуулж байгаа хэдий ч бодлого хэрэгжүүлж буй орон нутгийн түвшинд

³⁰ Боловсролын тухай хуулийн 28.1.6. удирдах ажилтан, багшийг нэгдсэн бодлого, тодорхой чиглэлээр бэлтгэх, давтан сургах, тэдний нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, энэ талаар гарсан шийдвэрийн биелэлтийг хангах;

³¹ Бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь багшийн хөгжлийн төвтэй байна.

³² Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын нийт хувьсах зардлын хоёр хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулна.

³³ 3.1.3. “багшийн хөгжлийн төв” гэж багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжихөд шаардлагатай хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж бүхий орчинг;

³⁴ Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 5.2. Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг үндэсний түвшинд багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, байгууллагын түвшинд захирал, сургалтын менежер, эрхлэгч, арга зүйч, сонирхлын бүлгийн түвшинд хамтын удирдлагын нэгдэл, багш өөрөө хэрэгжүүлнэ.

тус хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах, цаашид авах арга хэмжээг хэрхэн тодорхойлох, мэдээллээр хангах асуудал дутмаг байна.

1.78 БШУС-ын 2017 оны 2/287 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-ын 2.2³⁵-т “Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад эхний болон хоёр, гурав, дөрөв, тав, арав дахь жилдээ ажиллаж байгаа багш, эхний болон тав, арав дахь жилдээ ажиллаж байгаа ажилтныг хамруулна” гэж заасны дагуу 2017-2019 онуудад нийт 2,285.4 сая төгрөг зарцуулж 19,705 багш, ажилтнуудыг сургалтад хамруулсан байна.

Хүснэгт 12. Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад хамрагдсан багш нарын тоон мэдээлэл /2017-2019 он/

Мэргэжил	Он	2017			2018				2019		
	Сургалтын ангилал	эхний жил	5 дахь жил	10 дахь жил	эхний жил	5 дахь жил	10 дахь жил	ангилалагүй	эхний жил	5 дахь жил	10 дахь жил
Нийт /багш/	Төлөвлөгөө	1,854	1,684	1,566	2,624	2,074	1,814	441	3,165	1,957	1,482
	Гүйцэтгэл	1,453	1,280	1,340	1,900	1,501	1,489	393	2,068	1,523	1,224
	Хувиар	78.4	76.0	85.6	72.4	72.4	82.1	89.1	65.3	77.8	82.6
Нийт /ажилт/	Төлөвлөгөө	405	187	127	595	248	134		428	262	152
	Гүйцэтгэл	280	139	88	412	155	93		258	179	111
	Хувиар	69.1	74.3	69.3	69.2	62.5	69.4		60.3	68.3	73.0

Эх сурвалж: БШУЯ-ны Бага, дунд боловсролын газар

1.79 Цаашид тухайн орон нутгийн боловсролын байгууллага, сургууль, багшийн зүгээс өөрсдийн сурагчдын сурлагын чанарын үнэлгээний дүнд тулгуурлан сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, мэргэжил дээшлүүлэх сургалт-арга зүйн байгууллагад захиалга өгч, санхүүжүүлэх замаар багшийн хөгжилд зарцуулж буй хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх нь зохистой байна.

1.80 Монгол Улсад нийт 47 их, дээд сургууль багш бэлтгэж байгаа бөгөөд төрийн өмчийн 10, төрийн бус өмчийн 37 их, дээд сургууль байна. Боловсролын удирдлагын мэдээллийн системд 2020 оны байдлаар бүртгэгдсэн 29,688 багшийн 50.5 орчим хувь буюу 14,981 нь МУБИС-ийг төгссөн байна.

Хүснэгт 13. Багш нарын төгссөн их, дээд сургууль

№	Их, дээд сургууль	Нийт багш	Үүнээс, улсын дүн		Нийт дүнд эзлэх хувь
			бакалавр	магистр	
1	Багшийн дээд сургууль-МУБИС	14,981	14,322	659	50.5
2	Монгол Улсын Их сургууль-МУИС	2,461	2,281	180	8.3
3	Ховд МУИС-ийн салбар сургууль-МУБИС	2,006	1,911	95	6.8
4	Архангай Багшийн коллеж-МУБИС	1,271	1,262	9	4.3
5	Гурван -Эрдэнэ багшийн дээд сургууль	968	960	8	3.3
6	Дорнод коллеж-Дээд сургууль-МУБИС	764	754	10	2.6
7	Багшийн сургууль-Багшийн коллеж	609	603	6	2.1
8	Хүмүүнлэгийн ухааны их сургууль	534	343	191	1.8
9	Орхон их сургууль	380	366	14	1.3
10	Мон Алтиус-Биеийн тамирын дээд сургууль	220	220	0	0.7
11	Отгонтэнгэр Их Сургууль	111	107	4	0.7
12	Баян-Өлгий аймаг МУБИС	192	190	2	0.6
13	Улаанбаатарын Их Сургууль	160	141	19	0.5
14	Маргад Дээд сургууль	136	131	5	0.5
15	Шинжлэх ухаан технологийн их сургууль	147	117	30	0.5
16	Цагаан лавай Багшийн дээд сургууль	105	103	2	0.4
17	Хэл Иргэншил дээд сургууль	123	121	2	0.4
18	Шонхор биеийн тамир дээд сургууль	132	131	1	0.4
19	Бусад	4,388	4,124	264	14.4
	Нийт дүн	29,688	28,187	1,501	100.0

Эх сурвалж: БШУЯ-ны Бага, дунд боловсролын газар

³⁵ 2.2 Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад эхний болон хоёр, гурав, дөрөв, тав, арав дахь жилдээ ажиллаж байгаа багш, эхний болон тав, арав дахь жилдээ ажиллаж байгаа ажилтныг хамруулна.

1.81 Аудитын явцад түүвэрт хамрагдсан зарим сургуулийн захирал, менежерүүд нь холбогдох шалгуур, шаардлагыг хангаагүй, аймаг, нийслэлийн Төрийн албаны зөвлөлөөс сонгон шалгаруулалт тухай бүр зарлагдаагүйн улмаас захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ажилласаар байна. Иймд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолын хавсралтаар баталсан *“Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”*-ын дагуу түр орлон гүйцэтгэгчдийг удирдах ажилтны сонгон шалгаруулалтад бүрэн хамруулж, шалгаруулалт явуулан томилох шаардлагатай байна. Тухайлбал,

Ховд аймаг

- Дуут, Зэрэг, Мөст, Чандмань, Жаргалант сумын 3, Цаст алтай цогцолбор, сургуулиудын захирал мэргэшил³⁶ дэх шалгуур нөхцөлийг хангаагүй, Мөнххайрхан, Чандмань, Үенч, Жаргалант сумын 1, 3, Цаст алтай цогцолбор сургуулийн захирлууд 1 дүгээр хавсралтын туршлага³⁷ дахь заалтыг зөрчсөн,
- Алтай, Булган сумын 1, Булган сумын 2 дугаар, Зэрэг, Мянгад, Мөст, Мөнххайрхан, Чандмань, Эрдэнэбүрэн сумд болон Жаргалант сумын Прогресс сургуулийн сургалтын менежерүүд мэргэшил дэх шалгуур нөхцөлийг бүрэн хангаагүй,

Баян-Өлгий аймагт

- Цэнгэл сумын 3 дугаар, Ногооннуур сумын 2 дугаар сургуулийн захирлууд сонгон шалгаруулалтад тэнцээгүй ба “сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч”-ээр ажиллаж байна.

Нийслэлд

- 2019-2020 онд 18 сургуулийн захирал томилогдсноос шүүхийн шийдвэрийн дагуу эргэн томилогдсон 2, сургууль хооронд шилжүүлэн томилогдсон 2, сонгон шалгаруулалтад ороогүй, түр орлон гүйцэтгэгчээр 14 захирал томилогдсон бөгөөд уг сургуулиудын үйл ажиллагаа дотоод зохион байгуулалт муу, удирдах ур чадвар, дадлага туршлагагүй байна.
- НБГ-аас 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 1/725 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд “Сургуулийн захирлын албан тушаалд зохих журмын дагуу сонгон шалгаруулалт зарлаж өгөх” талаар хүсэлт хүргүүлсэн хэдий ч Ковид-2019 цар тахлын нөхцөл байдлын улмаас сонгон шалгаруулалт зарлагдаагүй байна.

1.82 Нийслэлд 2017 онд 12 сургууль, 2018 онд 11 сургууль, 2019 онд 5 сургуульд сургалтын менежер ажилласан нь БСШУСС, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А/167/292, 2018 оны А/024/11 дугаар тушаалаар баталсан *“Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”*-д 1-5 дугаар ангитай бага сургуулийн захирал нь сургалтын менежерийн ажил үүргийг хариуцан гүйцэтгэхээр заасантай нийцэхгүй байна.

Ерөнхий боловсролын салбарын төсвийн төлөвлөлт бодитой бус, тусгай зориулалтын шилжүүлгийн гүйцэтгэлд тавих хяналт сул байна

Хувьсах зардлын дундаж нормативыг шинэчлээгүйгээс төсвийн төлөвлөлт, хуваарилалт бодитой бус байна

1.83 Боловсролын салбарын санхүүжилт нь Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу улсын төсвөөс санхүүжүүлэх нормативт зардал болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх тогтмол зардлаас бүрдэх бөгөөд нормативт зардлыг Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2³⁸ дахь заалтын хүрээнд Засгийн газрын тогтоолоор баталсан нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативт хэмжээгээр тооцож тусгай зориулалтын шилжүүлгээр төлөвлөж, хуваарилж, зарцуулж байна. *Идэлгэрэнгүйг Хавсралт 9-с үзнэ үү/*

³⁶ Боловсрол, нийгэм, төрийн удирдлага, боловсрол судлалын аль нэг чиглэлээр мэргэшсэн байх

³⁷ 3-аас доошгүй жил ЕБС-д удирдах албан тушаалд эсхүл боловсролын салбарын байгууллагад удирдах болон гүйцэтгэх албан тушаалд ажилласан байх

³⁸ Төсвийн тухай хуулийн 61.2. Энэ хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээний үндсэн дээр улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлнэ. 61.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ: 61.1.2. ерөнхий боловсрол;

Дүрслэл 13. Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ /мянган төгрөг/ /Нийслэлийн бага ангийн хувьд/



Эх сурвалж: <http://legalinfo.mn>

газар жил бүр шинэчлэн тогтооно” гэж заасны дагуу дараах байдлаар шинэчилж ирсэн байна.


1.85 Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор “Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал” баталснаас хойш инфляц, цалин, бусад бараа ажил үйлчилгээний үнийн өсөлт, сургуулийн онцлог, хүчин чадал, байршил, төлбөрийн хэмжээтэй уялдуулж шинэчлэн тогтоогоогүй байна.

1.86 Мөн ЕБС-ийн төсвийн дийлэнх хувийг бүрдүүлж байгаа цалингийн зардлын хэмжээг Засгийн газрын 2018 оны 264 дүгээр тогтоол, 2019 оны 24 дүгээр тогтоолоор шинэчлэн тогтоосон хэдий ч хувьсах зардлын нормативыг шинэчлэн тогтоогүйгээс Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор баталсан хувьсах зардлын дундаж нормативын хэмжээгээр тооцож буй цалингийн сан нь албан тушаалын цалингийн сүлжээгээр бодсон хэмжээнээс бага байна.

- Улсын хэмжээнд ерөнхий боловсролын салбарын нийт цалин хөлс болон нэмэгдэл урамшил 2016 онд 368.6 тэрбум төгрөг байсан бол 2019 онд 477.2 тэрбум төгрөг болж нэмэгдсэн байна.

1.87 БШУЯ нь аймаг, нийслэлээс ирүүлсэн ЕБС-ын тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн төслийг нэгтгэж Сангийн яаманд хүргүүлж, хянуулдаг бөгөөд 2017-2019 оны хувьд төсвийн саналыг батлагдсан төсөвтэй харьцуулахад дараах байдалтай байна.

Дүрслэл 14. Төсвийн төсөлд хүргүүлсэн санал /тэрбум төгрөг/



Эх сурвалж: БШУЯ, СЯ

1.88 БШУЯ аймаг, нийслэлээс ирүүлсэн төсвийн төсөлд тусгасан дүнг нэгтгэхдээ 2019 оны хувьд статистикийн мэдээлэл дэх хүүхдийн тоо болон сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд тусгасан хүчин чадлаар тооцон 0.9 хувиар бууруулсан бол Сангийн яам салбарын яамны ирүүлсэн төсвийн төслийг 20 хувиар бууруулж УИХ-д өргөн барьж, батлуулсан байна.

Төсвийг хүүхдийн тоонд үндэслэхгүй, харилцан адилгүйгээр сургуулиудад хуваарилж байна

1.89 Орон нутгийн боловсролын байгууллагын төсөв нь Боловсролын тухай хуулийн 40.1³⁹ болон Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2⁴⁰-т заасны дагуу тусгай зориулалтын шилжүүлэг хэлбэрээр салбарын ТЕЗ-ийн багцад батлагдан, аймаг, нийслэлд хуваарилагдаж байна. Аймаг, нийслэлийн ИТХ нь тусгай зориулалтын шилжүүлгийг орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгон баталж байна.

1.90 Хувьсах зардлыг Бага, дунд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3⁴¹-д тусгасан ЕБС-ийн хэв шинжтэй нь уялдуулан төлөвлөж байгаа бөгөөд төрийн өмчит ерөнхий боловсролын олон улсын хөтөлбөртэй сургуулиуд болон нийслэл, орон нутгийн сургуулийн төсвийн харьцуулалт хийж үзэхэд харилцан адилгүй хуваарилсан байна.

- Засгийн газрын 2012 оны “Сургууль байгуулах, нэмэгдэл олгох тухай” 179 дүгээр тогтоолын дагуу олон улсын хөтөлбөрийн сургалттай сургуулийн ажилтнуудад үндсэн цалингийн 30-50 хувь, лаборатори сургуулийн ажилтнуудад үндсэн цалингийн 15-30 хувийн нэмэгдэл олгодог,
- Гүнзгийрүүлсэн сургалттай сургууль өөрийн үйл ажиллагааны орлогоос багшийн цалинг 15-20 хувиар нэмж тооцож олгодог байна.

Хүснэгт 14. Төсвийн харьцуулалт 2020 он /сая төгрөг/

Үзүүлэлт	Шинэ эрин сургууль /6-12 анги/	Шинэ эхлэл сургууль /6-12 анги/	Монгол тэмүүлэл сургууль /6-12 анги/	Нийслэлийн лаборатори сургууль	Хан-Уул дүүргийн 26 дугаар сургууль	Архангай аймгийн Их тамир сумын сургууль
УРСГАЛ ЗАРДАЛ	1,179.8	1,151.7	873.8	1,872.6	847.4	1,290.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	53	48	53	96	52	80
СУРАЛЦАГЧДЫН ТОО	419	320	300	1488	677	632
Нийт бүлгийн тоо	16	14	12	38	23	25
Нийт хувьсах зардал	1,135.4	1,117.5	873.8	1,713.4	706.7	1,138.7
Нэг хүүхдэд ногдох хувьсах зардал	2.71	3.49	2.91	1.15	1.04	1.09

Эх сурвалж: БШУЯ

1.91 Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2⁴², 22 дугаар зүйлийн 22.6.6⁴³, 42 дугаар зүйлийн 42.2.2⁴⁴-д заасны дагуу батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр батлах, түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөвт зохицуулалт хийх эрхтэй бөгөөд Сангийн сайдын тушаалаар баталсан сар, улирлын төсвийн хуваарийн хүрээнд сургуулийн сар, улирлын хуваарийг баталж, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс санхүүжилтийн эрхийг олгож байна.

1.92 Хувьсах зардал буюу боловсролын стандартыг хангах хөтөлбөрөөр батлагдаж буй зардал нь хүүхдийн тооноос хамаарахаар зохицуулалттай байхад орон нутагт хүүхдийн тооноос төдийлөн хамаардаггүй ямар тооцоолол, үндэслэлээр тооцож хуваарилж байгаа нь тодорхойгүй, зөрүүтэй байдлаар төсөв хуваарилагдаж байна. Тухайлбал,

- Нийслэлд 2017-2019 оны дунджаар 7 сургууль нэгдэж цогцолбор болж хүүхэд болон багшийн тоо нэмэгдсэнээс шалтгаалан СХД-ийн “Ирээдүй” цогцолбор сургуульд хамгийн их буюу 9,920.3 сая төгрөг, ЧД-ийн 112 дугаар сургуульд хамгийн бага буюу 213.9 сая төгрөгийн төсөв хуваарилсан;
- Төрийн бус өмчийн сургуулиудаас 1450 сурагчтай БЗД-ийн “Шинэ-Монгол” сургуульд 626.5 сая, 2019 онд байгуулагдаж 20 хүүхэд суралцаж буй СБД-ийн “Эрдмийн уурхай” сургуульд 1.1 сая төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна.
- Төв аймгийн Сэргэлэн сумын сургууль 67 хүүхэдтэй бөгөөд 2016 онд хувьсах зардалд 120.8 сая төгрөг хуваарилагдсан байхад 150 хүүхэдтэй Архуст сумын сургуульд 126.9 сая төгрөг, 217 хүүхэдтэй Өндөрширээт сумын сургуульд 136.9 сая төгрөг, 507 хүүхэдтэй Эрдэнэ сумын сургуульд 170.7 сая төгрөг батлагдсан,

³⁹ Боловсролын тухай хуулийн 40.1.Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг тогтмол болон нормативд зардлаар санхүүжүүлнэ.

⁴⁰ Төсвийн тухай хуулийн 61.2.Энэ хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээний үндсэн дээр улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлнэ.

⁴¹ Бага, дунд боловсролын тухай хуулийн 12.3 Ерөнхий боловсролын сургууль нь ердийн, төрөлжсөн, гүнзгийрүүлсэн, тусгай, олон улсын хөтөлбөрийн сургалттай гэсэн хэв шинжтэй байна.

⁴² Төсвийн тухай хуулийн 15.2.Энэ хуулийн 39.1-д заасан гэрээгээр тусгай зориулалтын шилжүүлэг хүлээн авсан төсвийн төвлөрүүлэн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг дарга байна.

⁴³ Төсвийн тухай хуулийн 22.6.6.төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах;

⁴⁴ Төсвийн тухай хуулийн 42.2.Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно: 42.2.2.төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд;

- 2018 онд 509 хүүхэдтэй Төв аймгийн Заамарын шижир алтны сургууль 238.7 сая төгрөг батлагдсан байхад 204 хүүхэдтэй Баянхангайн сургууль 192.9 сая төгрөг батлагдсан, хүүхдийн тоо 2.5 дахин зөрүүтэй байхад батлагдсан хувьсах зардал 45.8 сая төгрөгийн зөрүүтэй,
- Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын ЕБС-д 113.1 сая төгрөг, Түвшинширээ сумын ЕБС-д 63.8 сая, Эрдэнэцагаан сумын ЕБС-д 34.1 сая төгрөгийн зардлуудыг тус тус илүү хуваарилсан бол Баруун-Урт сумын 4-р сургуульд 89.6 сая, Баруун-Урт сумын 2-р сургуульд 76.5 сая төгрөг тус тус дутуу хуваарилсан байна. Илүү хуваарилсан зардлыг буцаан төвлөрүүлсэн бөгөөд Баяндэлгэр сумын хувьд санхүүгийн тайлангийн аудитаар акт тогтоож хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

1.93 ЕБС-ийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолыг баримтлан төсвийг төлөвлөдөг бөгөөд дотуур байрны хүүхдийн хоолны зардлын зарцуулалтад тавих хяналт хангалтгүйгээс зарим сумдын дотуур байрны хүүхдийн тоог зөрүүтэй төлөвлөж, санхүүжүүлсэн байна. Тухайлбал,

- Увс аймгийн Завхан, Малчин, Түргэн сумдын ЕБС, Улаангом сумын 2-р сургууль дотуур байрны хүүхдийг тоог нийт 64 сурагчаар бага, бусад сургуулийн тоог гүйцэтгэлээс нийт 763 хүүхдээр илүү төлөвлөсөн,
- Завхан аймгийн Завханмандал сумын дотуур байр төлөвлөсөн хүүхдээс 116 хүүхдээр илүү санхүүжсэн,
- Ховд аймагт 2017 онд нийт 26.6 сая төгрөг, 2018 онд нийт 26.4 сая төгрөгөөр хоолны зардлыг илүү зарцуулсан, Манхан, Дуут, Зэрэг, Үенч сумдын сургуулиас бусад сургуулиуд хоолны зардлыг 2017 онд 1.5-6.6 сая төгрөг, 2018 онд 5.9- 2.0 сая төгрөгөөр зардлыг хэтрүүлэн зарцуулсан,
- Баян-Өлгий аймгийн аудитын газраас хийсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дотуур байрны хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормыг хэтрүүлэн зарцуулсан зөрчилд 2018 онд 15 сургуульд нийт 89.6 сая төгрөгийн илүү зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоож төсөвт төлүүлсэн, 2019 онд 13 сургуульд нийт 123.4 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгсөн,
- Баянхонгор аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс нь ерөнхий боловсролын сургуулиудаас ирүүлсэн төсвийн төсөлд 6 настай хүүхдийг тусад нь тооцоолсныг орхигдуулснаас 2018 онд 10.8 сая төгрөгийг дутуу төлөвлөсөн,

1.94 Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцох бүрэлдэхүүнд батлагдаж буй бараа үйлчилгээний бусад хувьсах зардлыг хэрхэн хуваарилах аргачлал байхгүй бөгөөд БШУЯ нь шаардлагатай гарын авлага, сургалтын үзүүлэн болон бусад хэрэглэгдэхүүний төсвийг төсвийн төсөлд тусгаагүй байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн гүйцэтгэл, зарцуулалтад тавих хяналт сул байна

1.95 БШУС-ын багцад 2017-2019 онд 1,322.5-1,863.6 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд 2019 оны байдлаар ДНБ-ийн 5.0 орчим хувь, Монгол Улсын төсвийн нийт зарлагын 12.6 хувийг эзэлж байгаа бөгөөд ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг 653.7 тэрбум төгрөг байгаа нь салбарын урсгал зардлын 35.1 хувийг эзэлж байна.

Дүрслэл 15. Тусгай зориулалтын шилжүүлгийн зарцуулалт /зардлын зүйлээр/



"Эх сурвалж: Сангийн яам

1.96 ЕБС-ийн тусгай зориулалтын шилжүүлэг 2017-2019 онд 97.9-99.8 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд 2019 оны байдлаар нийт зардлын 78.5 хувийг Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, НДШ, 9.8 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 3.8 хувийг "Үдийн цай" хөтөлбөр, 7.9 хувийг урсгал засвар, хангамж, бараа материал зэрэг бусад зардал эзэлж байна.

1.97 Засгийн газрын 2018 оны 264 дүгээр, 2019 оны 24 дүгээр, 472 дугаар тогтоолоор багш, ажилтнуудын цалин дунджаар 213,063–242,213 төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 15. Цалингийн харьцуулалт

Цалингийн сүлжээний шатлал	2018 оны 264 дүгээр тогтоол	2019 оны 24 дүгээр тогтоол			2019 оны 472 дүгээр тогтоол			2018 оны 264 дүгээр тогтоолоор баталсан цалинтай харьцуулахад	
	ТҮБД-3	ТҮБД-3	Өсөлт	Хувь	ТҮБД-3	Өсөлт	Хувь	Өсөлт	Хувь
1	536,665.0	694,193.0	157,528.0	29.4	749,728.0	55,535.0	8.0	213,063.0	39.7
2	540,847.0	699,637.0	158,790.0	29.4	755,608.0	55,971.0	8.0	214,761.0	39.7
3	551,473.0	713,468.0	161,995.0	29.4	770,545.0	57,077.0	8.0	219,072.0	39.7
4	578,431.0	748,557.0	170,126.0	29.4	808,442.0	59,885.0	8.0	230,011.0	39.8
5	608,504.0	787,701.0	179,197.0	29.4	850,717.0	63,016.0	8.0	242,213.0	39.8

"Эх сурвалж: <http://legalinfo.mn>

1.98 Төрийн бус өмчийн сургуулиудад 2017-2019 онд Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтад заасны дагуу байршил, сургалтын төлбөрийн хэмжээнээс хамаарсан нормативт зардалд нийт 40,885.3 сая төгрөг олгосон байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 11-ээс үзнэ үү/

1.99 Салбарын яам, орон нутгийн боловсролын байгууллагын зүгээс ЕБС-ийн тусгай зориулалтын шилжүүлгийн зарцуулалт, гүйцэтгэлд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй бөгөөд аудитын хүрээнд төсвөөс олгох хувьсах зардлыг хүүхэд өдрийн гүйцэтгэлтэй тулган шалгахад зарим аймагт төрийн өмчийн бус сургуульд хувьсах зардлыг олгохдоо бодит гүйцэтгэлд үндэслээгүй, илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дах заалтад нийцээгүй байх тул төлбөрийн акт тогтоосон байна. Тухайлбал,

- Баянхонгор аймагт
 - 2018-2019 оны хичээлийн жилээс үйл ажиллагаа явуулж буй "Баянхонгор-Олон улсын бага сургууль"-д 6.0 сая төгрөгийг илүү олгосон,
- Орхон аймагт
 - Төрийн бус өмчийн 6 сургуульд 2019 онд 109.0 сая төгрөгийг илүү олгосон.

1.100 Мөн Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хуульд заасны дагуу орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагууд төрийн өмчийн сургуулийн жил бүрийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 2017-2019 онд 28,532.0-41,697.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлж тухай бүр холбогдох арга хэмжээг авч ажилласан байх тул салбарын яам, орон нутгийн удирдлагын зүгээс батлагдсан төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэхтэй холбоотой дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

1.101 БСШУС-ын 2008 оны 30 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 6.2⁴⁵-т "...Жил тутам сургуулийн нийт төсвийн 3 хувийг хичээлээс гадуурх уншлагын ном худалдан авахад зарцуулна" гэж заасан боловч хэрэгжилт хангалтгүй, 2017-2019 онд ном, хэвлэл худалдан авах зардалд нэг сургуульд дунджаар 785.3 - 1,197.6 мянган төгрөг төсөвлөгдөж, 711.2-1,088.1 мянган төгрөг буюу сургуулийн нийт төсвийн 0.07-0.1 хувийг зарцуулсан байна.

1.102 ЕБС-иудад багшийн хөгжлийг дэмжих төвийн үйл ажиллагаанд зориулсан төсөв батлагдаагүйгээс багш нар ажлын байран дээрээ тасралтгүй суралцах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдаагүй, зарим сургууль хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал болон бусад зардал, орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс багшийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөр, багш нарын зарим сургалтын зардал, техник хэрэгслийг санхүүжүүлсэн байна. Тухайлбал:

- Нийслэлд 2019 онд 24 сургууль урсгал зардлаас 84.0 сая төгрөг зарцуулсан,
- Баянхонгор аймагт "Сайн багш" хөтөлбөрийг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, ИТХ-аар батлуулан, 2017-2019 онд 148.3 сая төгрөгийг орон нутгийн төсвийн ангилагдаагүй зардлаас зарцуулсан,
- Орхон аймагт Багш дэд хөтөлбөрийн хүрээнд 2017-2019 онд 286.1 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Дорноговь аймгийн ИТХ-ын 2017 оны 40 дүгээр тогтоолоор баталсан "Маргаашийн нар багшийн гар дээр мандана" дэд хөтөлбөрийн хүрээнд сургууль бүр багшийг хөгжүүлэх төлөвлөгөө гаргаж батлуулж, хэрэгжүүлсэн,
- Говь-алтай аймагт 31.6 сая төгрөг, Завхан аймагт "Сайн багш" дэд хөтөлбөрийн хүрээнд 120.0 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс зарцуулсан байна.
- Ховд аймгийн БСУГ нь багшийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулан 2017-2019 онд 45.7 сая төгрөгөөр 28 төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн нийт 6571 багш ажилчдыг хамруулсан сургалт, зөвлөгөөнүүдийг зохион байгуулжээ.

⁴⁵ Номын сан нь ном, хэвлэл, хэвлэмэл бус материал болон шаардлагатай техник, тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авахад зориулсан төсөв (МНС 5742:2007 стандартын Хавсралт F.6-д "Жил тутам сургуулийн нийт төсвийн 3 хувийг хичээлээс гадуурх уншлагын ном худалдан авахад зарцуулна" гэж заасны дагуу)-тэй байна

1.103 УИХ-ын 2006 оны 66 дугаар тогтоол, Засгийн газрын 2006 оны 194 дүгээр тогтоолын дагуу “Үдийн цай” хөтөлбөрийг төрийн болон төрийн бус өмчийн 1, 2 дугаар ангид суралцаж байгаа хүүхдүүдэд хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын дагуу ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдийн үдийн цайны өдрийн зардлыг 600 төгрөгөөр тооцон төлөвлөж, 2017-2019 онуудад нийт 76,043.4 сая төгрөг, дотуур байрны хоолны зардалд 46,834.8 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 16. Үдийн цай хөтөлбөр, дотуур байрны хоолны зарцуулалт

Он	Үдийн цай хөтөлбөр				Дотуур байрны хоол			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувиар	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувиар
2017	25,004.9	24,864.9	140.0	99.4	16,528.4	16,212.6	315.8	98.1
2018	26,544.0	25,695.0	849.0	96.8	15,939.4	15,596.3	343.1	97.8
2019	26,498.3	25,483.5	1,014.8	96.2	15,338.8	15,025.8	313.0	98.0

Эх сурвалж: Сангийн яам

1.104 ЕБС-ийн үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг хүүхэд өдрөөр тооцож бүрэн олгосон хэдий ч төсвийг бусад зардалд гүйлгэн зарцуулах, үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэхгүй бараа материалын үлдэгдлээр тайлагнах зөрчлүүд гарсан нь зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна. Тухайлбал,

Дархан-Уул аймаг

- Аудитын түүвэрт хамрагдсан сургуулиудын Үдийн цай хөтөлбөрийн санхүүжилтийг давтан тооцоолол хийж тулган баталгаажуулахад 1 дүгээр сургууль 2016-2017 онд 1.8 сая, 24 дүгээр сургуульд 2016-2019 онд нийт 2.7 сая төгрөг илүү тооцож олгосон;

Дорноговь аймаг

- Хүүхдийн хоолны зардлын хэмнэлт 586.5 сая төгрөгийг дансанд төвлөрүүлээгүй бусад сургууль, зардал хооронд гүйлгэн шилжүүлж зарцуулсан;

Орхон аймаг

- Төрийн бус өмчийн 4 ЕБС-д 2016-2019 онд 182.9 сая төгрөгийн үдийн цай хөтөлбөрийн зардлын санхүүжилт олгохдоо тухайн хичээлийн жилийн хүүхдийн статистик тоонд үндэслээгүй, хүүхэд өдрөөр хянахгүйгээр 17.1 сая төгрөгийн зардал илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон;

Ховд аймаг

- Аудитын түүвэрт хамрагдсан сургуулиуд 2017-2019 онд 53.4 сая төгрөгийг бусад зардалд гүйлгэн зарцуулж үдийн цайны зардалд зарцуулснаар тайлагнасан, 121.9 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй бусад зардалд гүйлгэн зарцуулсан;

Завхан аймаг

- ЕБС-ийн үдийн цайны төсвийн гүйцэтгэлийг тулган шалгахад 23 сургууль гүйцэтгэлээс 156.4 сая төгрөгөөр илүү, 6 сургууль 47.0 сая төгрөгөөр дутуу санхүүжсэн;

Булган аймаг

- 2018-2019 онд тухайн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 67.8 сая төгрөг илүү олгосон зөрчилд албан шаардлага болон зөвлөмж өгч ажилласан;

Өвөрхангай аймаг

- Аудитад хамрагдсан 7 суманд үдийн цайны санхүүжилтийн хэмнэлтийг төсөвт буцаан төвлөрүүлэхгүйгээр материалын үлдэгдлийг их хэмжээгээр нөөцөлсөн, 2019 онд нийт 23.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

1.105 Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2⁴⁶, Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2⁴⁷, 39.11⁴⁸-д заасны дагуу БСШУСС, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 56/64 тоот тушаалаар “Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сангийн үлгэрчилсэн дүрэм”-ийн дагуу сургуулиуд хандив тусламж авч буй хэдий ч хяналт тавих чиг үүрэгтэй сургуулийн зөвлөлийн үйл ажиллагаа, хандивын зарцуулалтын тайлагнал хангалтгүй байна.

Дархан-Уул аймаг

- Аудитад хамрагдсан төрийн өмчийн 12 сургууль гадаад, дотоодын байгууллага, иргэд, эцэг эх, асран хамгаалагчдаас нийт 631.5 сая төгрөгийн хандив, тусламж хүлээн авсан боловч зөвхөн Дархан сумын 9, 15, 18, “Од” цогцолбор, “Оюуны ирээдүй” цогцолбор сургуулиуд санд хөрөнгө хүлээн авах, зарцуулах, тайлагнах дүрмээ боловсруулж, мөрдлөг болгон ажиллаж 2016-2019 онд нийт 169.4 сая төгрөгийн хандив тусламж авч зарцуулалтыг тайлагнасан.

- Ерөнхий боловсролын нийт 27 сургуулиас 5 сургууль буюу 20 хүрэхгүй хувь нь сургууль хөгжүүлэх сангийн үлгэрчилсэн дүрэмтэй;

Ховд аймаг

- Булган сумын 2 дугаар сургууль нь 2018 онд түүхт 45 жилийн ойн баяр арга хэмжээг зохион байгуулж байгууллагын нэмэлт дансаар 36.3 сая төгрөг, бэлэн мөнгөөр 30.5 сая төгрөг, бараа материалаар 17.8 сая төгрөг, бай шагналаар 29.0 сая төгрөг, ОНХС-аас 12.0 сая төгрөг нийт 125.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, бараа материалын хандив цуглуулахдаа дээрх дүрмийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлээгүй, хандивын хөрөнгийн зарцуулалтыг нээлттэй тайлагнаагүй байна.

⁴⁶ Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно.

⁴⁷ Боловсролын байгууллага нь улсын төсөв, орон нутгийн төсөв, хөрөнгө оруулалт, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс оруулах сургалтын төлбөр, дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулсан хандив, зээл, боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг санхүүгийн эх үүсвэртэй байна.

⁴⁸ Сургалтын байгууллага нь сургууль хөгжүүлэх сантай байж болох бөгөөд сангийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална

БҮЛЭГ 2. СУРГАЛТЫН ЧАНАР, СУРАГЧДЫН МЭДЛЭГЭЭ ХЭРЭГЛЭХ ЧАДВАР ХАНГАЛТГҮЙ, СУРГУУЛИЙН БОЛОН ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨРҮҮ ӨНДӨР БАЙНА

Сургалтын хөтөлбөр, сурах бичиг, багшийн хөгжил, үнэлгээний журмын өөрчлөлтийг иж бүрэн, харилцан уялдаатай байдлаар хэрэгжүүлээгүй байна

2.1 Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөнд ⁴⁹ тусгагдсан “бага, дунд боловсролын сургалтын төлөвлөгөө ба хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлэх замаар ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд бүрэн шилжүүлэх, 6 ба 7 настай хүүхдийг сургах агуулга, арга зүй, сургалтын орчныг бүрдүүлэх” зорилтын хүрээнд 2006 онд 11 жилийн тогтолцоонд, 2008 онд 12 жилийн тогтолцоонд шилжснээс шалтгаалан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт өөрчлөлт, шинэчлэлт хийгджээ.

2.2 Мөн Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Зөв Монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийн 6.1.10 ⁵⁰, 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.2.10⁵¹-д сургалтын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх тухай тусгагдсан байна.

2.3 БШУС нь Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”, 2013 оны 295 дугаар тогтоолоор баталсан “Зөв монгол хүүхэд” үндэсний хөтөлбөр, БШУС-ын “Бага, дунд боловсролын шинэчлэлийн зураглал, багийн бүрэлдэхүүн батлах тухай” 2013 оны А/155 дугаар тушаалыг тус тус үндэслэн сургалтын цөм хөтөлбөрийг дараах байдлаар баталж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- БШУС-ын 2014 оны А/240 дүгээр тушаалаар “Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр”,
- БШУС-ын 2015 оны А/302 дугаар тушаалаар “Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр”,
- БШУС-ын 2016 оны А/277 дүгээр тушаалаар “Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр”,
 - о 2016 оноос бүрэн дунд боловсролын 10 дугаар анги,
 - о 2017 оноос бүрэн дунд боловсролын 11 дүгээр анги,
 - о 2018 оноос бүрэн дунд боловсролын 12 дугаар ангийн сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд тус тус хэрэгжүүлж эхэлсэн.

2.4 Хөтөлбөрийн шинэчлэлүүд нь суурь судалгаанд үндэслээгүй, үзэл баримтлалаа тодорхойлох, боловсролын түвшин тус бүрээр хэрхэн уялдуулах, сурах бичиг болон багшийн ном боловсруулах, хөтөлбөрийн нийцлийг туршин тохируулах, үндэсний хэмжээнд нэвтрүүлж хэрэгжүүлэх зэрэг үйл явц, шаардагдах хөрөнгө, хүний нөөц, цаг хугацааг тодорхойлсон ямар нэгэн аргачлалгүйгээр хэрэгжсэн бөгөөд хөтөлбөрийн агуулгын залгамж холбоо, давхардал, хүндрэл, хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг дараах байдлаар үнэлсэн байна. Тухайлбал:

- Япон Улсын ЖАЙКА байгууллагын “Суралцахуйг дэмжих мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд 2018 онд хийсэн “Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцын тайлан”:
 - о Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн нэгдсэн зураглал батлагдсан боловч түүнийг дагаж урт болон дунд хугацааны нэгдсэн төлөвлөгөө болон төсөв батлагдаагүй;
 - о Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг 6 жилийн хугацаанд хийх нэгдсэн зураглалыг гаргахдаа сургалтын шинэ хөтөлбөр хэрэгжүүлэхийн өмнөх бэлтгэл ажил хийх хангалттай хугацаа төлөвлөөгүйн улмаас богино хугацаанд олон ажил зэрэг хийх шаардлага үүссэн;
 - о Боловсролын хүрээлэнгийн хүний нөөц бага, цаг хугацаа, санхүүгийн хязгаарлагдмал байдлаас үүдэж суурь судалгаа хийгдээгүй;
 - о Сургалтын цөм хөтөлбөр боловсруулахад оролцсон 400 орчим эрдэмтэн, судлаачдын 30 орчим хувь нь үндсэн ажлынхаа хажуугаар давхар ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж, нэг болон хэд хэдэн судлагдахуун, мөн түүнчлэн 3-5 ангийн сургалтын хөтөлбөрийг богино хугацаанд боловсруулсан нь бүтээгдэхүүний чанарт нөлөөлсөн;

⁴⁹ Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 192 дүгээр тогтоолоор батлагдсан

⁵⁰ 6.1.Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг хүүхэд бүрийг хөгжүүлэх боловсролын чанарын шинэчлэлийн бодлого, стратегитай уялдуулан шинэчлэн боловсруулах:

⁵¹ 3.2.10. Сургалтын стандарт, хөтөлбөр, сурах бичгийн агуулга, чанарыг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, өөрийн орны түүх, соёл, өв уламжлалд тулгуурлан шинэчилнэ.

- o Сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулах туршилтын үеийн удирдамж, аргачлалыг оновчтой боловсруулж, хэрэгжүүлж чадаагүй. Тухайлбал,
 - 40 лаборатори сургуулийн бүх хичээл, ангийг хамруулснаар багш, сурагчдын ачаалал нэмэгдсэн;
 - Сургалтын хөтөлбөр боловсруулах, турших, сайжруулах ажил хугацаа богино хугацаанд хийгдсэн нь боловсруулагчдад ажлын ачаалал их үүсгэж байсан;
- o Үндэсний болон орон нутгийн сургагч багш нараар дамжин сургууль, багш нарт мэдээлэл ижил түвшинд хүрч чадаагүй, сургагч багш нарын үүрэг хариуцлагыг тодорхой болгох, гэрээ байгуулах, сургалт, сурталчилгаа явуулсан үр дүнгээ тайлагнадаг, эргэх холбоог бий болгох механизм бүрдээгүй.
- **2019 оны 3 дугаар сард зохион байгуулсан “Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрт дүн шинжилгээ хийх” сэдэвт хэлэлцүүлэг:**
 - o ЕБС-д судалж байгаа хичээлийн тоо олон, зарим хичээлийн агуулга давхцаж байна (Бага ангийн хүн ба орчин, хүн ба байгаль, хүн ба нийгэм, иргэний боловсрол, эрүүл мэнд);
 - o Зарим хичээлийн агуулга цагтаа багтдаггүй (Бага боловсролын математик, монгол хэл, байгалийн ухаан, дүрслэх урлаг, технологи, 7-9 дүгээр ангийн газар зүй, 9 дүгээр ангийн хими, физик, 8 дугаар ангийн математик, 8, 9 дүгээр ангийн дүрслэх урлаг, дизайн технологи, 10-12 дугаар ангийн математик, монгол хэл бичиг, уран зохиол, физик, газарзүй, мэдээллийн технологи, хими).
 - o Зарим хичээлийн агуулга хүндэдсэн (3 дугаар ангийн математикийн энгийн бутархай, сөрөг тоо, монгол хэлний жорын дагуу унших, зохиох, захидал бичих, ёгт үлгэр зохиох, 5 дугаар ангийн “Хүн ба байгаль” хичээлийн туршилт хийдэг “Хөшүүрэг”, “Энерги).
 - o Зарим хичээлийн агуулга ангиудад жигд хуваарилагдаагүй (9 дүгээр ангийн хими, физикийн агуулга их, 10-12 дугаар ангийн агуулгад танин мэдэхүйн үйлийн доод түвшний суралцахуйн зорилт 54-77%, дээд түвшний зорилт 22-46% байна гэж шинжилгээний үр дүнгээс танилцуулсан),
 - o Зарим хөтөлбөрийн агуулга буюу суралцахуйн зорилтын томъёолол ерөнхий, ойлгомжгүй, багтаамж нь харилцан адилгүй байна гэж тус тус үзсэн.
- **Боловсролын хүрээлэнгээс 2019 онд хийсэн “Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйл” судалгааны тайлан:**
 - o Сурагчдын мэдлэг, ойлголтыг боловсролын түвшин бүрд хичээл тус бүрээр авч үзэхэд, бага ангид 56.0 хувь, дунд ангид 46.0 хувь, ахлах ангид 37.0 хувь,
 - o Сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадвар хангалтгүй, бага ангид 37.5 хувьтай, дунд ангид 43.0 хувьтай, ахлах ангид 36.0 хувь,
 - o Дунд ангийн сурагчдын мэдээлэлтэй ажиллах, асуудлыг шийдвэрлэх, бүтээлч чадвар, сурах арга барилын эзэмшилт, сэтгэхүйн задлан шинжлэх, харьцуулах, нэгтгэн дүгнэх, таамаглал дэвшүүлэх чадвар сул, ахлах ангийн сурагчдын мэдээлэлтэй ажиллан асуудал шийдвэрлэх, бие даан бүтээлч үйл гүйцэтгэх чадвар сул;
 - o Шинжлэх ухаанч арга барил эзэмшсэн байдал дунд ангид 28.0 хувь харин ахлах ангид 32.0 хувь;
 - o Хөтөлбөрийн хэрэгжилтэд хөтөлбөрт хамрагдаж буй бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд сурагчдын эцэг эхийн боловсролын түвшин, эцэг эхийн ажил эрхлэлт, өрхийн сарын дундаж орлого, сургуулийн өмчийн хэлбэр, сургуулийн байршил (нийслэл, аймаг, сум) нөлөөлсөн гэж дүгнэжээ.

2.5 Аудитын явцад салбарын яам, орон нутгийн боловсролын газрын мэргэжилтэн, ерөнхий боловсролын сургуулийн захирал, багш ажилтнуудтай хийсэн уулзалт, ярилцлага болон эцэг эхчүүдээс авсан санал асуулгын дүн дээрх судалгааны тайлангийн дүгнэлтийг дэмжиж байна. Тухайлбал,

- Цахим санал асуулгад хамрагдсан 21301 эцэг, эхийн 44.9 хувь нь сургалтын чанар хангалттай бус гэж хариулсан бол 6520 багш, ажилтны 32.7 хувь нь сургалтын хөтөлбөрийн тогтворгүй байдал, 19.6 хувь нь гэр бүлийн орчин өрхийн орлого, 18.9 хувь нь сургалтын чанарын үнэлгээний шалгуур үзүүлэлт, 15.9 хувь сургалтын орчин, нэг ангид ногдох хүүхдийн тоо, 13 хувь нь бусад хүчин зүйл сургалтын чанарт нөлөөлж байна гэж хариулжээ.

2.6 БШУЯ үндэсний, бүс нутгийн болон суралцагчийн бодит нөхцөл байдлыг харгалзан хөтөлбөр боловсруулахаас эхлээд үнэлэх, эргэх холбоогоор хангах хүртэлх цогц үйл ажиллагааг хянан баталгаажуулж сайжруулах боломжтой 10 жилийн хөтөлбөрийн менежментийн цикл, тогтолцоог бий болгох зорилгоор “Суралцахуйг дэмжих мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал” боловсруулж, БСШУСС-ын 2018 оны А/549 дүгээр тушаалаар баталсан байна.

2.7 “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.8-3.2.17 дахь заалтууд, Боловсролын хүрээлэнгийн 2019 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 124 дүгээр албан бичиг, “Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол” багш нарын улсын хоёрдугаар зөвлөгөөнд оролцогчдын санал, зөвлөмж, “Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр” үндэсний хэлэлцүүлэгт оролцогчдын санал, дүгнэлт, Монголын багш нарын VII их хурлын 2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн БСШУСС-ын 2019 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн А/492 дугаар тушаалаар бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын сайжруулсан хөтөлбөрийг баталжээ.

2.8 Салбарын яамны зүгээс сургалтын хөтөлбөрийн удаа дараагийн шинэчлэлттэй уялдуулан бага, дунд, ахлах ангийн сургалтын төлөвлөгөөг тухай бүр дараах байдлаар шинэчилж ирсэн байна. Тухайлбал,

- Бага ангийн сургалтын төлөвлөгөө: БШУС-ын 2014 оны А/240 дүгээр тушаал, БСШУСС-ын 2018 оны А/453 дугаар тушаал, 2019 оны А/491 дүгээр тушаал,
- Дунд ангийн сургалтын төлөвлөгөө: БШУС-ын 2014 оны А/488 дугаар тушаал, 2015 оны А/220 дугаар тушаал, БСШУСС-ын 2018 оны А/453 дугаар тушаал, 2019 оны А/491 дүгээр тушаал,
- Ахлах ангийн сургалтын төлөвлөгөө: БШУС-ын 2015 оны А/320 дүгээр тушаал /лаборатори сургуулийн хувьд/, 2016 оны А/275 дугаар тушаал, БСШУСС-ын 2016 оны А/103 дугаар тушаал /Х ангийн хувьд/, БСШУСС-ын 2017 оны А/61 дүгээр тушаал, 2018 оны А/453 дугаар тушаал, 2019 оны А/491 дүгээр тушаал.

2.9 БСШУСС-ын 2019 оны А/491 дүгээр тушаалаар баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу хичээллэж эхэлснээр хичээлийн жилийн нийт цаг 24-70 цагаар, нэг өдөрт хичээллэх цаг бага ангийн хувьд 0.1-0.3 цагаар буурсан бөгөөд VI-X ангийн хувьд тогтмол, XI, XII ангийн хувьд хичээлийн жилд 0.2 цагаар нэмэгдсэн нь тухайн хичээлийн жилд хичээллэх долоо хоногийн тоо 35 байсан нь 33 болж буурсантай холбоотой байна.

Хүснэгт 17. Сургалтын төлөвлөгөөний харьцуулалт

Хичээлийн жил	Анги											
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Хичээлийн жилийн нийт цаг												
2016-2019 оны хичээлийн жил	727	736	759	792	891	1015	1225	1225	1225	1225	1225	1225
2019-2020 оны хичээлийн жил	670	704	704	768	864	957	1155	1155	1155	1155	1188	1188
Зөрүү	57	32	55	24	27	58	70	70	70	70	37	37
Өдрийн цаг												
2016-2019 оны хичээлийн жил	4.5	4.6	4.6	4.8	5.4	5.8	7.0	7.0	7.0	7.0	7.0	7.0
2019-2020 оны хичээлийн жил	4.2	4.4	4.3	4.7	5.2	5.8	7.0	7.0	7.0	7.0	7.2	7.2
Хичээлийн тоо /Заавал судлах/												
2016-2019 оны хичээлийн жил	6	6	6	8	9	15	18	18	17	15	15	9
2019-2020 оны хичээлийн жил	7	7	7	9	10	16	19	19	18	16	16	10
Эх сурвалж: БШУС-ын тушаал												


2.10 Дунд ангийн сурагч өдөрт 5.8-7.0 цаг, ахлах ангийн сурагч 7.0-7.2 цаг хичээллэхээр байгаа хэдий ч гэрийн даалгавар, нэмэлт давтлага, олимпиадын бэлтгэл, сургуулийн нэмэлт үйл ажиллагаанд хамрагдах зэргээр өндөр ачаалалтай байх тул дунд ангийн 16-19 төрлийн хичээлийг интеграцчлах замаар сурагчдын ачааллыг бууруулах, сурах бичиг, багшид зарцуулах нөөцийн үр ашгийг дээшлүүлэх нь зохистой байна.

2.11 Цөм хөтөлбөрийн зорилтын хүрээнд багшлах, заах арга зүйгээ сайжруулахад багш нийт ажлын цагийн 85 хувийг зарцуулах ёстой хэдий ч нийт цагийн 37.3 хувийг зарцуулж, тайлан бичих, судалгаа бөглөх, журнал, бичиг баримт хөтлөх, цаг үеийн ажилд дайчлагдах зэрэг бусад нэмэлт ажилд нийт цагийнхаа 62.7 хувийг зарцуулж байна.

2.12 Боловсролын хүрээлэн багш нарын хичээл төлөвлөлт цөм хөтөлбөртэй нийцэж буй эсэхийг бага боловсролын түвшинд 3.2-57.7 хувь, суурь боловсролын түвшинд 57.5 хувь, бүрэн дунд боловсролын түвшинд 20.6-31.0 хувь нь тохироц сайн байна гэж дүгнэсэн⁵² бөгөөд аудитын хүрээнд цахимаар авсан санал асуулгад оролцсон 5758 багш, ажилтаны 38.0 хувь нь сургалтын хөтөлбөр, сурах бичиг агуулгын хувьд зөрүүтэй байдлыг тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, 30.0 хувь нь анги дүүргэлтээс шалтгаалан хичээлийн агуулгыг сурагчдад хүргэхэд хүндрэлтэй гэж хариулсан байна.

⁵² Эх сурвалж: "Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйл"-д хийсэн судалгааны тайлан

Дүрслэл 16. Сургалтын цөм /сайжруулсан/ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй хүндрэл бэрхшээл



Эх сурвалж: Аудитын санал асуулга

2.13 Баян-өлгий аймгийн хос хэл дээр сургалт явуулдаг сургуулиудын хувьд сургалтын төлөвлөгөөг тус аймгийн БСУГ-ын дарга баталж, мөрдүүлж байгаа нь Бага, дунд боловсролын тухай хуулийн 7.3⁵³-т заасантай нийцээгүй, казах, тува хэл дээрх сурах бичиг хангалтгүй, тухайн хэлний хичээл заадаг багш нарын мэргэжлийг дээшлүүлэх асуудал шийдэгдээгүй байна.

- Тус аймгийн БСУГ-ын даргын батлан мөрдүүлж буй сургалтын төлөвлөгөөний дагуу дунд, ахлах ангийн сурагчид 7 хоногт 37 цаг /өдрийн ачаалал 7.4 цаг/ хичээллэснээр сургуулиудад мэргэжлийн багшийн, мөн бага анги нь казах, монгол хэл дээр зэрэгцэж хичээллэдэг сургуулийн бүлэг дүүргэлт бага байдаг явдал нь бага ангийн багшийн орон тоо нэмэгдэх шалтгаан болсон;
- Монгол хэл дээрх үндэсний сурах бичгүүдийн хүртээмж сайн хэдий ч тува хэлний казах хэл дээр орчуулагдсан 27 нэр төрлийн сурах бичгийн 18 сурах бичиг үг үсэг, найруулгын алдаатай, 1-5 дугаар ангийн Эх хэл, 2-5 дугаар ангийн "Монгол хэл" сурах бичгүүдийг 2010 оноос хойш шинэчлэгдээгүй байсныг 2019 онд сурах бичгийг шинэчилсэн байна. Хос хэлээр сургалт явуулдаг Тува сургуулийн Тува хэлний 1-5 ангийн бүх сурах бичиг, 2-5 дугаар ангийн Тува хэлний багшийн ном, сургалтын хөтөлбөр нь яамнаас батлагдаж гараагүй бөгөөд Боловсролын хүрээлэнгээс гаргасан гарын авлагыг сургалтад ашиглаж ирсэн байна.

2.14 Монгол Улсын Ерөнхий сайдын 2011 оны 29 дүгээр захирамжаар эрх олгосны дагуу БСШУС /тухайн үеийн нэрээр/ Кэмбрижийн их сургуулийн олон улсын шалгалтын төвтэй 2011 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан "Бага дунд боловсролын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх талаар хамтран ажиллах" санамж бичигт бага, дунд боловсролын стандарт, хөтөлбөрийг шинэчлэн боловсролын чанарыг олон улсын түвшинд хүргэх зорилгын хүрээнд 2010-2017 онд дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд:

- Бага, дунд боловсролын стандарт хөтөлбөрийг олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн Кэмбрижийн олон улсын ерөнхий боловсролын стандарт хөтөлбөртэй уялдуулан, Монголын боловсролын үнэт зүйлс, үнэлэмж, боловсролын хөгжлийн эрэлт, хэрэгцээ, онцлогт нийцүүлэн шинэчлэх,

Кэмбрижийн ОУ-ын стандарт, хөтөлбөрөөр хос хэлээр хичээллэх төрийн өмчит сургуулийг байгуулж, туршилт явуулснаар ОУ-д өрсөлдөх чадвартай ерөнхий боловсролын тогтолцооны үндсийг бий болгох

Дунд хугацаанд лаборатори сургуулиудад Кэмбрижийн олон улсын стандартын дагуу шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг Монгол хэлээр заах

Одоо /тухайн үед/ мөрдөгдөж буй стандарт, хөтөлбөрийг Кэмбрижийн ОУ-ын стандарт, хөтөлбөр, сургалтын системтэй уялдуулсан бүрэн хэмжээний стандарт, хөтөлбөр бий болгож ерөнхий боловсролын бүх сургуульд мөрдөх

Багш бэлтгэдэг их, дээд сургуулийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэх, стандартын шинэчлэлтэй уялдуулан шинэ сурах бичгүүдийг зохиох, Лаборатори сургууль нь бусад сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх төвийн үүрэг гүйцэтгэх,

Шинэ стандарт, хөтөлбөрт шилжсэний дараа МУ-ын бүрэн дунд боловсролын гэрчилгээ, боловсролын баримт бичгийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлэх ажлыг зохион байгуулах

⁵³ Бага, дунд боловсролын тухай хуулийн Ерөнхий боловсролын сургуульд мөрдөх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, батална.

2.15 УИХ-аас 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдөр Боловсролын тухай хуульд “3.1.13 олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль” гэж олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий боловсролын хөтөлбөрөөр хичээллэдэг сургуулийг”, “3.1.14 “ерөнхий боловсролын лаборатори сургууль” гэж бага, дунд боловсролын судалгаа, арга зүйн туршилтыг зохион байгуулах ерөнхий боловсролын сургуулийг” гэсэн нэмэлт, өөрчлөлтийг оруулж, баталсан байна.

2.16 Засгийн газрын 2012 оны 179 дүгээр тогтоолоор байгуулсан олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчийн ерөнхий боловсролын “Шинэ эрин”, “Шинэ эхлэл”, “Монгол тэмүүлэл” сургууль нь суралцагчдаа уралдаант сонгон шалгаруулалтаар элсүүлж авдаг бөгөөд дунд, ахлах ангийн сурагчид иж бүрэн сургалтын хэрэглэгдэхүүн, лаборатори кабинет бүхий орчинд англи болон монгол хэл дээр хос хөтөлбөрөөр /Үндэсний болон Кэмбрижийн/, нэг ээлжээр өдөрт 8.4-10 цаг хичээллэж байна.

2.17 Тус сургуулийн сурагчид Монгол Улсын бүрэн дунд боловсролын гэрчилгээ авахаас гадна сонгон судалсан хичээлүүдээр Кэмбрижийн олон улсын шалгалтын төвд шалгалт өгч олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификат авдаг бөгөөд төгсөгчдөөс дотоодын болон гадаадын их дээд сургуульд суралцах хувь төрийн өмчийн бусад сургуулиудаас өндөр байна. Тухайлбал,

- Шинэ эрин сургуулийг 2012 оноос хойш 252 сурагч төгссөн бөгөөд 134 төгсөгч буюу 55.3 хувь нь 18 улсын 96 их дээд сургуульд элссэн, 110 сурагч сургалтын тэтгэлэгт хамрагдсан байна.
- БҮТ-ээс авсан суралцагчдын сурлагын амжилтын дундаж үзүүлэлтээр ердийн сургуулиас 23.4 пунктээр өндөр,
- ЭЕШ-ын математикийн хичээлийн анхны онооны дундаж төрийн өмчийн ердийн сургуулиас 21 оноогоор өндөр байна.

Хүснэгт 18. Олон улсын хөтөлбөртэй төрийн өмчийн сургуулийн сурагчдын тоо, бүлэг

Сургуулийн нэр	2019-2020 оны хичээлийн жил								
	Нийт хүүхэд	Нийт бүлгийн тоо	Нэг бүлгийн хүүхдийн тоо						
			VI	VII	VIII	IX	X	XI	XII
Монгол тэмүүлэл	226	10	-	-	-	24.8	26.0	20.0	17.5
Шинэ Эрин	409	16	25.5	26.0	25.5	25.6	26.0	26.3	24
Шинэ Эхлэл	307	14	24.0	26.0	21.5	19.3	24.0	19.0	15

Эх сурвалж: БШУЯ-ны статистик мэдээ

2.18 Өнөөгийн нөхцөлд төрийн өмчийн сургуулиуд нэг ээлжээр хичээллэх, зориулалтын лаборатори, кабинетэд байгалийн ухааны хичээл орох боломж бүрдээгүй, бүлэг дүүргэлт өндөр, англи хэл дээр хичээл заах багшийн нөөц хангалтгүй зэргээс улсын хэмжээнд хос хөтөлбөрөөр хичээллэх боломж бүрдээгүй байна. Тухайлбал,

- Аудитын явцад авсан судалгаагаар дунд, ахлах ангид хичээл заадаг 23,239 багшийн 17.9 хувь нь англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй гэж тодорхойлсон байна.

2.19 Ерөнхий боловсролын сурагч төгссөнөөс хойших хугацаанд мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсрол эзэмшиж буй эсэх, хөдөлмөр эрхэлж буй эсэх талаар мөшгөх судалгааг ерөнхий боловсролын сургууль, орон нутгийн боловсролын газар, салбарын яамны хэмжээнд хийж, нэгдсэн тоо мэдээ бүрдүүлдэггүй нь боловсролын салбарын санхүүжилтийн үр өгөөж, сургалтын үр нөлөөг тооцох боломжгүй байдалд хүргэж байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.20 БСШУС-ын 2012 оны А/387 дугаар тушаалаар анх аймаг тус бүрт 1, нийслэлд 10 сургууль нийт 31 сургууль, 2013 оны А/229 дүгээр тушаалаар нийслэлд 6, сумдад 3 сургуулийг лаборатори сургууль болгон өөрчилж, 2019 онд 3 лаборатори сургууль шинээр байгуулсан бөгөөд одоо нийт 45 лаборатори сургууль үйл ажиллагаа явуулж байгаа боловч шалгуур үзүүлэлт, үндэслэл тодорхойгүй, байршилтай уялдаагүй байна.

- Шинээр 2019-2020 онд байгуулагдсан нийслэлийн 141, 142, 151 дүгээр сургуульд лаборатори сургуулийн тусгай зөвшөөрөл олгосон,
- Нийслэлийн Баянгол дүүрэгт хамгийн олон буюу 6 сургууль, Баянзүрх дүүрэгт 4 сургууль, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүрэгт 3 сургууль, Завхан аймгийн Тосонцэнгэл сум, Булган аймгийн Хишиг-Өндөр сум, Дорноговь аймгийн Замын-Үүд зэрэг сумын төвд үйл ажиллагаа явуулж буй нь байршилтай уялдаагүй;

2.21 Салбарын яам лаборатори сургуулийн захирлыг томилохоос бусдаар үйл ажиллагааны уялдаа, хамааралгүй төдийгүй Боловсролын тухай хуульд заасан лаборатори сургуулийн тусгай арга хэмжээ, хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтыг хэрэгжүүлэх журам

батлагдаагүйгээс лаборатори сургуулиудын ердийн сургуулиас ялгагдах онцлог, тавигдах шалгуур, үндэслэл тодорхойгүй, мөн үйл ажиллагаа нь хуульд заасан лаборатори сургуулийн зорилттой нийцсэн, үр дүнтэй байгаа эсэхийг үнэлж дүгнэх шалгуур, үзүүлэлтгүй байгаа нь сар бүр олгож буй нэмэгдлийн үр өгөөжийг тооцох боломжгүй байдалд хүргэж байна.

2.22 Мөн салбарын яам ахлах ангийн сурагчдад өөрсдийн авьяас, сонирхол, ирээдүйн мэргэжлийн чиг баримжаандаа тулгуурлан хичээлээ сонгож судлах боломж олгох, дараагийн шатны сургуульд үргэлжлүүлэн суралцах залгамж холбоог хангах, ахлах сургуулийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого баримталж хэрэгжүүлж буй хэдий ч хөдөөгийн цөөн сурагчидтай сургуульд багшийн хүрэлцээ, бүлэг бүрдэхгүй байх зэргээс шалтгаалан анагаах ухаан, биологи, газарзүй, технологийн чиглэлийн мэргэжлээр гүнзгийрүүлэн судлах боломж хязгаарлагдаж байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 13-аас үзнэ үү/

- Боловсролын салбарын мэдээллийн системд 2017-2019 онд бүртгэгдсэн ахлах ангийн сурагчдын хичээл сонголтын байдлыг авч үзэхэд математик, англи хэл, нийгэм судлал, монгол хэл, физикийн хичээлийг дийлэнх сурагч сонгож буй боловч хими, газарзүй, биологи, дизайн технологи, мэдээллийн технологи зэрэг хичээлийг сонгож суралцагчийн тоо бага байна.

2.23 Аудитаар түүвэрт хамрагдсан зарим сургуулиуд салбарын яамнаас баталсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтын үйл ажиллагаа явуулаагүй, сургалтын хөтөлбөр, нэгж хичээлийн төлөвлөгөөг сургуулийн захирал, менежер хянаж батлаагүй зэрэг зөрчил илэрсэн байна. Тухайлбал,

Архангай аймаг

- Тариат, Хайрхан сумын Мөрөн багийн ЕБС-ийн 48 багшийн сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг түүвэрлэн шалгахад 26 багш нэгж хичээлийн хөтөлбөр төлөвлөгөөг сургалтын менежерээр батлуулаагүй;
- Хануй багийн бага сургуулийн 5 багш сургуулийн захирлаар батлуулсан нэгж хичээлийн төлөвлөгөө хөтөлбөргүй,
- Эрдэнэбулган сумын 2 дугаар сургуулийн багшийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө сургалтын менежерүүдэд анхан шатны баримтаар хадгалагдаагүй;
- 2016-2019 оны хичээлийн жилүүдэд аймгийн БСУГ-аас авсан стандартын биелэлтийн хөндлөнгийн үнэлгээ нь 60-аас доош хувьтай байгаа нь эзэмшвэл зохих боловсрол ур чадварыг бүрэн олгож чадаагүй байна гэж үзэхээр байна.
- Ирээдүй бага сургууль цэцэрлэгийн цогцолбор аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүлэг үүсгэн хичээллүүлдэг боловч хичээлийн хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүнгүй;

Баянхонгор аймаг

- Галуут сумын Мандалын бага сургуулийн сургалтын хөтөлбөрт хүүхдэд олгох агуулга, мэдлэг чадварыг бүрэн тусгаагүй, цагийн төлөвлөлт дутуу, мөн сургалтад ашиглах гарын авлага, хэрэглэгдэхүүн, үнэлгээ судалгаа байхгүй, сургуулийн удирдлагаас багш нарын хичээлийн бэлтгэлд тавих хяналт хангалтгүй;
- Шаргалжуут тосгоны ЕБС нь бага ангийн нэгж, ээлжит хичээлийн хөтөлбөргүй, сурагчдын үнэлгээ, даалгаврын сан, жишиг даалгаварыг агуулгад дүйцүүлж, даалгаврын сан бүрдүүлээгүй;
- Жинст сумын ЕБС-ийн дунд ангийн зарим судлагдахууны багш нарын жилийн хөтөлбөргүй;
- Баянлиг, Баян-Овоо сумын ЕБС-ийн зарим багш нар нэгж ээлжит хичээлийн хөтөлбөрийн чанарыг сайжруулах, зорилго зорилт, үнэлгээ зэргийг тодорхой тусгаж төлөвлөдөггүй, сургалтын хэрэглэгдэхүүний сан бүрдүүлж ажиллаагүй;
- Баянговь сумын ЕБС хөтөлбөрийн бүтцэд зорилго, арга зүй, үнэлгээ байхгүй, сургалтын хэрэглэгдэхүүн, даалгаврын сан бүрдүүлж ажиллаагүй;

Дархан-Уул аймаг

- 24 дүгээр сургууль 2016-2018 оны хичээлийн жилд 7-9 ангид орос хэлний хичээл ороогүй, 19 дүгээр сургууль нь одоог хүртэл 7-9 дүгээр ангиудад орос хэлний хичээлийг огт ороогүй нь БСШУС-ын 2015 оны А/220, БСШУСС-ын 2018 оны А/453, 2019 оны А/491 тоот тушаалын хавсралтад заасан дунд ангийн сургалтын төлөвлөгөөг мөрдөөгүй, мөн тус аймгийн БСУГ хяналт тавьж ажиллаагүй нь Бага дунд боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Боловсролын тухай хуулийн 28¹ дугаар зүйлийн 28¹.1.4 , 28¹.1.10 дахь заалтуудыг зөрчиж байгаа тул албан шаардлагыг хүргүүлсэн.

2.24 Түүвэрт хамрагдсан нийслэлд үйл ажиллагаа явуулж буй төрийн бус өмчийн зарим сургуулийн бага, дунд, ахлах ангийн хичээлийн хуваарийг БШУС-ын баталсан сургалтын төлөвлөгөөтэй тулгаж үзэхэд Иргэний ёс зүйн боловсрол, Биеийн тамир, Газар зүй, Эрүүл мэнд, Мэдээллийн технологи, Хөгжим, Түүх, Үндэсний бичиг, Хүн ба байгаль, Хүн ба нийгэм зэрэг хичээлийг заадаггүй, зарим судлагдахууны цагийг зөрүүтэй тусгасан байна.

Хүснэгт 19. Сургалтын хэв шинж, хөтөлбөр, төлөвлөгөө харьцуулалт

№	Сургуулийн нэр	Баталсан төлөвлөгөө хөтөлбөрт тусгасан цагаас		Хөтөлбөрт туссан судлагдахууныг ороогүй	Хэв шинж
		Илүү цаг	Дутуу цаг		
1	Жаргалан сургууль	978	98	165	гүнзгийрүүлсэн
2	Оюунлаг сургууль	1188	66	627	ердийн
3	Шинэ монгол сургууль	330	66	396	ердийн
4	Г.В.Плехановын нэрэмжит Оросын Эдийн засгийн их сургуулийн Улаанбаатар хотын салбар	522	191	685	гүнзгийрүүлсэн
5	Гёте сургууль	165	-	99	ердийн
6	Чандмань эрдэнэ сургууль	490	-	462	ердийн
7	Хос Уянга сургууль	33	-	66	ердийн
8	Цэцгийн өргөө сургууль	363	165	0	ердийн
9	Атланта сургууль	1703	66	790	гүнзгийрүүлсэн
10	Тусгал сургууль	98	64	32	ердийн
11	Олонлог төв сургууль	726	98	165	гүнзгийрүүлсэн
12	Олонлог эзэс сургууль	320	32	0	ердийн
13	Этүгэн сургууль	359	66	99	ердийн
14	Шинэ Зуунбилэг сургууль	528	66	33	гүнзгийрүүлсэн
15	Жет сургууль	256	186	122	ердийн
16	Кингс кидс сургууль	352	26	244	гүнзгийрүүлсэн
17	Логарифм бүрэн дунд сургууль	98	-	64	ердийн
18	Хобби сургууль	92	96	302	гүнзгийрүүлсэн
19	Үй цай сургууль	208	538	384	гүнзгийрүүлсэн
20	Дойче шүлэ сургууль	468	33	462	ердийн
21	Номуун сургууль	591	-	358	гүнзгийрүүлсэн
22	Тольт сургууль	490	396	231	гүнзгийрүүлсэн
23	Чандмань сургууль	490	-	462	ердийн

Эх сурвалж: Нийслэл дэх Төрийн аудитын байгууллагын тайлан

- Орос 3 дугаар сургууль буюу Монгол-Оросын хамтарсан сургууль цагийн ачааллаас шалтгаалан Иргэний ёс зүйн боловсрол, Эрүүл мэндийн хичээл ордоггүй,

2.25 Аудитын хүрээнд аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын түүвэрт хамрагдсан дараах сургуулиуд сургалтын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулаагүй зөрчлүүд илэрсэн бөгөөд аймгийн БСУГ-ын зүгээс тавих хяналт хангалтгүй байгаа нь БСШУС-ын 2002 оны 333 дугаар тушаалаар баталсан журмын 3.13⁵⁴ заалттай нийцээгүй байна. Тухайлбал:

Архангай аймаг

- Лаборатори 1 дүгээр сургуульд 2020-2021 оны хичээлийн жилд гүнзгийрүүлсэн сургалт явуулж буй 4 багш нь мэргэжлийн зэрэггүй байгаа нь гүнзгийрүүлсэн сургалт явуулах тусгай зөвшөөрлийн сургалт эрхлэх нөхцөл шаардлагыг хангаагүй,

Дархан-Уул аймаг

- Аймгийн БСУГ-аас гүнзгийрүүлсэн сургалт явуулж байгаа сургуулиудыг 3 жил тутамд аттестатчилж, сургалтын чанарт үнэлгээг хийгээгүй. 24 дүгээр сургууль гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөрийг батлуулаагүй, “Оюуны ирээдүй” цогцолбор сургуулийн гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөрийн хугацаа дууссан, 9 дүгээр сургууль гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөргүй,
- Гадаад боловсролын хөтөлбөрөөр 2003 оноос үйл ажиллагаа явуулж байгаа “Союз” сургуулийн сургалтын тусгай зөвшөөрөлд Монгол улсад мөрдөгдөж байгаа бага, дунд, суурь боловсролын стандарт, төлөвлөгөө, хөтөлбөртэй байх, орос хэлний гүнзгийрүүлсэн сургалтыг 1-12 ангид явуулахаар тусгасан байтал 1-4 ангиуд нь орос хэл дээр бүх хичээлийг явуулж байгаа нь Бага, дунд боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁵⁵, Боловсролын тухай хуулийн 28¹ дугаар зүйлийн 28^{1.1.2}⁵⁶, 28^{1.1.4}⁵⁷, 28^{1.1.10} дахь заалтууд, тусгай зөвшөөрөлтэй тус тус нийцэхгүй байгаа тул БСУГ-т хяналт тавьж ажиллах тухай албан шаардлага хүргүүлсэн.

Хөвсгөл аймаг

- Эрдмийн далай цогцолбор сургууль 6-9 дүгээр ангид англи хэлний гүнзгий сургалт явуулах зөвшөөрөлтэй хэдий ч 2020-2021 оны хичээлийн жилд 10-12 ангид гүнзгий сургалт явуулж байна

⁵⁴ Гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалттай сургуулийн сургалтыг Боловсролын тухай хуулийн 28.1.8-д заасны дагуу 3 жил тутам аттестатчилж, сургалтын чанарт үнэлгээ өгч баталгаажуулна. Аттестатчиллыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан удирдамж, зааврын дагуу аймаг, нийслэлийн, боловсрол, соёлын төв явуулна.

⁵⁵ Төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургууль нь суралцагчид бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартын агуулгыг заавал эзэмшүүлнэ

⁵⁶ Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргаж аймаг, нийслэлийн Засаг даргад санал болгох

⁵⁷ Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх

- Нутгийн аваргууд сургууль нь 2015-2018 онд төрөлжсөн сургалтын тусгай зөвшөөрөлгүй ажилласан нь БСШУСС-ын 2002 оны 333 дугаар тушаалаар баталсан журмын 2.1.1⁵⁸ заалттай нийцээгүй;
 - БУСГ-ын зүгээс гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалттай сургуулиудад сүүлийн 3 жилд аттестатчилал, сургалтын чанарт үнэлгээ өгөөгүй,
- Нийслэл**
- Төрийн бус өмчийн ЕБС-ууд сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу сургалтын үйл ажиллагааг явуулаагүй, ердийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ч гүнзгийрүүлсэн болон олон улсын хөтөлбөрөөр хичээллэсэн.


Хүснэгт 20. Төрийн бус сургуулийн тусгай зөвшөөрөл болон үйл ажиллагаа явуулж буй хэв шинж

№	Сургуулийн нэр	Дүүрэг	Суралцагчийн тоо	Тусгай зөвшөөрөлд тусгагдсан хэв шинж	Үйл ажиллагаа явуулж буй хэв шинж
1	Гэгээрэл	БГД	229	Ердийн	Гүнзгийрүүлсэн
2	Эрин эверест интернэшнл сургууль	БГД	267	Ердийн	Гүнзгийрүүлсэн
3	Оюунлаг сургууль	БЗД	1054	Ердийн	Гүнзгийрүүлсэн
4	Шинэ монгол сургууль	БЗД	1486	Ердийн	Гүнзгийрүүлсэн
5	Гёте сургууль	БЗД	535	Ердийн	Олон улсын
6	Тусгал сургууль	ЧД	178	Ердийн	Гүнзгийрүүлсэн
7	Олонлог эзэс сургууль	ЧД	189	Ердийн	Гүнзгийрүүлсэн
8	Этүгэн сургууль	ХУД	221	Ердийн	Гүнзгийрүүлсэн
9	Жет сургууль	ХУД	320	Ердийн	Олон улсын
10	Логарифм бүрэн дунд сургууль	СБД	694	Ердийн	Олон улсын
11	Дойче шуле сургууль	СБД	350	Ердийн	Олон улсын
12	Жаргалан	БГД	196	Гүнзгийрүүлсэн	Олон улсын

Эх сурвалж Нийслэл дэх Төрийн аудитын байгууллага

2.26 ТБӨ-ийн сургуулиудад гарч буй дээрх зөрчлүүд нь төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоогүй байдал, дүрэм журмаар магадлал хийх хугацаа нь 3 жил, хариуцсан ажилтнуудын ажлын ачаалал их, хүрэлцээ багаас хяналт шалгалтыг тогтмол хийх боломжгүйгээс шалтгаалсан байна.

Дүрслэл 17. Сурах бичгийн агуулга сургалтын хөтөлбөртэй бүрэн уялдаж буй байдал



- Зарим агуулга, сэдвийг хичээлийн цагт багтаах боломжгүй
- Тийм, бүрэн уялдсан
- Хангалтгүй, нэмэлт ном, материал ашиглахаг хүрдэг

Эх сурвалж: Аудитын явцад авсан санал асуулга

- Сурах бичгийн зохиогчийн эхийг агуулгын редактораар хянуулах, засварлахад хагас сар, эх бэлтгэхийн зэрэгцээ агуулга ба техникийн редактораар тус бүр 2 удаа хянуулахад 1 сар, редакторуудын уншилтад 5 хоног төлөвлөсөн. Нэг хичээлийн жилд багтааж эхийг зохиохоор төлөвлөсөн дунд ангийн сурах бичгийг 3 хичээлийн жилийн хугацаанд, ахлах ангийн сурах бичгийг хоёр хичээлийн жилийн хугацаанд зохиож байгаа нь хүний нөөц, санхүү хөрөнгийн төлөвлөлтийг бодитой хийж чадаагүйг харуулж байна.

2.27 БШУЯ нь Засгийн газрын 2009 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 28 дугаар тэмдэглэлийг үндэслэн сурах бичгийг бага ангид 80-100 хувь, дунд, ахлах ангид 40 хүртэл хувийг төрөөс хангах ажлыг зохион байгуулж, улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлж ирсэн бөгөөд сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг сурах бичиг, багшийн номын эх зохиох ажилтай зэрэгцүүлж төлөвлөж, хэрэгжүүлснээс тухайн жилд зохиогдсон сурах бичиг хугацаандаа нийлүүлэгдэхгүй байхад хүргэсэн байна. Тухайлбал,

- Сурах бичгийн зохиогчийн багийн бүрэлдэхүүний 49.1 хувийг их, дээд сургуулийн багш, 26.1 хувийг ЕБС-ийн багш, 17.5 хувийг мэргэжлийн байгууллагын судлаач, мэргэжилтэн, арга зүйч, 6.5 хувийг бусад төрийн бус байгууллага зэргийн төлөөлөл бүрдүүлсэн, 2013 оноос хойш өнөөг хүртэл сурах бичиг, багшийн номын эх зохиоход дунджаар 5-6 сар зарцуулсан бөгөөд бага ангийн нэг сурах бичигт 5-6 хүн зохиогчоор ажилласан, нийт 95 зохиогчдын 45 хувь нь нэгээс илүү тооны сурах бичигт ажилласан бөгөөд эдгээр зохиогчийн 52 нь буюу 54.7 хувь нь сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулахад оролцсон байна. Өөрөөр хэлбэл нийт зохиогчдын хоёр

хүн тутмын нэг нь сурах бичиг, сургалтын хөтөлбөр боловсруулахад давхар ажиллажээ.

⁵⁸ 2.1.1 гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалт явуулах сургалтын төлөвлөгөө, хичээлийн кикриколимийг боловсруулан аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын төвөөр батлуулсан байхаас гадна багшлах бүрэлдэхүүн, нэмэлт сурах бичиг, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнийг мөн төвөөр хянуулж, шаардлагад нийцэх, эсэх талаар дүгнэлт гаргуулсан;

2.28 Одоо мөрдөгдөж буй БСШУС-ын 2009 оны 131 дүгээр тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам”-д сурах бичгийн эх зохиох баг бүрдүүлэхтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй, шинээр болон дахин хэвлэх сурах бичгийн жагсаалтыг жил бүр батлах⁵⁹ зохицуулалттай байх тул сурах бичиг, багшийн номын жагсаалтыг эх зохиохоос 1-2 жилийн өмнө батлах, эх зохиох багийг бүрдүүлэх зохион байгуулалт, үйл ажиллагааны хугацаа зэргийг журамлаж зохицуулах шаардлагатай байна.

2.29 Сургалтын хөтөлбөрт хичээл хоорондын уялдаатай байдал, интеграци хичээл заах талаар тусгасан боловч сурах бичгийн стандартад тухайн сурах бичгийн агуулга нь бусад сурах бичгийн агуулгатай хэрхэн яаж уялдахыг тодорхой зааж өгөөгүй байна. Тухайлбал сурах бичгийн стандартын 5.1.7 -д “сурах бичгийн агуулга нь мэдлэгийн бусад салбартай холбогдсон байна” гэж заасан боловч бусад хичээлтэй ямар хэлбэрээр, хэрхэн уялдсан байхыг сургалтын хөтөлбөр, стандартад тодорхой тусгаагүй байна.

2.30 Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хуульд заасны дагуу суралцагчийг бие даан суралцах чадвартай болгохыг зорьж буй хэдий ч хэвлэмэл сурах бичигт тавигдах шаардлагыг шинэчлэх шаардлага үүссэн, одоо ашиглаж буй сурах бичгүүд суралцагчдын бие даан суралцах хэрэгцээ, шаардлагыг хангахгүй, сурах бичгийн жишээ дасгал, жишээ бодлого болон жишээ даалгавар нь хүрэлцээгүй, зарим сэдэвт жишээгүйгээс нэмэлт ном, гарын авлага ашиглахад хүргэж байна.

- MNS 5418:2008 “Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага”-ын стандартад хэвлэмэл сурах бичигт тавих ерөнхий шаардлагын 4.2-т “Боловсролын стандарт, кинрикулим болон эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна” гэж тусгасан, жишээ дасгал, даалгавар хэдий хэмжээний байх талаар заалт, зохицуулалтгүйгээс сурах бичигт жишээ дасгал, жишээ бодлого харилцан адилгүй, хүрэлцээгүй тусгагдаж байгаа бөгөөд агуулга, арга зүйн шаардлагад суралцагчийн бие даан суралцах хэрэгцээг хангахтай холбоотой зохицуулалтгүй байна.
- Аудитын хүрээнд цахимаар авсан санал асуулгад хариулсан 6096 багш, ажилтны 48.6 хувь нь сурах бичгийн агуулга сургалтын хөтөлбөртэй уялдаж буй байдал хангалтгүй, нэмэлт ном, материал ашиглахад хүрдэг, 26.2 хувь нь зарим агуулга, сэдвийг хичээлийн цагт багтаах боломжгүй байдаг гэж хариулжээ,

2.31 Боловсролын хүрээлэнгээс хийсэн судалгааны тайлангаас үзэхэд⁶⁰ нийслэлийн нэг сургуулийн бага ангид 8-9, дунд ангид 5-6, ахлах ангид 9-10 тооны сургалтын материал хэрэглэдэг байна. Нийт сургуулийн бага ангид давхардсан тоогоор 63, дунд ангид 61, ахлах ангид 109 төрлийн сургалтын материал хэрэглэдэг байна. Өөрөөр хэлбэл нийт сургалтын материалын 34.4 хувь нь бага, 23.6 хувь нь дунд, 42.1 хувь нь ахлах ангид хэрэглэгдэж байгаа бөгөөд байгалийн ухааны сургалтын материалыг ихэвчлэн олимпиадын бэлтгэлд хэрэглэх байдал ажиглагджээ. Тухайлбал,

- Бага ангид хэрэглэж буй сургалтын материалын дийлэнх буюу 90.0 орчим хувийг математик, монгол хэлний сургалтын материал;
- Дунд ангид хэрэглэж буй сургалтын материалын 60.0 орчим хувийг математик, монгол хэл, 12.0-13.0 орчим хувийг орос хэл, англи хэл, хими, физикийн сургалтын материал;
- Ахлах ангид хэрэглэж буй сургалтын материалын ихэнх хувийг англи хэл, математик, нийгмийн ухааны хичээлийн материал тус тус эзэлж байна.

Дүрслэл 18. Сургалтын материал, судлагдахуунаар /эзлэх хувь/



⁵⁹ Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журмын 1.2. Жил бүр шинээр болон дахин хэвлэх сурах бичгийн жагсаалтыг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага /цаашид "яам" гэнэ/ батална.

⁶⁰ Эх сурвалж: “ЕБС-д нэмэлтээр хэрэглэж буй сургалтын материалын нэр, төрлийг тодорхойлох” судалгааны ажлын тайлан

Сургалтын чанарын үнэлгээнд ерөнхий боловсролын сургалтын байгууллагуудыг бүрэн хамруулдаггүй байна

2.32 Боловсролын үнэлгээний төв /цаашид БҮТ гэх/ нь салбарын сайдын баталсан ерөнхий боловсролын сургуулийн сурагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журмын дагуу жилд 2 удаа чанарын үнэлгээ хийдэг байна.

- Аудитын явцад багш ажилтнуудаас авсан санал асуулгаар “Одоо мөрдөгдөж буй суралцагчийн болон сургуулийн чанарын үнэлгээний журам хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэж, үнэлгээ бодитой хийгдэж байна уу?” гэсэн асуултад оролцогчдын 55.3 хувь нь учир дутагдалтай, сайжруулах шаардлагатай гэж хариулжээ.

Хүснэгт 21. Боловсролын үнэлгээний талаар хууль, хөтөлбөрийн холбогдох заалтууд

	Хууль, хөтөлбөр	Хуулийн заалт
1	Боловсролын тухай хууль	5 дугаар зүйл Боловсролын үндсэн зарчим 5.1. Боловсролын үндсэн зарчим нь: 5.1.6. өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр боловсролын байгууллагад адил тэгш хандана.
		17 дугаар зүйл Боловсролын үнэлгээний байгууллага 17.1. Боловсролын үнэлгээний байгууллага бүх шатны боловсролын чанарт үнэлгээ, судалгаа хийх, дээд боловсролын хөтөлбөрт элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтыг үндэсний түвшинд хариуцан зохион байгуулах чиг үүрэг бүхий хуулийн этгээд мөн. 17.2. Боловсролын үнэлгээний байгууллагын бүтэц, дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.
		28 дугаар зүйл Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 28.1.4. бүх шатны боловсролын стандарт, норм, нормативыг Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулах; 28.1.8. боловсролын хөтөлбөр, норм, нормативыг хэрхэн хэрэгжүүлж байгааг тогтоох зорилгоор боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн чанарт үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, хүүхдийн хөгжлийн ахиц дэвшлийг дэмжих, баталгаажуулах чиглэлээр мэргэжлийн удирдлагаар хангах;
		13 дугаар зүйл Ерөнхий боловсролын тусгай сургууль 13.9. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн боловсролын үнэлгээний журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засагийн газрын гишүүн батална.
2	Бага дунд боловсролын тухай	4 дүгээр зүйл. Боловсролын агуулга, стандарт, сургалтын технологи, чанарын үнэлгээ 4.8. Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын стандарт, цөм хөтөлбөрийг төрөөс тогтоож, чанар, үр дүнг үнэлнэ.
3	Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024/	3.2.9. Боловсролын түвшин, чиглэл тус бүрээр үнэлгээний систем, шалгуур, аргачлалын хянан сайжруулж үйлчилгээний чанар, үр дүнг эцэг, эх, суралцагчдын оролцоотой үнэлэх боломжтой болгоно.
	МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	

Эх сурвалж: www.legalinfo.mn

2.33 БҮТ-ийн захирлын тушаалаар байгуулсан Боловсролын хүрээлэн, Боловсролын үнэлгээний төв, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын мэргэжилтнүүд болон их дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн багш мэргэжилтнүүдийн төлөөлөл бүхий ажлын хэсэг шалгалтын даалгаврын сан боловсруулдаг байна.

Хүснэгт 22. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийг үнэлэх үнэлгээ,

Үзүүлэлт	Хамрах түвшин	Хамрах хүрээ	Шалгалт зохион байгуулах, дүгнэх
Анги дэвших шалгалт	Бүх түвшин	Бүх суралцагч	Сургууль
Улсын шалгалт	V, IX, XII анги	Бүх V, IX, XII анги төгсөгчид	Сургууль
Элсэлтийн ерөнхий шалгалт	XII анги төгсөгчид	Элсэлтийн ерөнхий шалгалт өгөх хүсэлтэй 12 дугаар анги төгсөгчид	Боловсролын үнэлгээний төв
Сургалтын чанарын үнэлгээ	V, IX, XII ангиудаас Түүврийн аргаар хамруулдаг	Түүврийн аргаар хамруулдаг	Боловсролын үнэлгээний төв

Эх сурвалж: Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам, Элсэлтийн ерөнхий шалгалтын журам

2.34 БҮТ бага, суурь, бүрэн дунд боловсролын чанарыг үнэлэх зорилгоор 5, 9, 12 /эсвэл 3, 9, 10/ дугаар ангийн сурагчдаас авсан боловсролын чанарын үнэлгээний судалгаанд 2.42-11.51 хувийг хамруулсан нь “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын 6.3.”Чанарын үнэлгээнд өмчийн бүх хэлбэрийн

ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчийн 10-аас доошгүй хувийг хамруулна” гэсэн заалттай нийцэхгүй байна. /2019 онд IX ангийн суралцагчдыг бүрэн хамруулсан байна./

Хүснэгт 23 2016-2020 онуудад боловсролын чанарын үнэлгээнд хамрагдсан суралцагчдын тоо, нийт хамрагдагсдын тоо: /эзлэх хувиар/

Боловсролын түвшин/ хамрагдалт	2016-2017		2017-2018		2018-2019		2019-2020	
	Нийт суралцагчийн тоо	эзлэх хувь	Нийт суралцагчийн тоо	эзлэх хувь	Нийт суралцагчийн тоо	эзлэх хувь	Нийт суралцагчийн тоо	эзлэх хувь
Бага боловсролын түвшинд	309,355	1.60	288,345	6.60	327,019	0.43	356,904	5.20
Дунд боловсролын түвшинд	176,210	2.50	167,364	9.40	184,017	23.40	222,153	19.90
Бүрэн дунд боловсролын түвшинд	87,187.0	5.20	96,244.0	9.40	82,114.0	29.00	7,200.0	7.10
Нийт	572,752	2.42	551,953	9.1	593,150	11.51	586,257	10.3

Эх сурвалж: БҮТ, www.esis.edu.mn

2.35 БҮТ-ээс 2017-2020 онд авсан чанарын үнэлгээний судалгаанд хамрагдсан сургуулиудын жагсаалтаас үзэхэд бага төлбөртэй, хотын захын сургуулиуд, аймгийн төвөөс алслагдсан байршилтай сум, багийн сургуулиудыг хамруулаагүй байна.

- Сургалтын төлбөртэй холбоотой /Хувийн сургуулиудын хамрагдсан төлбөрийн хэмжээг авч үзэхэд 2017 онд төлбөрийн хэмжээ 450.0 мянган төгрөгөөс 42.5 сая төгрөгийн хооронд байсан бол тухайн онд түүвэрт хамрагдсан сургуулиудын төлбөрийн хэмжээ 2.4 сая төгрөгөөс 9.1 сая төгрөгийн хооронд, 2020 онд 733.3 мянган төгрөгөөс 44.9 сая төгрөгийн хооронд байсан бол хамрагдах сургуулиудын төлбөр 3.5 сая төгрөгөөс 5.99 сая төгрөгийн хооронд тус тус байжээ/
- Судалгаанд 2016-2018 онд хамрагдсан сумдын сургуулиудын аймгийн төвөөс алслагдсан зайн дундаж 83-123 км, 0-50 км алслагдсан 13 сум, 51-100 км алслагдсан 12 сум, 101-200 км алслагдсан 23, 200 км-с дээш алслагдсан 5 сум хамрагдсан байна.

2.36 Боловсролын үнэлгээний төвийн чанарын үнэлгээний судалгаанд эчнээ, дүйцүүлэх хөтөлбөр, олон улсын хөтөлбөртэй сургуулиудыг хамруулдаггүй нь Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6, 17 дугаар зүйлийн 17.1, “Боловсролын үнэлгээний төв”-ийн дүрмийн 2.1.2⁶¹ дахь заалтуудад нийцэхгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг үнэлж дүгнэх журам, шалгуургүйгээс үнэлгээнд бүрэн хамрагддаггүй байна

2.37 Салбарын яамны зүгээс Бага дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9⁶²-д заасан “Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн үнэлж дүгнэх журам”, “Ерөнхий боловсролын сургуулийн боловсролын суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын 3.15⁶³-д заасан “Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын суралцагчийн шалгуур” батлаагүйгээс чанарын үнэлгээний судалгаанд тусгай сургуулийн буюу хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын чанарыг үнэлж дүгнэдэггүй байна.

2.38 БҮТ-ээс 2019 онд улсын хэмжээний нийт 9 дүгээр ангийн сурагчдыг хамруулсан чанарын үнэлгээний судалгаанаас харахад сурлагын амжилт сургуулийн хэв шинжээс шалтгаалж харилцан адилгүй байна.

⁶¹ Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын чанарт хяналт шинжилгээ, үнэлгээ, судалгаа хийж санал, дүгнэлт гаргах;

⁶² 13.9. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн боловсролын үнэлгээний журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

⁶³ 3.15. Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийг тухайн төлөвлөгөө, хөтөлбөрт нийцсэн шалгуураар үнэлнэ. Шалгуурыг боловсролын эрдэм жиншилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулна

Дүрслэл 19. Сурлагын амжилт /2016-2018 он/



Эх сурвалж: Боловсролын үнэлгээний төв


Дүрслэл 20. Сурлагын амжилт /2016-2018 он/



Эх сурвалж: Чанарын үнэлгээний судалгаа

2.39 Боловсролын үнэлгээний төв нь жил бүрийн чанарын үнэлгээний судалгааны тайлан, дүгнэлт, зөвлөмж, судалгааны дэлгэрэнгүй дүн зэргийг аймаг, нийслэлийн боловсролын газар, хамрагдсан сургууль тус бүрээр хүргүүлж, хамтран ажилладаггүй нь орон нутагт тухайн сургалтын чанарт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, сурлагын чанарыг сайжруулах боломжийг хязгаарлаж, уг судалгааны үр нөлөөг бууруулж байна.

Дүрслэл 21. Улсын хэмжээнд бага боловсролын хамран сургалт хамгийн өндөр сургуулиудын чанарын үнэлгээний дүнгийн харьцуулалт /Гүйцэтгэлийн хувь/



Эх сурвалж: Чанарын үнэлгээний тайлан

2.40 Мөн сурлагын амжилтад сургуулийн нийт хүүхэд, нэг бүлэгт хичээллэж буй хүүхдийн тоо нөлөөлж байгаа нь харагдаж байна. Тухайлбал,


- Бага боловсролын хамран сургалт хамгийн өндөр, дүрслэлд дурдсан сургуулиудын сургалтын чанарын үнэлгээг нийслэлийн дундажтай харьцуулахад дараах байдалтай байна.
- Шашны сургалттай сургуулиуд ЭЭШ-д бүрэн хамрагддаггүй, суралцагчдын дүнгийн үнэлгээ улсын дунджаас доогуур байна.

Дүрслэл 22. Улсын шалгалтын харьцуулалт /112-р сургууль, 2019 он/



Эх сурвалж: www.esis.edu.mn

Дүрслэл 23. ЭЕШ-ын харьцуулалт /112-р сургууль, 2017 он/



Эх сурвалж: www.esis.edu.mn www.stat.eec.mn


2.41 “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д тусгасны дагуу сурлагын амжилтыг үнэлэх олон улсын судалгаа PISA-д хамрагдахтай холбогдуулан БҮТ-ийн дэргэд үндэсний баг байгуулагдан бэлтгэл ажлуудыг гүйцэтгэж байгаа боловч Ковид-19 цар тахлаас шалтгаалан сургуулиуд хаагдан шалгалт зохион байгуулах боломжгүй нөхцөл байдал үүссэний улмаас PISA 2021 судалгааг нэг жилээр хойшлуулж зохион байгуулах шийдвэр гаргасан байна.

Сургуулийн өөрийн үнэлгээний дүн, Боловсролын үнэлгээний төвийн чанарын үнэлгээний судалгааны дүнгээс хэт зөрүүтэй байна

2.42 Ерөнхий боловсролын сургуулиуд өөрийн үнэлгээ буюу улсын шалгалтыг сургалтын чанарын үнэлгээний журмын дагуу БҮТ-ийн баталгаажуулсан блюпринт, шалгалтын сэдэв боловсруулах, дүгнэх зөвлөмжийг үндэслэн зохион байгуулж байна.

2.43 Боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгэгдсэн улсын шалгалтын дүнг, БҮТ-ийн чанарын үнэлгээний дүнтэй харьцуулахад 30.8-62.9 пунктээр зөрүүтэй байгаа нь өөрийн үнэлгээний дүн бодитой бус байгааг харуулж байна.

Дүрслэл 24. XII ангийн суралцагчдын сурлагын үнэлгээний харьцуулалт /2018 он/



Эх сурвалж: Боловсролын мэдээллийн технологийн төв, ЧҮС

2.44 Улсын шалгалтын зохион байгуулалт, хяналт муу байгаагаас зарим сургуулиуд шалгалтын дүнг Боловсролын удирдлагын мэдээллийн системд иж бүрэн оруулдаггүй, БҮТ нь улсын шалгалтын дүнд шинжилгээ хийдэггүй нь чанарын үнэлгээний журмын холбогдох заалттай⁶⁴ нийцэхгүй байна.

2.45 “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон чанарын үнэлгээний журам” 2018 онд батлах хүртэл шалгалтад 0-59 хувь авсан суралцагчийг “хангалтгүй” үнэлгээгээр үнэлдэг байсан бол 2018 оноос 0-59 хувийг дараах түвшинд үнэлдэг болсон байна. Үүнд:

⁶⁴ 2018 онд батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын 5.13. Боловсролын үнэлгээний байгууллага нь боловсролын салбарын мэдээллийн системд оруулсан улсын шалгалтын дүнд шинжилгээ хийж, жил бүрийн 10 дугаар сард багтаан, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олон боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагад тус тус хүргүүлнэ.

- 0-29 хувь Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахууныг таних, нэрлэх түвшинд эзэмшсэн;
- 30-39 хувь /0-29 хувь + Эзэмшсэн мэдлэг ойлголтоо заавар, аргачлалын дагуу ашигладаг;
- 40-49 хувь /30-39 хувь + Бусдын дэмжлэгтэй зааврын дагуу хялбар асуудлыг шийдвэрлэдэг, Асуулт асууж, таамаглал дэвшүүлдэг;
- 50-59 хувь /40-49 хувь + Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах аргыг сонгон хэрэглэхийг хичээдэг, асуудал мэдээллийг эргэцүүлэн бодож, санаа бодлоо энгийн байдлаар илэрхийлдэг/

Хүснэгт 24. XII ангийн улсын шалгалтын үнэлгээний харьцуулалт

№	2010 оны “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшилийг үнэлэх, дүгнэх журам”		2013 оны “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам”		2018 оны “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”	
	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ	Хувь	Үнэлгээ	Хувь
1	A	90-100	A+	97-100	VIII	90-100
2	B	80-89	A	93-96	VII	80-89
3	C	70-79	A-	90-92	VI	70-79
4	D	60-69	B+	87-89	V	60-69
5	F	0-59	B	83-86	IV	50-59
6			B-	80-82	III	40-49
7			C+	77-79	II	30-39
8			C	73-76	I	0-29
9			C-	70-72		
10			D+	67-69		
11			D	63-66		
12			D-	60-62		
13			F	0-59		

Эх сурвалж: Чанарын үнэлгээний журмууд

2.46 Суралцагчийн шалгалтын 0-59 хүртэл онооны үнэлгээг 2018 оны “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-аар 4 түвшинд хувааснаар тухайн суралцагчийн ахицыг бодитоор үнэлэх боломж бий болсон байна.

Элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн суралцагчдын 58 орчим хувь нь улсын их дээд сургуулийн, 82 орчим хувь нь хувийн их дээд сургуулийн босго оноонд тэнцдэг байна

2.47 Боловсролын тухай хуулийн 17¹ дүгээр зүйлийн 17^{1.1} “Боловсролын үнэлгээний байгууллага бүх шатны боловсролын чанарт үнэлгээ, судалгаа хийх, сургалт зохион байгуулах, дээд боловсролын хөтөлбөрт элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтыг үндэсний түвшинд хариуцан зохион байгуулах чиг үүрэг бүхий хуулийн этгээд мөн”, Боловсролын үнэлгээний төвийн дүрэм”-ийн 2.1.10 “Их, дээд сургууль, коллежид элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах, шалгалтын нууцлал, даалгаврын тохироц, найдварыг шалгах, сан бүрдүүлэх, боловсронгуй болгож хөгжүүлэх” заалтуудын дагуу БҮТ жил бүр Элсэлтийн ерөнхий шалгалтыг зохион байгуулах журам баталдаг байна.

2.48 БШУС-ын 2013 оны А/79 дүгээр тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам”-ын 1.11. “Дээд боловсролын сургалтын байгууллагад элсэгчдийн хангавал зохих энэхүү журмын 2.2-д заасан ерөнхий шалгалтын үндэсний хэмжээний босго оноог боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр тогтооно” гэж заасны дагуу БШУС-ын тушаалаар жил бүр их дээд сургуулийн босго оноог баталдаг байна.

Хүснэгт 25. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүн ИДС-ын босго онооны харьцуулалт /2018-2020/

№	Он	Нийт шалгуулагчийн тоо	Улсын ИДС-н босго оноонд тэнцсэн шалгуулагчийн тоо	Хувийн ИДС-ын босго оноонд тэнцсэн шалгуулагчийн тоо
1	2018 он	135,961	79,330	112,066
2	2019 он	53,615	31,362	43,880
3	2020 он	91,977	53,469	75,074
	Нийт	281,553	164,161	231,020


Эх сурвалж: Боловсролын үнэлгээний төв

2.49 ЭЕШ-д шалгуулагчдын дүн оноог анхны оноо, хэмжээст оноо, проценталь оноо, амжилтын чанарын индекс гэсэн үзүүлэлтээр эрэмбэлэн дүгнэдэг байна.

- Анхны оноо /100 хүртэлх оноо/ гэдэг нь тухайн хичээлийн шалгалтын сэдэв, даалгаврыг хэрхэн гүйцэтгэснийг илтгэх үнэлгээ бөгөөд авбал зохих онооноос хэдэн оноо авсныг хувьд шилжүүлсэн тоон үзүүлэлт
- Хэмжээст оноо /200-800 хүртэл/ гэдэг нь тухайн хичээлийн нийт гүйцэтгэлийг шалгалтад орсон шалгуулагчдын гүйцэтгэлтэй харьцуулан хэмжээсжүүлж үзүүлсэн оноо. Хичээл бүрийн анхны оноог шилжүүлсэн хэмжээст оноо өөр өөр гардаг. Хэмжээст оноо нь 200-800 хооронд гардаг
- Проценталь оноо /100 хувь хүртэл/ нь шалгуулагч тухайн хичээлийн шалгуулагчдын жагсаалтад хэдэд байгааг харуулсан үзүүлэлт юм. Шалгуулагчийн проценталь оноо 98.2 гэсэн байвал тухайн шалгуулагчтай нь ижил буюу их оноо авсан шалгуулагч нийт шалгуулагчийн 1.8 хувь байна гэсэн үг.

2.50 Сургалтын цөм хөтөлбөрийн дагуу суралцагчид 10, 11, 12 дугаар ангидаа заавал судлах хичээлээс гадна нэмэлтээр хичээлүүд сонгон судалдаг хэдий ч 12 дугаар анги төгсөх үедээ тухайн судалсан хичээлүүдээс гадна сонгон судлаагүй хичээлээр ЭЕШ өгдөг байна.

Дүрслэл 25. XII ангийн сурагчдын хичээл сонголт, ЭЕШ өгсөн тоон харьцуулалт /2017-2019 оны нийлбэр дүнгээр/



Эх сурвалж: www.esis.edu.mn www.stat.eec.mn

Дүрслэл 26. Элсэлтийн ерөнхий шалгалтын хичээл сонголтын тоо /хичээлийн эзлэх хувь/



Эх сурвалж: www.stat.eec.mn

2.51 ЭЕШ-д тавих хяналт сул байгаагаас МУЗГ-ын 2013 оны 37 дугаар “Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай” тогтоолын 1.2⁶⁵ дахь заалтыг үндэслэн жил бүрийн элсэлтийн ерөнхий шалгалт зохион байгуулах шалгалтын журамд монгол хэлбичгийн шалгалт заавал өгөх тухай 1.4-т⁶⁶ заасан хэдий ч нийт шалгуулагчдыг бүрэн хамруулдаггүй байна.

Хүснэгт 26. Элсэлтийн ерөнхий шалгалтын шалгуулагчийн тоон харьцуулалт

Он / Шалгуулагчийн тоо	2016-2017	2017-2018	2018-2019	Нийт дүн
Нийт шалгуулагчийн тоо	39,579	41,095	17,064	97,738
Монгол хэл бичгийн шалгалт өгсөн шалгуулагчийн тоо	38,017	40,643	16,881	95,541
Зөрүү	1,562	452	183	2,197

Эх сурвалж: Элсэлтийн ерөнхий шалгалтын статистик

2.52 Орон нутагт сургалтын чанарын үнэлгээнээс илүүтэй ЭЕШ-д ач холбогдол өгөх хандлага их байх тул чанарын үнэлгээний ач холбогдлыг сурталчлан таниулах, үнэлгээний дүнг аймаг, нийслэлийн боловсролын газар, ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлж,

⁶⁵ “Ерөнхий боловсролын сургууль төгсөгч, их, дээд сургууль, коллежид элсэгчдээс монгол хэл бичгийн хичээлээр шалгалт авч байх журам тогтоон 2013-2014 оны хичээлийн жилээс эхлэн мөрдүүлэх”

⁶⁶ 2017 оны элсэлтийн ерөнхий шалгалтын журам: 1.4. Их дээд сургуульд элсэн суралцахаар ЭЕШ-д бүртгүүлсэн шалгуулагч нь Монгол Улсын Засгийн газрын 37 дугаар тогтоолын дагуу Монгол хэлбичгийн шалгалт /цаашид МХБШ/-ыг заавал өгнө
2018, 2019 оны элсэлтийн ерөнхий шалгалтын журам: 1.4. Их дээд сургуульд элсэн суралцахаар ЭЕШ-д бүртгүүлсэн шалгуулагч нь Монгол Улсын Засгийн гаурын 37 дугаар тогтоолын дагуу Монгол хэлбичгийн шалгалт /цаашид МХБШ/-хамрагдсан байна.

алдаа дутагдлаа засаж сайжруулах боломж олгох эргэх холбоо үүсгэх талаар салбарын яам анхаарч ажиллах шаардлагатай байна. Тухайлбал,

Баянхонгор аймаг

- ЭЕШ-ийн үнэлгээ 2017-2018 онд 15 байраар буурсан нь 2016-2017 оны хичээлийн жилд сайн хүүхдээ сайн болгоё гэсэн зорилт тавьж зөвхөн ЭЕШ-д хамрагдах багш нарын дунд болзолт уралдаан явуулж мөнгөн урамшуулал олгох хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд улсын хэмжээнд 6 дугаар байрт орж байсан ч дараагийн жилээс багш нараас босго үзүүлэлтийг бууруулах санал гарснаар үргэлжлүүлж хэрэгжүүлээгүйтэй холбоотой” гэсэн тайлбар өгч байна

Баян-Өлгий аймаг

- “Элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнг дээшлүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд ЭЕШ-ын дундаж оноо 2018 онд зорилтот түвшнээс 7.5 буюу өмнөх оноос 30.2 оноогоор ахисан байна. ЭЕШ-ын дундаж оноогоор тус аймаг нь улсын хэмжээнд өмнөх онд 21 дүгээр байранд орж байсан бол 2018 онд 18 дугаарт, 2019, 2020 онд тус үзүүлэлт нь буурсан байна. ЭЕШ-ын дүнг дээшлүүлэх зорилгоор аймгийн ЗДТГ, БСУГ хамтран 2019 онд “ЭЕШ 2019” 2 сарын аяныг зохион байгуулсан байна. Энэ хүрээнд төгсөх ангийн сурагчдын түвшнийг тогтоох, шалгалтын дэвтэр, хариултын хуудсан дээр ажиллуулж сургах зорилгоор “Цахим сорилго” компанитай хамтран УИХ-ын гишүүн Х.Баделханы нэрэмжит цахим сорилгын шалгалтыг 10 хичээлээр Өлгий сумын ЕБС-ын сурагчдаас авч, үр дүнд шинжилгээ хийж, тэргүүлсэн сурагчдыг шагнаж урамшуулжээ.
- Аймгийн ЗДТГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.2.4-т “Сургалтын чанарыг сайжруулах аймгийн хөтөлбөрийг боловсронгуй болгож, сургалтын чанарыг 81 хувьд хүргэнэ.” гэж заасан. Аймгийн ИТХ-аас 2015-2016 онд “Сургалтын чанарыг сайжруулах” хөтөлбөр, 2017-2020 онд “Сургалтын чанар ахиулах” хөтөлбөрийг баталж хөтөлбөрийн хүрээнд 5 удаагийн хөндлөнгийн үнэлгээний шалгалтыг зохион байгуулахад 58.6 сая төгрөг, хөндлөнгийн үнэлгээний шалгалтаар 60 хувиас дээш үнэлэгдсэн Заах аргын нэгдэл, ЭЕШ-д 800 оноо авсан багш, сурагч, шавь нь тив дэлхийн уралдаан тэмцээнд амжилт гаргасан багш, ЭЕШ-д сурагчдаа амжилттай бэлтгэж улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн судлагдахууны багийг урамшуулах зэрэг шалгуур үзүүлэлтээр шалгаруулж 201.6 сая төгрөгийг шагнал, урамшуулалд зарцуулжээ.

2.53 Сургалтын чанарын үнэлгээ нь суралцагчийн мэдлэгийн түвшинг тогтооход түлхүү чиглэсэн хэдий ч бүтээлч сэтгэхүй, бүтээмж, ур чадвар, мэдлэгээ ашиглах чадварыг үнэлэхэд төдийлөн чиглээгүй байна. Тухайлбал,

Хүснэгт 27. БҮТ-с зохион байгуулсан ЧҮС-ний хичээлийн агуулга /он тус бүрээр/

2017 он	Хичээлийн агуулга	2018 он	Хичээлийн агуулга	2019 он	Хичээлийн агуулга
V анги	Математик	V анги	Математик	III анги	Математик
	Монгол хэл		Монгол хэл		Монгол хэл
	Байгаль шинжлэл		Байгаль шинжлэл		Хүн орчин
					Хөгжим
IX анги	Математик	IX анги	Математик	IX анги	Математик
	Монгол хэл		Монгол хэл		Монгол хэл
	Байгалийн ухаан		Байгалийн ухаан		Англи хэл
	Нийгмийн ухаан		Нийгмийн ухаан		Физик
XII анги	Математик	XII анги	Математик	X анги	Математик
	Монгол хэл		Монгол хэл		Монгол хэл
	Гадаад хэл		Гадаад хэл		Биологи
	Сонгосон хичээлийн агуулга		Сонгосон хичээлийн агуулга		Газарзүй

Эх сурвалж: БҮТ-ийн чанарын үнэлгээний судалгаа /2017-2019 он/


Сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг бодитой үнэлж дүгнэдэггүй, тэдгээрийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлдэггүй байна

2.54 БСШУСС-ын 2018 оны А/425 тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын 6.1-д “Бага дунд боловсролын чанарын үнэлгээ нь суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг үндэсний түвшинд тогтоох, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд чиглэнэ” гэж заасан байна.

2.55 Түүвэрт хамрагдсан сургуулиудын боловсролын чанарын үнэлгээний шалгалтын гүйцэтгэлийг сурагч, багш, сургуулийн захирал, удирдах ажилтан, эцэг эхээс авсан асуулга судалгаанд хэрхэн хариулсантай холбон үзэж сурлагын амжилтын хүчин зүйлийн нөлөөллийг тодруулдаг байна.

2.56 Аудитын явцад багш ажилтнуудаас авсан санал асуулгаар сурлагын чанарт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн судалгаанд нийт оролцогчдын 58 хувь нь сургалтын хөтөлбөрийн тогтворгүй байдал гэж хариулсан байна. Тухайлбал,

Дүрслэл 27. Сургалтын чанарын нөлөөллийн талаар судалгааны дүн




Эх сурвалж: Орон нутаг дах төрийн аудитын газрын тайлан

2.57 Боловсролын хүрээлэнгээс “Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс” - д 2019 онд хийсэн судалгаагаар бага, суурь, бүрэн дунд түвшин бүрээр сургалтын амжилтад нөлөөлж буй нөлөөллийг дараах байдлаар дүгнэсэн байна. Тухайлбал,

- Бага боловсролын түвшинд суралцагчдын сургалтын амжилт эцэг эхийн боловсрол, өрхийн дундаж орлого, багшийн ажилласан жил нэмэгдэх тусам сайжирсан;
- Суурь боловсролын түвшинд сургалтын орчин, багшийн ажилласан жил, багшлах арга зүй нөлөөлөхөөс гадна нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, сургалтын хэрэглэгдэхүүн, материалын төрөл зүйл нөлөөлдөг;
- Бүрэн дунд боловсролын түвшинд англи хэл болон дизайн технологийн хичээлийн гэрийн даалгавар хийхдээ ашиглаж буй материал, сурагчдын унтах цаг нь суралцагчдын гүйцэтгэлд ач холбогдол бүхий ялгаатай гэж дүгнэжээ.

Дүрслэл 28. Сургуулийн хэмжээнд сургалтын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, үнэлэх ажил хийгддэг эсэх судалгааны дүн



Эх сурвалж: Багш, ажилтнуудаас авсан судалгаа

2.58 Аудитын явцад багш ажилтнуудаас цахимаар авсан санал асуулгад “Сургуулийн хэмжээнд сургалтын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, үнэлэх ажил хийгддэг үү” гэсэн асуултад 56 хувь нь хийгддэг буюу тийм гэж хариулсан байна.

2.59 БҮТ нь сурлагын амжилтад сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг асуулга, судалгаагаар үнэлдэг хэдий ч салбарын яамны зүгээс уг үнэлгээний дүнд анализ хийх, нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна.

Салбарын дотоод болон хөндлөнгийн хяналт үр нөлөө багатай байна

Салбарын яамны хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын нэгжийн үндсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна

2.60 ХШҮДАГ нь Боловсролын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 “Боловсролын хяналтыг хяналт-шинжилгээ, тандалт, судалгаа хийх хэлбэрээр хэрэгжүүлнэ”, 28 дугаар зүйлийн 28.1.2⁶⁷, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 9 дүгээр зүйлийн 9.4, 10 дугаар зүйлийн 10.7 дахь заалтын дагуу Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэгтэй байна.

2.61 Мөн МУЗГ-ын 2017 оны 267 дугаар тогтоолоор баталсан “Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т тус

⁶⁷ 28.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.1.2.боловсролын салбарын хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэл, төлөвлөгөө, үзэл баримтлал, үндсэн чиглэл, дүрэм, журам, хөтөлбөр, төсөл, заавар, аргачлалыг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тооцох;

яамны хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүргийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилт болон яамны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, боловсролын хяналтыг хяналт-шинжилгээ, тандалт, судалгааны хэлбэрээр хэрэгжүүлж салбарын бодлогыг үр дүнтэй болгох, салбарын болон яамны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.62 ХШУДАГ нь 2017-2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий боловсролын салбарт хийхээр тусгагдсан дараах хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй, тайлагнаагүй нь нэгжийн үндсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна. Тухайлбал,

2017 он

- Салбарт хэрэгжиж буй гадаадын зээл, тусламжийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх,
- Боловсролын байгууллагын сургалтын орчны аюулгүй байдал, дотуур байранд суралцагчид эрсдэлд өртөж болзошгүй хүчин зүйлийн судалгаа хийх, хяналт-шинжилгээ хийж дүгнэлт санал, зөвлөмж гаргах,
- Ерөнхий боловсролын сургуульд хичээлээс гадуур явуулж буй үйл ажиллагаа, сонгон, секц, дугуйланг хичээллүүлж буй өнөөгийн нөхцөл байдалд тандалт судалгаа хийх,

2018 он

- Сурах бичиг зохих, хэвлэх, түгээх журмын хэрэгжилтэд болон бага ангийн сурах бичиг болон сурах бичгээс гадна ашиглаж байгаа номын агуулга, арга зүйд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх,
- Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гаргах,

2019 он

- Эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллага болон орон нутгийн боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийнэ.
- Дотуур байрны хүртээмжийн байдалд хяналт-шинжилгээ хийх,
- Тусгай зөвшөөрөл олголтын байдалд хяналт-шинжилгээ хийх

2.63 БШУЯ нь “Боловсрол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого хэрэгжиж эхэлснээс хойш 4 жилийн хугацаанд 1 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ЗГХЭГ-т 2019 онд хүргүүлсэн нь уг бодлогын баримт бичгийн 7.5⁶⁸, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6⁶⁹, 10 дугаар зүйлийн 10.7⁷⁰-д заасантай нийцэхгүй байна.

2.64 Нийслэлийн боловсролын газрын зүгээс 2017-2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу стандарт хөтөлбөрийн хэрэгжилт, санхүү төсвийн үйл ажиллагаа, хүүхдийн тооны гүйцэтгэл, сургуулийн үйл ажиллагаа, улсын шалгалтын үйл ажиллагааны хяналт, индексийн шалгалт, насан туршийн боловсролын үйлчилгээ, хүртээмж, сургууль завсардалт, дүйцсэн хөтөлбөрийн хэрэгжилт, захирамж, тушаал, шийдвэр, тогтоол, дүрэм, журам, албан тоотын хэрэгжилт зэрэгт хийсэн хяналт, шалгалтаар дараах зөрчлүүд илэрчээ. Үүнд:

- Багш нар хүрэлцээгүйгээс мэргэжлийн бус хүн ажиллуулах;
- БСШУС-ын 2008 оны 98 дугаар тушаалыг зөрчин ЕБС-ын биеийн тамирын заалыг түрээслүүлэх;
- Сурагчдын ирцийн бүртгэл, өдрийн хоолны зарцуулалтын тооцоолол нь дутуу;
- Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл дэх хүчин чадал барилгын хувийн хэрэг дэх хүчин чадал зөрүүтэй байх;
- Багш нарын мэргэжлийн зэргийн хүчинтэй хугацаа дууссан.

2.65 Дээрх байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр тодорхой арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байгаа ч хүний нөөцийн хүрэлцээ, ажлын ачаалал, хяналт шалгалтад сургуулиуд бүрэн хамрагддаггүй зэргээс үр нөлөө багатай, зөрчил арилахгүй жил бүр давтагджээ.

- Нийслэлийн боловсролын газарт хяналтын чиглэлээр 1 хүн, дүүргүүдийн боловсролын хэлтэст статистик мэдээ, хяналт шинжилгээг тус бүр 1 мэргэжилтэн хавсран хууль тогтоомж, хөтөлбөр, баримт бичгийн хэрэгжилтийг хянах, ЕБС-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх үүргийг хэрэгжүүлэхэд орон тоо дутагдалтай байна.

⁶⁸ Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хоёр жил тутамд МУЗГ, УИХ-д тайлагнаж, боловсролын чанарын үр дүнд тогтмол үнэлэлт, дүгнэлт өгч байна

⁶⁹ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль 8.6.Төрийн захиргааны төв байгууллага төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайлан тус бүрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

⁷⁰ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль 10.7.Төрийн захиргааны төв байгууллага жил бүр үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээг хийлгэх ажлыг зохион байгуулж, тайлан тус бүрийг Засгийн газарт танилцуулна.

Ерөнхий боловсролын сургуулиудын дотоод хяналт сул байна

2.66 БСШУС-ын сайд, Сангийн сайдын 2018 оны “Орон тооны жишиг норматив батлах тухай” А/024/11 дугаар хамтарсан тушаалд ЕБС-д дотоод хяналтын ажилтны орон тоог тусгаагүй, зарим сургуульд захирлын тушаалаар дотоод хяналтын ажилтныг томилох, бусад албан тушаалтан хавсран гүйцэтгэж байгаа нь ажилтнуудын ажлын ачааллыг нэмэгдүүлж ажлын үр дүн, дотоод хяналтын үр нөлөөг бууруулж байна.

- 2020-2021 оны хичээлийн жилд нийслэлийн нийт ЕБС-ийн 48 буюу 17.5 хувь нь орон тооны бус дотоод хяналтын ажилтныг сургуулийн захирлын тушаалаар томилсон, 176 буюу 63.6 хувь нь хавсран гүйцэтгүүлсэн, 51 буюу 18.9 хувь нь дотоод хяналтын ажилтангүй байна. Дотоод хяналтын ажилтангүй 51 сургуулийн 25 нь төрийн өмчийн, 26 нь төрийн бус өмчийн сургууль байна.

2.67 Аудитын хүрээнд түүвэрт хамрагдсан нийслэлд үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын сургуулиудын дотоод хяналтын хэрэгжилттэй танилцахад ажлын төлөвлөгөө, тайлан байгаа боловч хэрэгжүүлсэн зарим ажлууд нь баримтаар нотлогдохгүй, үр дүнг тооцож ажиллаагүй байна.

2.68 Орон нутгийн БСУГ-аас ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжиж буй сургалтын хөтөлбөрт жилд 2 удаа хяналт хийж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлдэг гэх боловч баримтжуулалт хангалтгүй, биелэлтийг тооцож ажилладаггүй байна.

Сургуулийн зөвлөлийн хяналтын чиг үүрэг хэрэгждэггүй, мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт шалгалт сургалтын орчинд түлхүү чиглэсэн байна

2.69 Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2017-2019 онд ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаа, сургалтын орчны аюулгүй байдалд эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр хяналт шалгалт хийж дараах нийтлэг зөрчил дутагдлыг илрүүлж ажилласан байна. Үүнд:

- Сургуулийн зөвлөл, удирдах зөвлөл сургуулийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, тодорхой үнэлэлт дүгнэлт өгч ажиллаагүй,
- Багш хөгжлийн төвийн үйл ажиллагааг зохион байгуулж, төсөв санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллаагүй,
- Сургуулийн барилга байгууламж нь сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулах шаардлагыг бүрэн хангахгүй, өөрийн гэсэн эдэлбэр газаргүй,
- Байгалийн ухааны болон дуу хөгжим, гадаад хэлний лаборатори, кабинетгүй, хичээлийн хэрэглэгдэхүүн хангалтгүй,
- Мэргэжлийн үндсэн багшаар бүрэн хангагдаагүй, зарим багш мэргэжлийн бус,
- Сургалт эрхлэх нөхцөл шаардлагад заасан чиглэлээр сургалт явуулдаггүй,
- Төрөлжсөн, гүнзгийрүүлсэн, олон улсын сургалтын хөтөлбөрийн сургалтыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулаагүй зэрэг

2.70 Боловсролын тухай хуульд боловсролын стандарт нь багшийн мэргэжлийн түвшин, сургалтын орчинд тавигдах үндсэн шаардлагаар хязгаарлагдаж байгаагаас ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын үндсэн үйл ажиллагаа, сургалтын агуулга, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хичээлийн цаг зэрэг нь салбарын сайдын баталсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд нийцэж буй эсэхийг хяналт шалгалтад төдийлөн хамруулдаггүй нь дээрх хяналт шалгалтын тайлангаас харагдаж байна.

2.71 Ерөнхий боловсролын сургуулиудад Бага дунд боловсролын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.7⁷¹-д заасны дагуу эцэг эхийн зөвлөл олон нийтийн байгууллагатай хамтарч ажиллах, сургуулийн орчны эрсдэлийн үнэлгээ хийх, сургуулийн ойр орчимд үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний байгууллагад хяналт хийх зэргээр үйл ажиллагаа явуулж буй хэдий ч эцэг эх, олон нийтийн зүгээс тавих хяналт үүрэг оролцоо хангалтгүй, үйл ажиллагаа, харилцан адилгүй, үр дүн багатай байна.

⁷¹ Бага, дунд боловсролын тухай хууль 19.7 Сургуульд эцэг, эх, асран хамгаалагчийн болон суралцагчдын байгууллага ажиллаж болно

2.72 Боловсролын тухай хуулийн 34,35 дугаар зүйлд боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлагыг ерөнхий боловсролын сургуульд сургуулийн зөвлөл хэрэгжүүлж дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгагдсан байна. Тухайлбал:

- Захирал, эрхлэгчийн үйл ажиллагаанд **хөндлөнгийн хяналт тавих**, дэмжлэг үзүүлэх;
- Сургуулийн батлагдсан **төсөв, сангийн зарцуулалтад хяналт тавих**, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлттэй танилцах, мэдээлэх.

2.73 Гэвч аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагуудын зүгээс тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй сургуулиудын үйл ажиллагаатай танилцахад сургуулийн зөвлөл байгуулагдаагүй, үйл ажиллагаа жигдрээгүй байдал түгээмэл ажиглагдаж байгаа нь хуулиар тодорхойлсон чиг үүрэг бүрэн хэрэгжихгүй байгааг харуулж байна. Тухайлбал,

Баян-Өлгий аймаг:

- Түүвэрт хамрагдсан ерөнхий боловсролын 17 сургуульд 9 сургууль холбогдох төлөөллүүдийг оролцуулан 9-11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан боловч үйл ажиллагааны жигдрээгүй, 8 сургууль сургуулийн зөвлөл байгуулаагүй,

Хэнтий аймаг:

- Мөрөн сумын сургуульд сургуулийн зөвлөл байгуулсан боловч төрийн өмчийн 24, хувийн хэвшлийн 1 сургуульд сургуулийн зөвлөл байгуулаагүй,

Хөвсгөл аймаг:

- Эрдмийн далай ЦС болон Их-Уул сумын ЕБС-ийг эс тооцвол бусад бүх сургуулиуд сургуулийн зөвлөл байгуулсан боловч үндсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй, БСУГ-аас 2018 онд сургуулийн зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах зөвлөмжийг бүх сургуулийн захирлуудад өгсөн боловч хэрэгжээгүй;

Дундговь аймаг:

- Мэргэжлийн хяналтын газраас хийсэн сургуулийн зөвлөл нь үйл ажиллагаа, төсөв санхүүгийн зарцуулалт болон сургуулийн захирлын үйл ажиллагаанд хяналт тавих, шалгалтын дүнг сургуулийн зөвлөлөөр хэлэлцүүлж, хамт олондоо тайлагнаагүй зөрчил нийтлэг илэрсэн;

Говь-Алтай аймаг:

- Мэргэжлийн хяналтын газрын хийсэн хяналт, шалгалтаар Алтай, Баян-Уул, Бугат, Жаргалан, Төгрөг, Цээл зэрэг сумын ЕБС Есөнбулаг сумын Хантайшир эрдэм цогцолбор сургуулийн сургуулийн зөвлөл, удирдах зөвлөлийн үйл ажиллагаа тогтворжоогүй байна,

Холбогдох байгууллагын санал:



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,

Утас: 26-22-27, Факс: 263727

И-мэйл: info@mes.gov.mn, Веб сайт: www.mes.gov.mn

2021.08.15 № 2/670

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
О.ТЭНГИС ТАНАА**

Үндэсний аудитын газраас “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан холбогдох саналаа хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 6 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА  Д.БАТБААТАР



1420102414

Боловсрол, шинжлэх ухааны яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны
02 дугаар сарын 15-ны өдрийн албан
бичгийн хавсралт

ТӨРӨӨС БҮХ НИЙТИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОЖ БУЙ ӨНӨӨГИЙН
БАЙДАЛ, ҮР ДҮНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН
ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

2021.02.15

Улаанбаатар

Гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг гаргаж байна.

Тайлбар 1-г
үзнэ үү

Эхний нүүрний -Тайлангийн ерөнхий нэр, үндэслэлийг "Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгоход хөрөнгө оруулалт, санхүүжилтийг оновчтой төлөвлөх, хөндлөнгийн хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай" гэж өөрчлөх,

Тайлбар 2-г
үзнэ үү

10 дугаар нүүр: ... "Цэцэрлэг, сургуулийн орчинд гар утас, цахим хэрэгсэл болон сүлжээг зохистой хэрэглэх журам"-Энэ журам нь танхимын сургалтын үед цэцэрлэг, сургуулийн орчинд мөрдөгдөх журам тул зайны сургалтын үетэй харьцуулж тайлбарласан хэсгийг өөрчлөх,

Тайлбар 3-г
үзнэ үү

14 дүгээр нүүр: ... 1.24 дэх хэсгийн найруулгыг засах... суурь боловсролын хамран сургалтын хувь хэмжээгээр илэрхийлэх,

Тайлбар 4-г
үзнэ үү

15 дугаар нүүр: ... 1.25 дахь хэсэгт сургуульд суралцаагүй болон сургуулийн гадна байгаа сурагчдын албан ёсны статистикийн маягт буюу БДБ-15 маягтаар мэдээг жил бүр гаргадаг. Үүнийг залруулах...

Тайлбар 5-г
үзнэ үү

16 дугаар нүүр: ... 1.33 дахь хэсэг... хотын захын буюу гэр хорооллын сургуульд 38 хүүхэд буюу 20 хувиар хэтэрсэн. 20 хувь гэснийг магадлах,

37 дугаар нүүр: 2.12 сургалтын хөтөлбөр, сурах бичиг агуулгын хувьд зөрүүтэй байгаа гэдгийг аль судлагдахууны хувьд боловсролын аль түвшний багш нараас авсан судалгаанд үндэслэсэн бэ? гэдгийг магадлах.

Тайлбар 6-г
үзнэ үү

38 дугаар нүүр: 2.13 дахь хэсэгт ... орон нутгийн түвшинд мэргэжил дээшлүүлсэн эхлэлүүд тавигдсан байна гэж найруулах...

Тайлбар 7-г
үзнэ үү

39 дүгээр нүүр: 2.21 дэх хэсэгт-Салбарын яам лаборатори сургуулийн захирлыг томилох, хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээ байгуулж, дүгнэн ажиллаж байгаа боловч Боловсролын тухай хуульд заасан лаборатори сургуулийн эрх зүйн зохицуулалт батлагдаагүй, бага, дунд боловсролын судалгаа, аргазүйн туршилт явагдаж дууссан зэрэг нөхцөл байдал нь цаашид лаборатори сургуулийн асуудлыг дахин шинээр тодорхойлон ажиллах эрэлт хэрэгцээг үүсгэж байна.

Тайлбар 8-г
үзнэ үү

42 дугаар нүүр: 2.27...сурах бичиг хугацаандаа нийлүүлэгдэхгүй ...гэдгийг тухайн жилд зохиогдсон сурах бичиг гэж өөрчлөх саналтай байна. Учир нь бүх сурах бичиг хугацаандаа хүргэгддэггүй мэт харагдаад байна. Зөвхөн тухайн жилд зохиогдсон сурах бичгийн хувьд хугацаанаасаа хоцорч очих асуудал гарч байсан.

Тайлбар 9-г
үзнэ үү

43 дугаар нүүр: 2.30...Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага MNS5418:2008 стандартад: сурах бичгийн эх зохиоход агуулга (9), арга зүй (8), үнэлгээ (6), хэл найруулга (5), дизайн (6), эх бэлтгэл, хэвлэлд (23) тавигддаг шаардлага тусгагддаг. Сурах бичгийн эх зохиох, дасгал даалгаврыг боловсруулахад хамгийн гол баримтлах баримт бичиг бол сургалтын хөтөлбөр юм. Сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээтэй нийцүүлэн сурах бичгийн агуулга, арга зүй, үнэлгээ, дизайн, дасгал даалгаврыг зохиодог.

43 дугаар нүүр: 2.31.. Боловсролын хүрээлэнгээс хийсэн тус тайлан нь ЕБС-ийн I-XII ангид нэмэлтээр хэрэглэж буй гарын авлага, сургалтын материал, дасгал ажлын ном, бодлогын хураамжийн төрөл, тоог тодорхойлох судалгаа хийсэн. Судалгааны үр дүн, сургалтын нэмэлт материалын хэрэглээнд нөлөөлөх хүчин зүйлийг тооцоолж, судлаагүйгээр дүгнэснийг учир дутагдалтай гэж үзэж байна.

Тайлбар 10-г
үзнэ үү

... бага ангид 8-9, дунд ангид 5-6, ахлах ангид 9-10 тооны гэдгийг нарийвчлах боломж бий юу?... өөрөөр хэлбэл нэг сургалтын хэрэглэгдэхүүний хэмжээг дунджаар илэрхийлэх.

Тайлбар 11-г
үзнэ үү

44 дүгээр нүүр: Чанарын үнэлгээнд 9 дүгээр ангийн сурагчдыг 2019 оноос бүрэн хамруулж эхэлсэн.

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ГАЗАР

Тайлбар 12-г
үзнэ үү

Маш цөөн тооны сургуульд бүлэг дүүргэлт 66 байгааг хотын төвийн бүх сургууль ийм байгаа мэт бичиж болохгүй. Бүлэг дүүргэлтийн норм норматив нь 32-35 байхад 38 хүүхдийг 20 хувиар хэтэрсэн гэж үзэж болохооргүй байна. 7 хувиар л хэтэрсэн байна.

Багшийн хөгжлийн хуулийн дагуу санхүүжилтийг жил бүрийн улсын төсвийн төлөвлөлтөд санал хүргүүлдэг боловч сангийн яам, УИХ-аар төсөв нэмэгдэж батлагддаггүй хасагддаг. Энэ асуудлыг аудитын зөвлөмжөөр заавал оруулж 2022 оноос төсөвт мөнгө батлуулдаг болмоор байна.

Төсвийн тухай хуулийн дагуу Ерөнхий боловсролын төсөв нь Тусгай зориулалтын шилжүүлгээр Орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн болж батлагдан урсгал төсвийн гүйцэтгэлд тавих хяналт БШУЯ-аас хамааралгүй болсон нь үүнд нөлөөлж байна. Төсвийн гүйцэтгэлийн аймгийн төсвийн гүйцэтгэлд нэгтгэн сангийн яаманд шууд тайлагнадагтай холбоотойгоор зөрчил дутагдал нь БШУЯ-нд мэдэгдэхгүй өнгөрөөд байна.

Ерөнхий боловсролын статистик мэдээний тоонд үндэслэн төсвийг төлөвлөн орон нутагт хуваарилж байгаа бөгөөд хяналтыг орон нутгийн Засаг дарга, Мэргэжлийн хяналт, Аудитын байгууллага, Боловсрол, соёл урлагийн газар хамтран тавьж, гарсан зөрчил дутагдлын талаарх мэдээллийг БШУЯ-нд ирүүлэн хамтран ажиллах шаардлагатай байна.

Төсвийн тухай хуулиар орон нутаг хяналт тавьж зөрчил дутагдлыг Яаманд ирүүлдэггүйтэй холбоотой жил бүр давтагдаад байгааг шийдвэрлэх талаар холбогдох хуульд өөрчлөлт оруулах, Засаг дарга нартай хариуцлагын гэрээ байгуулах гэх мэтээр аудитын зөвлөмжид тодорхой тусгуулах хүсэлтэй байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

Тайлбар 13-а үзнэ үү

2017 он: -Салбарт хэрэгжиж буй гадаадын зээл, тусламжийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх,

-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж байгаа гадаад зээл, тусламжийн төслүүдийн 2018 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн. 2018 онд салбарт нийтдээ гадаадын зээл тусламжаар 14 төсөл хэрэгжсэн.

- Боловсролын байгууллагын сургалтын орчны аюулгүй байдал, дотуур байранд суралцагчид эрсдэлд өртөж болзошгүй хүчин зүйлийн судалгаа хийх, хяналт-шинжилгээ хийж дүгнэлт санал, зөвлөмж гаргах,

2018 оны 06 сард БСШУСЯ-ны төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ням-Очирын баталсан удирдамжийн дагуу нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчны аюулгүй байдал хангагдсан эсэхэд дүгнэлт гаргах, эрсдэлийг арилгах, арга хэмжээ авах зорилготойгоор нийслэлийн төрийн өмчийн 60 сургуулийн үйл ажиллагаатай ажлын хэсэг танилцаж, ажиллаж, холбогдох тайлан дүгнэлт, зөвлөмжийг гаргасан. Тус удирдамжийн дагуу 6 ажлын хэсэг байгуулагдсан ба үүний 3 ажлын хэсгийг нь Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, мэргэжилтэн ахалж ажилласан.

Тайлбар 14-а үзнэ үү

2018 он: - Сурах бичиг зохих, хэвлэх, түгээх журмын хэрэгжилтэд болон бага ангийн сурах бичиг болон бага ангийн сурах бичиг болон сурах бичгээс гадна ашиглаж байгаа номын агуулга, арга зүйд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх,

-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 10 сарын 16-ны өдрийн А/645 дугаартай "ажлын хэсэг байгуулах тухай" тушаал батлагдсан. Ажлын хэсэг тус тушаалын хавсралтаар батлагдсан удирдамжийн хүрээнд ажиллах төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу томоохон номын дэлгүүр, хэвлэх үйлдвэрүүд, номын жижиглэн худалдааны цэгүүдээр явж холбогдох судалгаа, шинжилгээг хийж ажилласан.

- Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гаргах,

Боловсрол, шинжлэх ухааны яамны ХШҮДАГ-ын жилийн төлөвлөгөөнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг харьяа байгууллагуудад хийхээр тусгагдаж жилд ойролцоогоор 10-15 байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийгддэг. Тухайн байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх удирдамж батлагддаг бөгөөд удирдамжид заасны дагуу хяналт-шинжилгээ, дотоод аудитын тайлан нэгтгэж гаргадаг. Боловсролын байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа асуудлыг тайланд тусгаж ажилладаг болно. 2018 оны тайланг ҮАГ-т хүргүүлсэн байгаа.

2018 онд Ерөнхий боловсролын сургуулиудаас: Нийслэлийн 116 дугаар сургууль, Архангай аймгийн Эрдэнэбулган сумын "хүмүүн" 1-р сургууль, Завхан

Тайлбар 15-г
үзнэ үү

аймгийн Тосонцэнгэл сумын 1-р сургууль, Монгол оросын хамтарсан 3-р сургууль, Нийслэлийн 2-р сургууль, Говьсүмбэр аймгийн 5-р сургууль зэрэг байна.

Их, дээд сургуулиудад 2018, 2019, 2020 онуудад тусгай зөвшөөрлийн шаардлага хангаж байгаа эсэх асуудлаар ажлын хэсэг байгуулагдаж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж холбогдох тайлан, дүгнэлт, зөвлөмжүүд гарсан. Уг дүгнэлт зөвлөмжид үндэслэн их, дээд сургуулийн тусгай зөвшөөрлийг цуцлах, зарим хөтөлбөрийг хаах зэрэг арга хэмжээнүүд шат дараатай авагдаж байгаа болно.

Үүнтэй холбогдох тайлан мэдээллийг ЯАГ-ын ажлын хэсэгт танилцуулсан.

2019 он: - Эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллага болон орон нутгийн боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийнэ.

Харьяа байгууллагад дотоод аудит хийхдээ сайдын баталсан тушаал, удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хамт хийж нэгдсэн тайлан зөвлөмж гаргадаг болно. 2019 онд харьяа байгууллагуудад хийгдсэн дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг өмнө хүргүүлсэн байгаа болно.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/400 тоот тушаалаар төв, хангай, баруун, зүүн болон говийн 5 бүсэд ажиллах дэд ажлын хэсгүүд байгуулагдсан. Тус ажлын хэсэг нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын бодлого шийдвэрийн хэрэгжилтийг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, Биеийн тамир, спортын газрууд болон салбарын байгууллага болох сургууль, цэцэрлэг, дотуур байр, музей, театр, спорт хороо зэрэг орон нутгийн байгууллагуудын ажилтай газар дээр нь танилцах, салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд үнэлгээ дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах зорилготой юм.

Дорнод, Хэнтий аймагт 2018 оны 9 дүгээр сард ажиллаж холбогдох тайлан, дүгнэлт гарсан. Мөн Монгол Улсын Их хурлын даргын ажлын хэсэгт Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын дэд сайдаар ахлуулсан бүрэлдэхүүн 2019 оны 02 сарын 24-28 өдрүүдэд Баянхонгор, Өвөрхангай зэрэг аймгуудад ажиллаж, орон нутгийн боловсролын байгууллагын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж, тайлан дүгнэлт гарсан байна. БСШУС-ын сайдын 2019.05.24-ний өдрийн А/330 дугаар тушаалаар Нийслэлийн ЕБС-ын 28 дугаар сургуульд хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын ажлыг Сайдын баталсан удирдамжийн дагуу хамтатган хэрэгжүүлж ажиллан, тайланг Дотоод аудитын Хорооны хурлаар хэлэлцүүлж ажилласан байна. Тайланг ЯАГ-т танилцуулсан.

- Дотуур байрны хүртээмжийн байдалд хяналт-шинжилгээ хийх

ХШҮДАГ нь газрын 2019 оны төлөвлөгөөний дагуу Дотуур байрны орчин, үйлчилгээний нөхцөл байдлын мэдээлэлд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж боловсруулж ажилласан. Нэгдсэн тайланг 2019 оны 10 сарын 31-нд гаргаж удирдлагад танилцуулж ажилласан. Үндэсний аудитын ажлын хэсэгт файлаар болон цаасаар танилцуулсан.

“Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрын нөхцөлийг сайжруулах төсөл”-ийн 3 зорилтын хүрээнд нийт 12 үйл ажиллагааг хэрэгжүүлсэн бөгөөд тус ажилд ХШҮДАГ-с хяналт тавьж, амжилттай хэрэгжүүлсэн.

- Тусгай зөвшөөрөл олголтын байдалд хяналт-шинжилгээ хийх

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит хийхээс гадна их дээд сургуулиудад 2018, 2019, 2020 онуудад тусгай зөвшөөрлийн шаардлага хангаж байгаа эсэх асуудлаар ажлын хэсэг байгуулагдаж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж холбогдох тайлан, дүгнэлт, зөвлөмжүүд гарсан.

БШУЯ нь Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого хэрэгжиж эхэлснээс хойш 4 жилийн хугацаанд 1 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ЗГХЭГ-т 2019 онд хүргүүлсэн нь уг бодлогын баримт бичгийн 7.5, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 -д заасантай нийцэхгүй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын 2018 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ЗГХЭГ-т хүргүүлж ажилласан.

“Боловсрол” үндэсний хөтөлбөрийн 2-р үе шатны хэрэгжилтийн тайланд 2020 оны 03 сарын 12-нд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. Эдгээр баримт, мэдээллийг УАГ-ын ажлын хэсэгт танилцуулсан.

2020 оны 07 сарын 1-нд хүчингүй болсон “хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-ийн заалтыг дурдсан нь зохимжгүй байна.

Тодруулга:

2.12. Аудитын хүрээнд цахимаар авсан санал асуулгад оролцсон 5758 багш, ажилтны 38.0 хувь нь сургалтын хөтөлбөр, сурах бичиг агуулгын хувьд зөрүүтэй байдлыг тулгамдаж буй хүндрэл бэрхшээл гэж хариулсан байна.

2.30. Аудитын хүрээнд цахимаар авсан санал асуулгад хариулсан 6096 багш, ажилтны 48.6 хувь нь сурах сурах бичгийн агуулга, сургалтын хөтөлбөртэй уялдаж буй байдал хангалтгүй гэж хариулжээ.

Дээрх 2.12, 2.30-тай дараах асуултад тодруулга өгнө үү.

1. Дээрх санал асуулгад оролцогчдын тоо, үр дүнгийн тоон үзүүлэлтийн хувь зөрүүтэй байна. Алийг нь зөв гэж үзэх вэ?

2. Санал асуулгад 1-12 дугаар ангид хичээл заадаг хичээл/судлагдахуун бүрийн багш нарын төлөөлөл бүрэн хамрагдсан уу.

3. Сургалтын хөтөлбөрийн агуулга/ суралцахуйн зорилтын хэдэн хувийг сурах бичгийн агуулга хангахгүй байгааг санал асуулгын үр дүнгээр тодорхойлсон уу.

4. Сургалтын хөтөлбөрийн агуулга/суралцахуйн зорилтуудад сурах бичгийн агуулга нийцэхгүй байгааг илрүүлэх шаардлага, шалгуур, үзүүлэлтийг боловсруулсан санал асуулгын хуудсанд тусгасан уу.

5. Хэддүгээр ангийн хэдэн онд хэвлэгдсэн, ямар сурах бичиг нь сургалтын хөтөлбөртэйгөө нийцэхгүй байгааг асуулгын үр дүнгээр тодорхойлсон уу.

Тайлбар 16-а
үзнэ үү

Тайлбар 17-а
үзнэ үү

Тайлбар 18-г
үзнэ үү

45 дугаар нүүр: 2.35-дугаар заалт: Боловсролын чанарын үнэлгээний түүвэр хийх аргачлал нь санамсаргүй түүврийн арга биш тодорхой нөхцөлт түүврийн арга бөгөөд судалгаа авч буй зорилго, тухайн жилийн судалгаанаас хүлээгдэж буй үр дүнгээс хамааран түүвэрт сонгогдох сургуулиудад тодорхой шаардлага, нөхцөл тавьж түүвэр хийдэг. Түүвэрт хамрагдах сургуулийн тоо нь төсвийн хүрээнд хязгаартай тогтоогддог бөгөөд лаборатори сургуулиудыг зайлшгүй хамруулах, тухайн сонгогдсон сургууль 5, 9, 12 дугаар ангитай байх, нэг сургуулийг 3-аас доошгүй удаа түүвэрт хамруулсан байх, сонгогдсон сургуулийн сурагчдын тоо 20-оос багагүй байх, газарзүйн байршил, зэрэг нөхцөлт түүврээр сургуулиуд сонгогддог. Аймгийн төсөөс алслагдсан сум, багийн төвийн сургуулиуд нь хэт цөөн хүүхэдтэй, зардал мөнгөний тооцооны хэтрэл зэрэг шалтгаанаас хамаарч хамруулдаггүй болно. Харин Улаанбаатар хотын хувьд түүврийг хийхдээ хотын төв, хотын захын сургуулиудаас бодлогын түвшинд сонгож хамруулдаг болно. 2019 оноос эхэлж авсан 9 дүгээр ангийн чанарын үнэлгээнд бүх сургууль, бүх сурагчид хамрагддаг болсон.

Мөн тус судалгааны зорилго нь ерөнхий боловсролын үндсэн хөтөлбөрийн хэрэгжилтийг тодорхой агуулгын хүрээнд /БХ-тэй хамтарч бюпринт гаргадаг/ үнэлэх зорилготой учраас олон улсын хөтөлбөртэй, тусгай болон дүйцүүлэх хөтөлбөрөөр хичээллэдэг сургуулиудыг бодлогын түвшинд хамруулдаггүй.

---ooOoo---

Саналд өгсөн тайлбар:

БШУЯ-аас ирүүлсэн 18 санал, тодруулга авах хүсэлт ирүүлснийг аудитын баг нягтлан үзэж, 8 саналтай холбоотой зохих найруулгын өөрчлөлт оруулсан бөгөөд 10 саналыг хүлээн авах боломжгүй тул дараах тайлбарыг өгч байна.

Саналд өгөх тайлбар	
YAГ-ын тайлбар 1	Холбогдох нотлох баримтаар дэмжигдэхгүй байгаа тул саналыг хүлээн аваагүй болно.
YAГ-ын тайлбар 2	Саналыг хүлээн авч тайланд дараах байдлаар найруулгын өөрчлөлт оруулав. Боловсролын сайдын 2018 оны А/608 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэг, сургуулийн орчинд гар утас, цахим хэрэгсэл болон сүлжээг зохистой хэрэглэх журам”-ын 3.8-д танхимын сургалтын үед багш нар суралцагчдад нийгмийн сүлжээг ашиглан даалгавар, бие даалт өгөхийг хориглох”-оор зохицуулсан байна. Covid-19 цар тахлын дэгдэлтийн үед зохион байгуулж буй онлайн болон теле хичээлийн үйл ажиллагаанд багш нар https://classroom.google.com, https://meet.google.com платформ ашиглаж сурагчдад хичээл заах, даалгавар өгөх, шалгах, мөн нийгмийн сүлжээгээр өдөр тутамдаа мэдээлэл солилцож буй боловч тодорхой эрх зүйн зохицуулалтгүй байна.
YAГ-ын тайлбар 3	Саналыг хүлээн авч тайланд дараах байдлаар найруулгын өөрчлөлт оруулав. 1.23 Ерөнхий боловсролд 2017-2020 оны хичээлийн жилд өдрөөр 572,752-640,449 хүүхэд хамрагдсан бөгөөд хамран сургалтын цэвэр жин дунджаар 93.3 хувь байгаа нь бусад доогуур орлоготой улс оронтой харьцуулахад өндөр, өндөр орлоготой орнуудын түвшинд, суурь боловсролын хамран сургалтын хувь 2019 онд 96.6 хувьтай байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас үзнэ үү /.
YAГ-ын тайлбар 4	Саналыг нягталж, тайланд дараах байдлаар нэмэлт мэдээлэл оруулав. 1.25 БШУЯ-наас суурь боловсролд хамрагдаагүй хүүхдийг бүртгэх, суралцаагүй шалтгааныг судлах ажил иж бүрэн хийгдээгүй байна. Суурь боловсролд 2019 онд 6-14 насны нийт 19,303 хүүхэд хамрагдаагүй байхад БШУЯ-ны статистик мэдээнд нийт хамрагдаагүй хүүхдийн 4.3 хувь буюу 838 хүүхдийг хамруулж, суралцаагүй шалтгааныг тогтоосон байна.
YAГ-ын тайлбар 5	Саналыг хүлээн авч тайланд дараах байдлаар найруулгын өөрчлөлт оруулав. 1.33 Гэвч 1 дүгээр ангийн бүлэг дүүргэлтийг авч үзэхэд хотын төвийн буюу орон сууцны хорооллын сургуульд хамгийн ихдээ 66 хүүхэд буюу 2.8 дахин их, хотын захын буюу гэр хорооллын сургуульд 38 хүүхэд буюу 1.6 дахин хэтэрсэн байна.
YAГ-ын тайлбар 6	Холбогдох нотлох баримтаар дэмжигдэхгүй байгаа тул саналыг хүлээн аваагүй болно.
YAГ-ын тайлбар 7	Аудитын явцад бага, дунд боловсролын судалгаа, аргазүйн туршилт явагдаж дууссан талаар мэдээлэл ирүүлээгүй тул агуулгыг хэвээр үлдээв.
YAГ-ын тайлбар 8	Саналыг хүлээн авч тайланд дараах байдлаар найруулгын өөрчлөлт оруулав. 2.27 БШУЯ нь Засгийн газрын 2009 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 28 дугаар тэмдэглэлийг үндэслэн сурах бичгийг бага ангид 80-100 хувь, дунд, ахлах ангид 40 хүртэл хувийг төрөөс хангах ажлыг зохион байгуулж, улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлж ирсэн бөгөөд сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг сурах бичиг, багшийн номын эх зохиох ажилтай зэрэгцүүлж төлөвлөж, хэрэгжүүлснээс тухайн жилд зохиогдсон сурах бичиг хугацаандаа нийлүүлэгдэхгүй байхад хүргэсэн байна.
YAГ-ын тайлбар 9	Боловсрол тухай хуулийн “боловсролын стандарт” хэсэгт орсон нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан найруулгын өөрчлөлт оруулав. БШУЯ-аас ирүүлсэн

	<i>тайлбар нь MNS 5418: 2008 стандартад хэвлэмэл сурах бичигт тавих ерөнхий шаардлагын 4.2-т “Боловсролын стандарт, кррикулим болон эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна” гэж тусгасантай нийцэхгүй байна.</i>
YAГ-ын тайлбар 10	<i>Тайланд Боловсролын хүрээлэнгээс хийсэн судалгааны дүнг дурдаж буй тул уг саналыг хүлээн аваагүй болно.</i>
YAГ-ын тайлбар 11	<i>Саналыг хүлээн авч тайланд дараах байдлаар оруулав. 2.34 БУТ бага, суурь, бүрэн дунд боловсролын чанарыг үнэлэх зорилгоор 5, 9, 12 /эсвэл 3, 9, 10/ дугаар ангийн сурагчдаас авсан боловсролын чанарын үнэлгээний судалгаанд 2.42-11.51 хувийг хамруулсан нь “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын 6.3.”Чанарын үнэлгээнд өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчийн 10-аас доошгүй хувийг хамруулна” гэсэн заалттай нийцэхгүй байна. /2019 онд IX ангийн суралцагчдыг бүрэн хамруулсан байна/</i>
YAГ-ын тайлбар 12	<i>Багшийн хөгжлийн хуулийн дагуу санхүүжилтийг тусгахтай холбоотой саналыг хүлээн авч аудитын Сангийн сайдад өгсөн зөвлөмжид дараах байдлаар оруулсан бөгөөд төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулахтай холбоотой агуулга тусгагдсан байгаа болно. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас ирүүлсэн төсвийн саналыг нэгтгэн боловсруулахдаа Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, урсгал зардлыг нэг суралцагчид ногдох хувьсах зардалд үндэслэн төлөвлөж, хуваарилах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төрөөс баримтлах хөтөлбөр, боловсролын салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдсан, тэргүүлэх ач холбогдол бүхий хуулийн шаардлага хангасан байдлаар төлөвлөж, санхүүжүүлэх;</i>
YAГ-ын тайлбар 13	<i>Тус газрын 2017 оны төлөвлөгөөнд тусгагдсан хяналт-шалгалт тухайн онд хийгдээгүй байх тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.</i>
YAГ-ын тайлбар 14	<i>Тус газраас бага ангийн сурах бичиг болон сурах бичгээс гадна ашиглаж байгаа номын агуулга, арга зүй болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагуудын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.</i>
YAГ-ын тайлбар 15	<i>Ирүүлсэн тайлбар нь холбогдох нотлох баримтаар дэмжигдэхгүй байх тул тайланд өөрчлөлт оруулаагүй болно.</i>
YAГ-ын тайлбар 16	<i>Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын баримт бичгийн 7.5, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 10 дугаар зүйлийн 10.7 -д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хууль аудитын хамарсан хугацаанд буюу 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан тул саналыг хүлээн аваагүй болно.</i>
YAГ-ын тайлбар 17	<i>Аудитын явцад авсан санал асуулгын “Сургалтын цөм /сайжруулсан/ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй хүндрэл бэрхшээл”, “Сурах бичгийн агуулга сургалтын хөтөлбөртэй бүрэн уялдаж чаддаг эсэх” асуултад багш нарын хариулсан байдлыг тайланд тусгасан тул өөрчлөлт оруулаагүй болно.</i>
YAГ-ын тайлбар 18	<i>Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. “Боловсролын үндсэн зарчим” 5.1.6 “Өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр боловсролын байгууллагад адил тэгш хандана”, 17 дугаар зүйлийн 17.1 “Боловсролын үнэлгээний байгууллага бүх шатны боловсролын чанарт үнэлгээ, судалгаа хийх, дээд боловсролын хөтөлбөрт элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтыг үндэсний түвшинд хариуцан зохион байгуулах чиг үүрэг бүхий хуулийн этгээд мөн”, “Боловсролын үнэлгээний төв”-ийн дүрмийн 2.1.2 “Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын чанарт хяналт шинжилгээ, үнэлгээ, судалгаа хийж санал, дүгнэлт гаргах” заалтуудтай нийцэхгүй байх тул саналыг хүлээн аваагүй болно.</i>

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Боловсролын хууль тогтоомж сургалтын үйл ажиллагааг цогц байдлаар зохицуулаагүй, холбогдох хуулиуд шинэчлэн батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон, ерөнхий боловсролын салбар 12 жилийн сургалтад шилжсэн, Цөм хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн зэргээс эрх зүйн орчин өнөөгийн шаардлагад бүрэн нийцээгүй, харилцан уялдаагүй байна;
- Салбарын хөрөнгө оруулалтыг бодит хэрэгцээ шаардлага, судалгаа тооцоололд үндэслэж оновчтой төлөвлөөгүй, барилгын норм ба дүрэмд шинээр барих орон сууцны хороолол, хотхоныг сургуулийн барилгын хамт төлөвлөж барих зохицуулалтгүй, суралцагчийн сурах хэрэгцээнд дэмжлэг үзүүлэхүйц материаллаг орчин бүрэн бүрдээгүй;
- Аймаг, сум, багт бүрэн дунд сургууль нэмж байгуулж ирснээс сургуулийн ангилал, байршилд зохистой бус өөрчлөлт гарч, бүлэг дүүргэлт байршлаас шалтгаалан эрс ялгаатай байхад хүргэж багшийн ачаалал, хүрэлцээ, сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байна;
- Засгийн газар нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 2016 оноос хойш шинэчлээгүйгээс төсвийн төлөвлөлт, хуваарилалт бодитой бус, салбарын яамны зүгээс тусгай зориулалтын шилжүүлгийн гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлдэггүй, санхүүжилтийн үр ашгийг сурагчдын гүйцэтгэл, сургалтын чанартай уялдуулан тооцож, дүгнэх тогтолцоо бүрдээгүй байна;
- Салбарын багш, ажилтны ажлын байрны эрэлт хэрэгцээг хүн амын өсөлттэй уялдуулан тухай бүр тодорхойлоогүй, БМДИ, БСУГ, багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй байна;
- Салбарын яам сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг суурь судалгаа, шаардагдах хөрөнгө, хүний нөөц, цаг хугацааг тодорхойлсон аргачлалгүйгээр багшийн хөгжил, сургалтын чанарын үнэлгээтэй бүрэн уялдуулаагүй хэрэгжүүлж ирсэн байна;
- Сургалтын чанар хангалтгүй⁷², сургуулийн өөрийн болон хөндлөнгийн чанарын үнэлгээний дүн хоорондын зөрүү өндөр байна;
- Үнэлгээний байгууллага болон орон нутгийн боловсролын газар, сургуулиудын дунд мэдээлэл солилцох, эргэх холбоо хангалтгүйгээс салбар, орон нутаг, сургуулийн хэмжээнд сургалтын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг үнэлж, сайжруулах арга хэмжээ авах нөхцөл бүрдээгүй байна;
- Салбарын яамны зүгээс төрийн өмчийн бус сургуулиудын сургалтын төлбөрийн орлогын зарцуулалт, зардлын бүрэлдэхүүн, тэдгээрийн зохистой харьцаа, эзний өмчийг хэрхэн нэмэгдүүлж буй байдалд дүн шинжилгээ хийгээгүй, суралцагчийн хувьд төлж буй төлбөрөөс хүртэх өгөөжийг тодорхойлж, тооцох боломжгүй байна;
- Салбарын яамны болон хөндлөнгийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ үр нөлөө багатайгаас сургалтын орчинтой холбоотой зөрчлүүд буураагүй, олон улсын хөтөлбөртэй улсын төсвийн сургууль болон лаборатори сургуулийг анх байгуулсан зорилго, зорилт биелж буй эсэхэд тавих шалгуур үзүүлэлт тодорхойгүй байна.

⁷² “Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйл” судалгааны тайлан: Сурагчдын мэдлэг, ойлголт бага ангид 56.0 хувь, дунд ангид 46.0 хувь, ахлах ангид 37.0 хувь, Сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадвар хангалтгүй, бага ангид 37.5 хувьтай, дунд ангид 43.0 хувьтай, ахлах ангид 36.0 хувь, Дунд ангийн сурагчдын мэдээлэлтэй ажиллах, асуудлыг шийдвэрлэх, бүтээлч чадвар, сурах арга барилын эзэмшилт, сэтгэхүйн задлан шинжлэх, харьцуулах, нэгтгэн дүгнэх, таамаглал дэвшүүлэх чадвар сул, ахлах ангийн сурагчдын мэдээлэлтэй ажиллан асуудал шийдвэрлэх, бие даан бүтээлч үйл гүйцэтгэх чадвар сул, Шинжлэх ухаанч арга барил эзэмшсэн байдал дунд ангид 28.0 хувь харин ахлах ангид 32.0 хувь байна,

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Монгол Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

- Боловсролын салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомжууд өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй, харилцан уялдаагүй, шинэчлэн батлах шаардлагатай байгаад анхаарал хандуулна уу;

Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт:

- “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”, “Боловсрол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд холбогдох хуульд заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж, хэрэгжилтийг хангуулах;

Сангийн сайдад:

- Боловсрол, шинжлэх ухааны яамнаас ирүүлсэн төсвийн саналыг нэгтгэн боловсруулахдаа Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, урсгал зардлыг нэг суралцагчид ногдох хувьсах зардалд үндэслэн төлөвлөж, хуваарилах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төрөөс баримтлах хөтөлбөр, боловсролын салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдсан, тэргүүлэх ач холбогдол бүхий хуулийн шаардлага хангасан байдлаар төлөвлөж, санхүүжүүлэх;

Боловсрол, шинжлэх ухааны сайдад:

- Боловсролын салбарт мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм журам, норм нормативыг тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, хэрэгцээ шаардлага, цаашдын чиг хандлагад нийцүүлэн цогц байдлаар шинэчлэх замаар уялдаа холбоог хангах;
- Салбарын яам холбогдох байгууллагатай хамтран төрийн өмчийн бус сургуулиудын хариуцлагын хэлбэрийг тодорхой болгох арга хэмжээ авах;
- Төрийн өмчийн бус сургуулиудын хувьд сургалтын төлбөрийн эх үүсвэрээс санхүүжүүлэх зардлын бүрэлдэхүүн, тэдгээрийн зохистой харьцааг тогтоох, суралцагч төлж буй төлбөрөөс хүртэх өгөөжийг тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Боловсролын салбарт хийх төсвийн хөрөнгө оруулалтыг салбарын дунд хугацааны хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөгөөтэй уялдуулж, бодит хэрэгцээ шаардлага, судалгаа тооцоололд үндэслэн төлөвлөх замаар суралцагчийн сурах хэрэгцээнд дэмжлэг үзүүлэхүйц тэгш, хүртээмжтэй материаллаг орчин бүрэн бүрдүүлэх
- Хүний нөөцийн нэгдсэн бодлого төлөвлөгөөг хүн амын өсөлттэй уялдуулан боловсруулж, багш бэлтгэдэг их, дээд сургуулиудтай үйл ажиллагаагаа уялдуулж хэрэгжүүлэх, багшийн хөгжлийн төв бодит эрэлт, хэрэгцээнд тулгуурласан, хөгжлийн чиг хандлагад нийцсэн байдлаар үйл ажиллагаа явуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг инфляц, үнийн өсөлт, сургуулийн онцлог, хүчин чадал, байршил, төлбөрийн хэмжээтэй уялдуулан тооцож жил бүр шинэчлэн сайжруулах санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

- Салбарын яам, орон нутгийн удирдлагын зүгээс батлагдсан төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэхтэй холбоотой дотоод хяналтыг сайжруулах;
- Сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлалыг мөрдөх замаар хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангаж, улс, орон нутаг, сургуулийн хэмжээнд сургалтын чанарын үнэлгээ болон улсын шалгалтын дүнд дүн шинжилгээ хийх,
- Боловсролын чанарын үнэлгээнд бүх шатны боловсрол сургалтын байгууллагыг хэвшил, хэв шинж, байршил харгалзахгүй, журамд заасан хувь хэмжээгээр бүрэн хамруулан мэдлэг, ур чадвар, бүтээлч сэтгэхүй зэргийг бодитой үнэлж дүгнэх.
- Сургалтын чанарын үнэлгээний дүнгийн мэдээлэл солилцох орчин бий болгох замаар сургалтын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг бодитой үнэлж дүгнэх, нөлөөллийг бууруулах арга зүйн зөвлөмж боловсруулж мөрдүүлж ажиллах;
- Одоо мөрдөгдөж буй “Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам”-ыг өнөөгийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчлэх замаар сурах бичгийн чанар, хүртээмжийг сайжруулах;
- Олон улсын хөтөлбөртэй төрийн өмчит сургууль, лаборатори сургуулийн үйл ажиллагаа тухайн сургуулийг байгуулсан зорилго, зорилттой нийцсэн, үр дүнтэй байгаа эсэхийг үнэлж дүгнэх;
- Салбарын яам болон аймаг, нийслэлийн боловсролын газрын зүгээс ерөнхий боловсролын сургуулиуд тусгай зөвшөөрөлд заасан шаардлагад нийцсэн, яамнаас баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт шалгалт хийж, арга хэмжээ авах;

Барилга, хот байгуулалтын сайдад:

- Барилгын норм ба дүрэмд шинээр барих орон сууцны хотхон, хороололд сургуулийн барилгыг хамт төлөвлөх зохицуулалт тусгах;

Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд:

- Салбарын яамны боловсруулсан төлөвлөгөө, арга зүйг үндэслэн тухайн орон нутгийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх ойрын болон хэтийн төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангуулах, хамран сургалтын тэгш хүртээмжтэй орчин бий болгох;

Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

- Ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлгийн зарцуулалтын арвилан хэмнэлт, санхүүгийн сахилга бат, хариуцлагатай холбоотой дотоод аудитын хяналтыг сайжруулах;

ХАВСРАЛТУУД:**Хавсралт 1****Хүснэгт 28. Боловсролын тухай хууль бусад хуулиудын харилцан уялдаа**

Боловсролын тухай хуулийн заалт		Бусад холбогдох хуулийн нэр, заалт		
3.1.9	“хөгжлийн бэрхшээлтэй суралцагч” гэж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан иргэнийг	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль	4.1.1	“хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг;
20.1	Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.7.1, 15.7.2, 15.7.4, 15.7.8, 15.7.9, 16.2.4, 16.3.3-д заасны дагуу их сургууль, дээд сургууль, коллежид, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт аймаг, нийслэлийн боловсролын газрын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус олгоно.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль	15.7.9	Ийм заалт байхгүй.
			16.3.3	Хүчингүй болсон заалт
43.1.8	Ерөнхий боловсролын сургуулийн эмч, бага ангийн багшид Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 7.8-д заасан нэмэгдлийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамаарч сар бүр олгох	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль	7.8	Ийм заалт байхгүй.
43.4	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, бусад албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгох бөгөөд уг урамшууллын хэмжээ, түүнийг олгох журмыг Төрийн албаны тухай хуулийн 31.3-т заасны дагуу Засгийн газар батална	Төрийн албаны тухай хууль	51.2	Энэ хуулийн 51.1.1-д заасан шагнал олгох, 51.1.3-т заасан шагналд тодорхойлох болон 51.1.4-т заасан мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар, 51.1.2-т заасан шагналд нэр дэвшүүлэх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч тус тус батална
43.6	Энэ хуулийн 43.1.8-д заасан нэмэгдлийг Төрийн албаны тухай хуулийн 28.9-д заасны дагуу тогтооно.		57.8	Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлсний доод хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.
43.7	Энэ хуулийн 43.1.4, 43.5-д заасан нэг удаагийн тэтгэмж тооцох цалингийн дундаж хэмжээ, тэтгэмж олгох шалгуур нөхцөлийг Төрийн албаны тухай хуулийн 30.2-т заасан журмыг баримтлан тогтооно.		60.1	Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй байна. Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох цалингийн дундаж хэмжээ болон олгох шалгуур нөхцөлийг тодорхойлсон журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

Хавсралт 2

Хүснэгт 29 Холбогдох хуульд батлахаар заасан дүрэм, журам

Боловсролын тухай хууль
25 дугаар зүйлийн 25.6-д “Энэ хуулийн 25.2-т заасныг хэрэгжүүлэхтэй холбоотой дүгнэлт гаргах аргачлал, журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”; 28 дугаар зүйлийн 28.1.23-д “төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам батлах” 28 дугаар зүйлийн 28.1.25-д “төрийн өмчийн олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль болон ерөнхий боловсролын лаборатори сургуулийн тусгай арга хэмжээ, хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтыг хэрэгжүүлэх журам боловсруулж батлах;” гэж заасан хэдий ч Засгийн газрын 2012 оны “Лаборатори сургууль байгуулах, нэмэгдэл олгох тухай” 179 дүгээр тогтоолоор зөвхөн лаборатори сургуулийн нэмэгдлийг, салбарын сайдын тушаалаар сургалтын төлөвлөгөөг баталсан боловч төрийн өмчийн олон улсын хөтөлбөртэй сургууль, лаборатори сургууль ямар журам, тусгай арга хэмжээгээр судалгаа, арга зүйн туршилтыг зохион байгуулах нь тодорхойгүй байна; 28 дугаар зүйлийн 28.3-д “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоол, хүнсний эрүүл, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн стандарт, норм, нормативыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, эрх бүхий байгууллага батална” гэж заасан хэдий ч норм, норматив батлагдсан бөгөөд стандартын төсөл боловсруулах шатандаа байна ; 39 дүгээр зүйлийн 39.12 “Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, түүнийг зарцуулах, тайлагнах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална” гэж заасан боловч Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаал, 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг мөрдөж байна.
Бага дунд боловсролын тухай хууль
14 дүгээр зүйлийн 14.8 заасан “Төрөлжсөн болон олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн элсэлтийн журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” 19 дүгээр зүйлийн 19.5-д заасан “... багш нарын зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” 41 дүгээр зүйлийн 41.4-д “Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, ёс заншил, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлж болох бөгөөд дэмжлэг үзүүлэх нөхцөл, шаардлага, хэмжээг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна” 13 дугаар зүйлийн 13.2 “Ерөнхий боловсролын тусгай сургуулийн хамран сургах тойрог тогтоох, аймаг, нийслэл, сум, дүүрэгт салбар бүлэг ажиллуулах, элсэлтийг зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална”
Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
7 дугаар зүйлийн 7.5-д “Багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж заасан боловч үлгэрчилсэн дүрмийг батлаагүй; 8 дугаар зүйлийн 8.3-т “Багш мэргэжлээр дээд боловсрол олгох их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт 6 сарын хугацаатай дадлагажигч багшаар ажиллах агуулгыг багтаана. Дадлагажигч хөдөө орон нутагт ажиллавал тэтгэлэг олгож болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.” гэж заасан хэдий ч батлагдаагүй бөгөөд дадлагажигчид тэтгэлэг олгох харилцааг Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам” -аар зохицуулж байна. 14 дүгээр зүйлийн 14.1.1-д “багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг 5 жил тутам батлах” гэж заасан хэдий ч хөтөлбөрийг одоо боловсруулж байна;
Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
12 дугаар зүйлийн 12.2 “Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журмыг боловсролын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.”; 13 дугаар зүйлийн 13.2 “Брайль үсгийн стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын төв байгууллага батална”; 15 дугаар зүйлийн 15.2 “Бүх шатны сургалтын байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална”; 23 дугаар зүйлийн 23.4 “Энэ хуулийн 22.1-д заасан үйлчилгээг эрхлэх байгууллагад тавигдах шаардлагыг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран боловсруулж батална.”;
Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль
Тус хууль 2019 онд шинээр батлагдсантай холбоотойгоор тус хуулийн 10.1, 10.1.1, 10.1.3, 10.2.2, 10.2.3, 10.2.5, 10.2.6, 10.2.12, 10.3.1 дэх хэсэгт заасан сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний стандарт, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтын журам, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний дотоод хяналтын журам, хандив, тусламжийг хүлээн авах ажлыг зохион байгуулах зэрэг журам батлагдаагүй, боловсруулах, хэлэлцүүлэх, санал авах, хянуулах үе шатанд байна.

Хавсралт 3

Хүснэгт 30. Нийт хамран сургалтын хувь, бусад улс оронтой харьцуулалт /хувиар/

Улсын нэр	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Энэтхэг	90.7	91.0	90.4	91.6	92.3					
Киргиз	86.8	87.4	87.3	89.6	90.4	89.8	89.5	89.4	89.9	89.9
Мьянмар	88.9	89.0				96.1			97.7	97.9
Камбодж		93.6	97.5	97.4		95.0	95.3	92.8	90.5	90.3
Филлипин	89.9					95.4	95.1	94.4	93.8	
Вьетнам	98.6	98.0	99.3	98.1	98.0					
Украйн	87.9	90.4	92.4	93.2	93.4	91.7				
АНУ		93.4	92.4	92.8	92.8	93.2	93.9	95.1	94.6	
ОХУ	94.1		95.4	96.3	96.2	94.4	95.7	96.7	95.1	
Өмнөд Солонгос	99.5	98.4	98.9	97.8	95.4	95.8	98.0	96.9	97.3	
Монгол	95.5	97.3	97.8	97.2	94.6	94.6	96.0	97.8	97.9	97.7

Эх сурвалж: Дэлхийн банк

Хавсралт 4

Хүснэгт 31. Гадаадын хөрөнгө оруулалттай хувийн сургууль

№	Байршил	Сургуулийн нэр
1	Баян-Өлгий	Баян-Өлгий эмпати
2	Төв	Сейнт поул бага сургууль
3	Дархан-Уул	Дархан-Эмпати сургууль
4	Орхон	Орхон эмпати сургууль
5	Орхон	Эрдэнэт орос сургууль
6	Нийслэл-БГД	Хүрээ тулга сургууль
7	Нийслэл-БЗД	Кириллица бага сургууль
8	Нийслэл-БЗД	Монгол оросын русский лицей ерөнхий боловсролын сургууль
9	Нийслэл-БЗД	Нийслэлийн ерөнхий боловсролын Эм Ай Ю сургууль
10	Нийслэл-БЗД	Улаанбаатар эмпати сургууль
11	Нийслэл-БЗД	Г.В.Плехановын нэрэмжит сургууль
12	Нийслэл-БЗД	Улаанбаатар сургууль
13	Нийслэл-БЗД	Глобал иннова сургууль
14	Нийслэл-Налайх	Хос Уянга сургууль
15	Нийслэл-СХД	Гэрэлт ирээдүй глобал боловсрол
16	Нийслэл-СХД	Номын ёс бага сургууль
17	Нийслэл-СБД	Монгол Хятадын найрамдал сургууль
18	Нийслэл-СБД	Улаанбаатар элит олон улсын дунд сургууль
19	Нийслэл-ХУД	Оном сургууль
20	Нийслэл-ХУД	Улаанбаатар дах олон улсын сургууль
21	Солонгос улс	Солонгос дахь Монгол дунд сургууль

Эх сурвалж: БШУЯ

Хавсралт 5

Хүснэгт 32. Сургуулийн тусгай зөвшөөрлөөр олгосон суудлын ашиглалтын судалгаа, хүчин чадлаас давсан болон ашиглалтгүй байгаа суудлын тоо, аймгаар

Аймаг	2017 он		2018 он		2019 он	
	Илүү	Дутуу	Илүү	Дутуу	Илүү	Дутуу
Архангай	4,082	(2,431)	4,137	(2,566)	4,868	(2,296)
Баян-Өлгий	5,435	(932)	5,610	(1,025)	6,193	(979)
Баянхонгор	5,224	(756)	5,230	(770)	5,912	(680)
Булган	1,303	(1,791)	1,010	(1,994)	1,520	(1,838)
Говь-Алтай	2,039	(2,398)	2,125	(2,451)	1,504	(2,482)
Говьсүмбэр	1,431	(217)	1,463	(203)	1,818	(207)
Дорноговь	1,947	(1,518)	2,230	(1,497)	3,134	(1,439)
Дорнод	3,352	(1,736)	3,641	(1,582)	4,555	(1,426)
Дундговь	812	(1,688)	814	(1,790)	1,016	(1,782)
Завхан	3,742	(1,210)	3,811	(1,409)	4,298	(1,263)
Өвөрхангай	6,846	(1,254)	6,993	(1,410)	7,142	(2,679)
Өмнөговь	3,263	(1,251)	3,639	(1,314)	4,198	(1,209)
Сүхбаатар	4,027	(509)	4,306	(471)	4,960	(396)
Сэлэнгэ	4,218	(1,917)	4,305	(1,887)	4,770	(1,481)
Төв	2,722	(2,217)	3,110	(2,184)	4,095	(1,888)
Увс	5,478	(630)	5,585	(623)	5,417	(465)
Ховд	3,266	(1,241)	3,387	(1,244)	4,019	(1,065)
Хөвсгөл	8,342	(721)	8,415	(832)	9,856	(630)
Хэнтий	2,172	(1,891)	1,975	(1,827)	2,504	(1,574)
Дархан-Уул	4,344	(2,443)	5,069	(2,916)	6,383	(2,524)
Орхон	6,029	(2,474)	6,015	(3,177)	7,307	(2,849)
Нийслэл	98,320	(26,702)	109,447	(24,421)	125,803	(21,993)
НИЙТ ДҮН	178,394	(57,927)	192,317	(57,593)	221,272	(53,145)

Эх сурвалж: БШУЯ

Хавсралт 6

Хүснэгт 33. ЕБС-ийн хичээлийн байрны тоон үзүүлэлт

Үзүүлэлт	2017 он	2018 он	2019 он
Хичээлийн байрны тоо:	1,186	1,178	1,238
Төрийн өмчийн	1,024	1,012	1,064
Хувийн өмчийн	162	166	174
Стандартын шаардлага хангасан байрны тоо:			
Төрийн өмчийн	827	865	927
Хувийн өмчийн	125	139	144
Стандартын шаардлага хангаагүй байрны тоо:			
Төрийн өмчийн	197	147	137
Хувийн өмчийн	37	27	30
Өөрийн байрны тоо:			
Төрийн өмчийн	1,014	1,000	1,046
Хувийн өмчийн	119	123	129
Түрээсийн байрны тоо:			
Төрийн өмчийн	10	12	18
Хувийн өмчийн	43	43	45
Мэргэжлийн хяналтын актласан дүгнэлттэй барилгын тоо:			
Төрийн өмчийн	31	33	51
Хувийн өмчийн	-	-	-

Эх сурвалж: БШУЯ

Хавсралт 7

Хүснэгт 34. 73-108 жилийн насжилттай барилгын жагсаалт

№	Аймаг	Сургууль	Ашиглалтад орсон огноо	Ашиглагдсан жил
1	Булган	Сайхан сумын ЕБС	1938, 1939, 1940	80, 81, 82
2	Дорнод	Хэрлэн сумын Хан-Уул цогцолбор сургууль	1939, 1940	80, 81
3	Дорнод	Халхгол сумын Ялалт багийн бага сургууль	1926	94
4	Ховд	Жаргалант сумын "Цаст алтай" цогцолбор сургууль	1929	91
5	Хөвсгөл	Жаргалант сумын ЕБС	1940	80
6	Хөвсгөл	Цагаан-Уул сумын ЕБС	1941	79
7	Хөвсгөл	Чандмань-Өндөр ЕБС	1940	80
8	Увс	Улаангом сумын 4 дүгээр сургууль	1947	73
9	Өвөрхангай	Гучин-Ус сумын сургууль	1940	80
10	УБ, СБД	1 дүгээр сургууль	1940	80
11	УБ, ЧД	112 дугаар сургууль	1912	108

Хавсралт 8

Хүснэгт 35. Анги дүүргэлт илүү болон хангалтгүй байгаа суудлын тоо /аймгаар/

№	Аймаг, сум	Сургууль	Батлагдсан хүчин чадал	Хамрагдсан хүүхэд	Тайлбар
Архангай аймаг					
1	Чулуут	Халуун ус багийн бага сургууль	120	16	1-5 дугаар ангийн 1 бүлэгт 2017 онд 3-8, 2018 онд 2-7, 2019 онд 1-5 хүүхэд суралцсан.
2	Өндөр-Улаан	Хануй багийн бага сургууль	80	25	1-5 дугаар ангийн 1 бүлэгт 2017 онд 5-11, 2018 онд 4-7, 2019 онд 3-7 хүүхэд суралцсан.
3	Эрдэнэбулган	Хоршоолол багийн бага сургууль	100	21	1-5 дугаар ангийн 1 бүлэгт 2017 онд 2-6, 2018 онд 1-5, 2019 онд 3-9 хүүхэд хамрагдсан. 2019 онд 4 дүгээр ангийн бүлэгт хүүхэд хамрагдаагүй
Баян-Өлгий аймаг					
4	Алтай	2 дугаар сургууль	80	41	1-5 дугаар ангийн 1 бүлэгт 2017 онд 2-17, 2018 онд 1-5, 2019 онд 1-23 хүүхэд хамрагдсан.
5	Баяннуур	3 дугаар сургууль	60	36	1-5 дугаар ангийн 1 бүлэгт 2017 онд 5-10, 2018 онд 5-9, 2019 онд 3-14 хүүхэд хамрагдсан.
6	Дэлүүн	3 дугаар сургууль	75	41	1-5 дугаар ангийн 1 бүлэгт 2017 онд 5-15, 2018 онд 5-13, 2019 онд 4-11 хүүхэд хамрагдсан. 2019 онд 5 дугаар ангийн бүлэгт хүүхэд хамрагдаагүй.
7	Дэлүүн	2 дугаар сургууль	60	49	1-5 дугаар ангийн 1 бүлэгт 2017 онд 5-21, 2018 онд 7-12, 2019 онд 7-17 хүүхэд хамрагдсан.
8	Сагсай	2 дугаар сургууль	60	48	1-5 дугаар ангийн 1 бүлэгт 2017 онд 7-11, 2018 онд 6-11, 2019 онд 7-15 хүүхэд хамрагдсан.
9	Ногооннуур	3 дугаар сургууль	85	49	1-5 дугаар ангийн 1 бүлэгт 2017 онд 6-13, 2018 онд 4-10, 2019 онд 6-13 хүүхэд хамрагдсан.
Баянхонгор аймаг					
10	Баянбүрд	Баянбүрд багийн бага сургууль	50	17	1-5 дугаар ангийн 1 бүлэгт 2017-2019 онд 2-7 хүүхэд хамрагдсан. 2018 онд 2-р ангид, 2019 онд 3-р ангид хүүхэд хамрагдаагүй
11	Мандал	Мандал бага сургууль	50	17	1-5 дугаар ангийн 1 бүлэгт 2017-2019 онд 1-7 хүүхэд хамрагдсан. 2017 онд 3-р ангид хүүхэд хамрагдаагүй.
12	Гашуундэл	Гашуундэл бага сургууль	50	11	1-5 дугаар ангийн 1 бүлэгт 2017-2019 онд 1-5 хүүхэд хамрагдсан.
Булган аймаг					
13	Хутаг-Өндөр	Уньт багийн бага сургууль	100	66	1-5 дугаар ангийн 1 бүлэгт 2017-2019 онд 7-18 хүүхэд суралцсан.
14	Хутаг-Өндөр	Хантай багийн бага сургууль	100	35	1-5 дугаар ангийн 1 бүлэгт 2017-2019 онд 3-9 хүүхэд суралцсан.
15	Булган	Спортын ахлах сургууль	120	56	6-9 дүгээр ангийн 1 бүлэгт 2017 онд 3-11, 2018 онд 3-9, 2019 онд 4-11 хүүхэд хамрагдсан.
Говь-Алтай аймаг					
16	Тонхил	Алтансоёмбо багийн бага сургууль	60	14	Алтансоёмбо багийн бага сургуулийн 2, 3-р ангид 2017 онд, 3, 4-р ангид 2018 онд, 4, 5-р ангид 2019 онд хүүхэд хамрагдаагүй
17	Халиун	Олонбулаг багийн бага сургууль	80	9	Олонбулаг багийн бага сургуулийн 5-р ангид 2018 онд, 1-р ангид 2019 онд, Тахийн тал бага сургуулийн 2, 5-р ангид 2017 онд, 3-р ангид 2018 онд, 1, 4-р ангид 2019 онд хүүхэд хамрагдаагүй.
18	Бугат	Тахийн тал багийн бага сургууль	72	12	1-5 дугаар ангийн 1 бүлэгт 2017-2019 онд 2-7 хүүхэд хамрагдсан.
19	Есөнбулаг	Анагаах Ухааны Сургуулийн Лицей ахлах сургууль	90	56	2017-2019 онд 10-12 дугаар ангийн 1 бүлэгт 7-28 хүүхэд хамрагдсан.
Говьсүмбэр аймаг					
20	Баянтал	4 дүгээр сургууль	350	143	Хүчин чадлын 60.0 хувь ашиглалтгүй
Дорноговь аймаг					
21	Сайншанд	4 дүгээр сургуульд	952	396	Хүчин чадлын 60.0 хувь ашиглалтгүй
22	Сайхандулаан	Сайхандулаан сумын сургууль	250	147	Хүчин чадлын 45.0 хувь ашиглалтгүй
23	Алтанширээ	ЕБС	320	139	Хүчин чадлын 54.0 хувь ашиглалтгүй
24	Хөвсгөл	ЕБС	400	232	Хүчин чадлын 41.0 хувь ашиглалтгүй

Дорнод аймаг					
25	Халхгол	ЕБС	640	373	Хүчин чадлын 41.0 хувь ашиглалтгүй
26	Халхгол	Ялалт багийн ЕБС	160	85	Хүчин чадлын 52.0 хувь ашиглалтгүй
27	Хөлөнбуйр	ЕБС	530	270	Хүчин чадлын 53.0 хувь ашиглалтгүй
28	Сэргэлэн	ЕБС	400	185	Хүчин чадлын 56.0 хувь ашиглалтгүй
Дундговь					
29	Говь-Угтаал	ЕБС	320	175	Хүчин чадлын 45.0 хувь ашиглалтгүй
30	Өлзийт	ЕБС	320	145	Хүчин чадлын 57.0 хувь ашиглалтгүй
	Завхан				
31	Завханмандал	Бага, дунд сургууль	320	163	Хүчин чадлын 49.0 хувь ашиглалтгүй
32	Цагаанхайрхан	Дунд сургууль	320	92	Хүчин чадлын 71.0 хувь ашиглалтгүй
33	Яруу	ЕБС	260		Хүчин чадлын 60.0 хувь ашиглалтгүй
Өвөрхангай аймаг					
34	Тарагт	Туяа багийн бага сургууль	80	18	1-5 дугаар ангийн 1 бүлэгт 2017-2019 онд 1-8 хүүхэд хамрагдсан
35	Тарагт	ЕБС	440	212	Хүчин чадлын 51.0 хувь ашиглалтгүй
36	Хайрхандулаан	ЕБС	640	410	Хүчин чадлын 35.0 хувь ашиглалтгүй
Өмнөговь аймаг					
37	Ноён	ЕБС	320	145	Хүчин чадлын 56.0 хувь ашиглалтгүй
38	Хүрмэн	ЕБС	320	122	Хүчин чадлын 63.0 хувь ашиглалтгүй
Сэлэнгэ аймаг					
39	Сүхбаатар	Спортын сургууль	240	100	2017-2019 онд 6-9 дүгээр ангийн 1 бүлэгт 1-15 хүүхэд хамрагдсан.
40	Сүхбаатар	3 дугаар сургууль	960	490	Хүчин чадлын 53.0 хувь ашиглалтгүй
41	Сүхбаатар	6 дугаар сургууль	770	480	Хүчин чадлын 51.0 хувь ашиглалтгүй
Төв аймаг					
42	Баян-Өнжүүл	Дунд сургууль	350	142	Хүчин чадлын 59.0 хувь ашиглалтгүй
43	Өндөрширээт	Ахлах сургуулийн	640	218	Хүчин чадлын 66.0 хувь ашиглалтгүй
44	Баянцагаан	Дунд сургууль	320	139	Хүчин чадлын 58.0 хувь ашиглалтгүй
45	Сэргэлэн	ЕБС	320	96	2019 онд 1-9 дүгээр ангийн 1 бүлэгт 3-18 хүүхэд хамрагдсан
Увс аймаг					
46	Улиастай	Бага сургууль	80	15	2017-2019 онд 1-5 дугаар ангийн 1 бүлэгт 1-9 хүүхэд хамрагдсан байна. 2019 онд 3-р ангид хүүхэд хамрагдаагүй.
47	Тариалан	2 дугаар сургууль	120	49	1-5 дугаар ангийн 1 бүлэгт 7-15 хүүхэд хамрагдсан
Ховд аймаг					
48	Ховд	Ховд их сургуулийн харьяа ахлах сургууль	150	77	Хүчин чадлын 63.0 хувь ашиглалтгүй
49	Дуут	Бүрэн дунд сургууль	320	202	Хүчин чадлын 36.0 хувь ашиглалтгүй
50	Чандмань	Бүрэн дунд сургууль	724	441	Хүчин чадлын 40.0 хувь ашиглалтгүй
Хөвсгөл аймаг					
51	Бүрэнтогтох	Бүрэнхаан багийн бага сургууль	50	38	1-5 дугаар ангид 2017-2019 онд 3-10 хүүхэд суралцсан
52	Бүрэнтогтох	Зүрх багийн бага сургууль	100	56	1-5 дугаар ангид 2017-2019 онд 9-15 хүүхэд суралцсан
Хэнтий аймаг					
53	Хэрлэнбаян-Улаан	Дунд сургуулийн	100	60	2017-2019 онд 6-9 дүгээр ангид 4-7 хүүхэд хамрагдсан бол 8-р ангид хүүхэд хамрагдаагүй байна.
54	Батширээт	Дунд сургууль	560	349	Хүчин чадлын 41.0 хувь ашиглалтгүй
55	Баянхутаг	Дунд сургууль	240	81	Хүчин чадлын 66.0 хувь ашиглалтгүй
56	Гурванбаян	Дунд сургууль	340	108	Хүчин чадлын 69.0 хувь ашиглалтгүй
Дархан-Уул аймаг					
57	Дархан	11 дүгээр сургууль	564	274	Хүчин чадлын 53.0 хувь ашиглалтгүй
58	Дархан	ШУТИС-ийн харьяа сургууль	350	131	Хүчин чадлын 66.0 хувь ашиглалтгүй
59	Дархан	ХААИС-ийн харьяа лицей сургууль	350	56	Хүчин чадлын 85.0 хувь ашиглалтгүй
60	Дархан	12 дугаар сургуулийн /Энэрэл цогцолбор/	500	225	Хүчин чадлын 54.0 хувь ашиглалтгүй
Орхон аймаг					
61	Баян-Өндөр	Технологийн сургуулийн харьяа	320	83	Хүчин чадлын 72.0 хувь ашиглалтгүй
62	Баян-Өндөр	16 дугаар сургууль	720	572	Хүчин чадлын 47.0 хувь ашиглалтгүй

Эх сурвалж: БШУЯ

Хавсралт 9

Хүснэгт 36. Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ (мян.төгрөгөөр)

Байршил	Сургуулийн ангилал	Багшийн цалин			Ажил олгогчийн төлөх шимтгэл			Бусад хувьсах зардал	Нийт хувьсах зардал		
		Бага анги	Дунд анги	Ахлах анги	Бага анги	Дунд анги	Ахлах анги		Бага анги	Дунд анги	Ахлах анги
Аймгийн төвөөс бусад сум	Багийн бага сургууль	576.8	-	-	63.5	-	-	42.8	683.1	-	-
	Суурь боловсролын сургууль	309.0	481.0	-	34.0	52.9	-	21.9	364.9	555.9	-
	Бүрэн дунд боловсролын сургууль	288.3	417.0	438.8	31.7	45.9	48.3	14.6	334.6	477.5	501.7
Аймгийн төвийн болон нийслэлийн захын дүүрэгт	Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургууль	271.6	392.7	400.4	29.9	43.2	44.0	13.9	315.4	449.8	458.4
Нийслэл	Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургууль	246.7	355.1	373.6	27.1	39.1	41.1	13.1	286.9	407.3	427.8

Эх сурвалж: Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоол

Хавсралт 10

Хүснэгт 37. Төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ (мянган төгрөгөөр)

Нэг хичээлийн жилийн сургалтын төлбөрийн хэмжээ	Байршил	Нормативт зардлын хэмжээ		
		Бага анги	Дунд анги	Ахлах анги
Төлбөргүй болон 5,000,000.0 төгрөг хүртэлх төлбөртэй	Орон нутгийн	316.4	450.8	459.3
	Нийслэлийн	288.9	409.3	429.8
5,000,001.0-ээс 10,000,000.0 төгрөг хүртэлх төлбөртэй	Орон нутгийн	189.8	270.5	275.6
	Нийслэлийн	173.3	245.6	257.9
10,000,001.0 төгрөгөөс дээш төлбөртэй	Орон нутгийн	94.9	132.2	137.8
	Нийслэлийн	86.7	122.8	128.9

Эх сурвалж: Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоол

Хавсралт 11

Хүснэгт 38. Төрийн бус өмчийн сургуулиудад олгосон санхүүжилт /сая төгрөг/

№	Байршил	2017 он		2018 он		2019 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Архангай аймаг	109.9	109.9	57.1	57.1	63.1	63.1
2	Баян-Өлгий аймаг	1,264.9	1,265.0	1,069.9	1,069.9	1002.3	1002.3
3	Баянхонгор аймаг	24.4	24.4	6.1	6.1	102.6	102.6
4	Говь-Алтай аймаг	42.0	42.0	43.9	43.4	46.03	45.99
5	Дорнод аймаг	362.6	362.6	286.4	286.4	383.3	383.3
6	Өвөрхангай аймаг	47.7	47.7	44.2	44.2	-	-
7	Сэлэнгэ аймаг	15.1	15.1	156.3	156.3	173.9	173.9
8	Төв аймаг	14.9	14.9	14.9	14.9	24.7	24.7
9	Увс аймаг	57.7	57.7	29.0	29.0	50.8	50.8
10	Хөвсгөл аймаг	116.3	116.3	120.8	120.8	112.9	112.9
11	Хэнтий аймаг	71.4	71.4	88.7	88.7	101.9	101.9
12	Дархан-Уул аймаг	650.5	650.5	650.5	650.5	862.7	862.7
13	Орхон аймаг	549.6	549.5	606.7	606.3	707.6	707.6
14	Багануур дүүрэг	54.1	54.1	57.3	57.3	60.9	60.9
15	Баянгол дүүрэг	1,331.8	1,331.8	1,471.9	1,470.6	1,539.0	1,502.4
16	Баянзүрх дүүрэг	2,823.0	2,823.0	3,232.9	3,205.6	3,752.6	3,705.6
17	Налайх дүүрэг	49.3	49.3	59.3	59.3	67.8	67.8
18	Сонгинохайрхан дүүрэг	501.1	501.1	493.7	493.7	472.8	472.8
19	Сүхбаатар дүүрэг	3,039.1	3,021.6	3,513.3	2,852.7	3,285.4	3,201.2
20	Хан-Уул дүүрэг	988.9	988.9	1,262.1	1,262.1	1,756.2	1,756.2
21	Чингэлтэй дүүрэг	568.1	568.1	623.9	623.9	622.9	622.9
	Нийт	12,682.4	12,664.9	13,888.9	13,198.7	15,189.4	15,021.6

Эх сурвалж: Сангийн яам

Хавсралт 12

Хүснэгт 39. Боловсролын салбарт батлагдсан төсөө /сая.төг/

Тухайн оны төсвийн тухай хууль	ДНБ	БШУС-ын багц	ДНБ-нд эзлэх хувь	Урсгал зардал	Үүнээс: ЕБС-ийн тусгай зориулалтын шилжүүлэг	Урсгал зардалд эзлэх хувь	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын дүн
2017	27,876,300.0	1,322,550.3	4.7	1,078,729.9	604,842.8	45.7	104,310.2
2018	32,411,200.0	1,632,349.0	5.0	1,136,445.0	619,730.0	38.0	262,817.6
2019	36,897,600.0	1,863,563.9	5.1	1,192,310.2	653,733.3	35.1	616,453.7

Эх сурвалж: Төсвийн тухай хуулиуд

Хавсралт 13

Хүснэгт 40. Багш бэлтгэж буй их, дээд сургуулиуд

№	Сургуулийн нэр	2017 он			2018 он			2019 он		
		Суралцагчид	шинээр элссэн	төгсөх ангид	Суралцагчид	шинээр элссэн	төгсөх ангид	Суралцагчид	шинээр элссэн	төгсөх ангид
Төрийн өмчийн сургууль		9,956	2,983	2,383	10,985	3,072	2,517	11,102	888	5,562
1	МУБИС /Монгол улсын боловсролын их сургууль/	8,096	2,536	1,854	8,430	2,428	1,916	8,890	764	4,497
2	Хөвд Их сургууль	748	235	266	677	227	206	814	80	446
3	МУИС /Монгол улсын их сургууль/	494	12	111	625	16	123	752	7	268
4	МУБИС Архангай	-	-	-	580	237	130	-	-	-
5	СУИС /Соёл урлагийн их сургууль/	424	130	85	433	104	83	241	23	50
6	Дорнод их сургууль	162	38	67	144	44	34	364	4	296
7	МУИС Орхон	-	-	-	59	-	25	-	-	-
8	ХААИС /Хөдөө аж ахуйн их сургууль/	32	32		25	8	-	1	-	1
9	Монгол улсын консерватори	-	-	-	12	8	-	36	10	
10	ШУТИС /Шинжлэх ухаан технологийн их сургууль/	-	-	-	-	-	-	4	-	4

Төрийн бус сургууль		3,251	1,099	957	3,397	1,054	663	3,166	636	1,346
1	Үндэсний биеийн тамирын дээд сургууль	420	186	67	557	198	152	586	237	232
2	Хүмүүнлэгийн ухааны их сургууль	540	235	130	387	82	68	316	28	111
3	МУИС /Монголын үндэсний их сургууль/	267	105	38	393	154	28	220	9	72
4	Идэр их сургууль	219	87	44	228	72	23	214	120	66
5	Мон-Алтиус дээд сургууль	157	42	36	169	45	38	198	16	106
6	Дархан дээд сургууль	-	-	-	157	37	38	196	5	78
7	Гурван-Эрдэнэ багшийн дээд сургууль	233	37	138	177	4	13	157	6	97
8	Орхон их сургууль	71	13	46	53	6	35	148	12	126
9	Газарчин дээд сургууль	121	25	52	141	49	42	134	29	65
10	Олон улсын Улаанбаатарын их сургууль	121	49	21	108	26	19	101	59	22
11	Зохиомж дээд сургууль	91	30	34	98	35	39	98	-	91
12	Аварга дээд сургууль	159	55	42	136	43	22	91	15	20
13	Хүмүүн-Дархан	72	9	31	88	27	31	91	17	21
14	Хэл иргэншлийн дээд сургууль	90	44	13	85	28	5	78	15	18
15	Эм Ай Ю дээд сургууль	85	31	8	112	40	24	69	11	50
16	Рояль олон улсын дээд сургууль	-	-	-	-	-	-	68	1	18
17	Маргад дээд сургууль	32	5	17	37	16	5	67	3	40
18	Улаанбаатар эрдэм их сургууль	46	-	-	58	12	15	65	14	22
19	Хангай дээд сургууль	22	4	5	31	9	10	49	-	37
20	ИЗОУИС /Их засаг олон улсын их сургууль/	22	22	-	54	37	-	45	8	-
21	Отгонтэнгэр их сургууль	55	31	24	50	34	3	37	16	2
22	Сити их сургууль	32	8	8	24	4	6	33	-	11
23	Этүгэн их сургууль	17	17	-	34	17	-	29	4	-
24	Глобал удирдагч дээд сургууль	16	-	6	6	2	2	25	6	15
25	Чингис хаан дээд сургууль	29	3	21	26	15	7	13	-	11
26	Тэнгэр дээд сургууль	-	-	-	-	-	-	12	-	12
27	Шинэ монгол технологийн дээд сургууль	-	-	-	-	-	-	12	3	-
28	Нийгэм, сэтгэл судлалын дээд сургууль	12	10	-	15	4	-	7	2	1
29	Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билиг дээд сургууль	8	8	-	-	-	-	4	-	-
30	Үндэсний техникийн их сургууль	13	2	6	5	-	2	1	-	1
31	Засагт Хан дээд сургууль	-	-	-	2	-	-	1	-	-
32	Утга зохиол, нийгмийн ажилтны дээд сургууль	6	-	5	1	-	1	1	-	1
33	ХИС-ийн Баян-Өлгий	163	37	74	129	49	17	-	-	-
34	ЭЗҮДС	-	-	-	23	9	5	-	-	-
35	Улаанбаатарын ИС	-	-	-	13	-	13	-	-	-
36	Сэрүүлэг ИС	81	-	70	-	-	-	-	-	-
37	Нийгмийн ухааны ДС	51	4	21	-	-	-	-	-	-
Эх сурвалж: БШУЯ										

Хавсралт 14

Хүснэгт 41 Боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгэгдсэн хичээл сонголтын нэгтгэл

Х анги				XI анги				XII анги			
Хичээлийн нэр	Сонгон үзсэн суралцагчийн тоо			Хичээлийн нэр	Сонгон үзсэн суралцагчийн тоо			Хичээлийн нэр	Сонгон үзсэн суралцагчийн тоо		
	2017 он	2018 он	2019 он		2017 он	2018 он	2019 он		2017 он	2018 он	2019 он
Математик	22089	26833	27597	Математик	14431	20552	26342	Математик	31001	13198	21896
Англи хэл	19179	25731	25260	Англи хэл	11274	16887	22549	Англи хэл	23447	9870	18392
Нийгэм судлал ***	61	33272	21842	Нийгэм судлал	64	20858	19792	Нийгэм судлал	43	10823	19802
Монгол хэл	10979	13838	14777	Физик	6058	7741	9264	Монгол хэл	14100	5653	9483
Физик	10128	13093	11060	Монгол хэл	5495	7565	9805	Физик	11943	5369	8313
Хими	5186	7071	6590	Хими	2999	4476	5512	Хими	6187	3044	5023
Биологи	4471	6042	6193	Биологи	2523	4035	5309	Биологи	5572	2951	4914
Бусад гадаад хэл /Орос, хятад, япон, герман, солонгос .../	2926	4659	4491	Бусад гадаад хэл /Орос, хятад, япон, герман, солонгос .../	1410	1991	2257	Бусад гадаад хэл /Орос, хятад, япон, герман, солонгос .../	1864	1404	2061
Бизнес судлал	1865	2111	1163	Дизайн, зураг зүй	1308	1417	740	Газарзүй	1229	961	1236
Дизайн, зураг зүй	1999	2202	1045	Газарзүй	526	621	824	Монголын түүх	0	361	785
Мэдээллийн технологи	1186	1720	1363	Мэдээллийн технологи	370	558	653	Дизайн, зураг зүй	3192	671	552
Газарзүй	836	1302	912	Бизнес судлал	755	1272	522	Мэдээллийн технологи	371	217	463
Монголын түүх	0	431	620	Түүх	350	393	195	Бизнес судлал	562	370	359
Түүх	648	497	369	Үндэсний бичиг	185	365	146	Түүх	684	152	372
Геометр	121	161	138	Геометр	132	129	131	Үндэсний бичиг	164	180	215
Үндэсний бичиг	251	486	76	Уран зохиол	30	298	180	Уран зохиол	173	78	196

Эх сурвалж: Боловсролын удирдлагын мэдээллийн систем